

Лиахоноа



Зөвхөн Тэр л бидний Аврагч болж чадах байсан, 8-р хуудас

Бид Амилалтаас бие махбодын талаар
ямар үнэнийг мэдэж авдаг вэ?, 14-р хуудас

Бэлгийн хүчирхийллийн дарамтаас
чөлөөлөгдөх нь, 22-р хуудас

Дайснаа таньж мэд: Сатаны дөрвөн
арга барилыг хэрхэн эсэргүүцэх вэ?,
30-р хуудас



Барилгачид Швейцарийн Берн ариун сүмийн барилгын талбай дээр тэмдэг тавив. Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй 1955 оны 9-р сард ариун сүмийг онцгойлон адисалжээ. Энэ бол Хойд Америкаас гадна баригдсан анхны ариун сүм байсан бөгөөд энд анх удаа англи хэлнээс өөр хэл дээр ёслолуудыг танилцуулжээ.

Гэрэл зургийг Сүмийн түүхийн номын сангийн зөвшөөрлөөр нийтлэв



ЗАХИАСУУД

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Зөвт хүн итгэлээр амьдарна
Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф
- 7** Айлчлагч багшийн захиас бичиг: Санваарын тангараг ба гэрээ



ХАВТСАН ДЭЭР
Гурван Мариа булшин дээр,
Виллиам-Адольф Бөүжэрэү

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 8** Аврагчийн Цагаатгал бол жинхэнэ Христийн шашны үндэс суурь
Ахлагч Роберт Д.Хэйлс
Тэр амьд учраас бүх хүн дахин амьдрах болно.
- 14** Есүс Христийн амилалт ба бие махбодын талаарх үнэн
Дэвид А.Эдвардс
Есүс Христийн амилалт бие махбодын мөнхийн болоод ариун нандин мөн чанарын тухай чухал үнэнийг заадаг.
- 22** Найдвар, эдгэрэл тийш хөтлөх гүүр
Нанон Тэллий
Та болон таны хайртай хүн бэлгийн хүчирхийлэл гэх хор хөнөөлтэй, жигшүүрт зүйлд өртсөний дараа хэрхэн амар амгалан байж, итгэл найдвар тээн, эдгэрэх боломжтой вэ?

- 28** Гэр бүлийн хуучин зургийн цомог: Гэр бүлийн түүхийн хүч
Амнэрис Пускасу
Эцэг өвгөдийн минь түүх, амьдрал намайг хүчирхэг-жүүлсээр байна.
- 30** Дайн үргэлжилсээр
Ахлагч Ларри Р.Лорэнс
Ахлагч Лорэнс Сатаны дөрвөн арга барил болон тэдгээрийг хэрхэн эсэргүүцэх талаар хуваалцав.

БУСАД ӨГҮҮЛЭЛ

- 20** Дуу хөгжим: Түүнд, Түүнд ирэгтүн
Стивэн К.Жөүнс, Майкл Ф.Мүүди
- 38** Итгэлийн хөрөг:
Скайдрайт Бокума
- 40** Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой
- 80** Биднийг дахин уулзах хүртэл:
Бурханы хүч
Ахлагч Брус Р.Макконки



44 Патриархын адислалаа ойлгох нь

Аллий Арнэлл, Маргарэт Виллдэн
Патриархын адислал хувь хүн бүрийн туулах замын газрын зурагтай адил. Өөрсдийгөө залуурдахад туслах зарим зөвлөгөөг дурдав.

48 Шинэ аялалд бэлдэх нь

Карина Мартинс Пэрэйра Коррэйа дэ Лима
Гэр бүлтэй болно гэхээс төрөх эргэлзээ, айдас намайг зовоож байв. Би амар амгаланг хэрхэн олж авах вэ?

Энэ дугаарт нуусан Лиахонаг олж чадах эсэхээ хараарай. Сэжүүр: Энэ гэрэлтдэг үү?



50 Би хэрхэн оюун санаа, зүрх сэтгэлдээ судлах вэ?
Асуултынхаа хариултыг олох, судрыг илүү сайн ойлгох Их Эзэний арга зам юу вэ?

52 Сайн мэдээг судлах өөрийн гэсэн арга барилтай бол
Сайн мэдээг судлахдаа хэрхэн илүү ихийг олж авч болох талаар суралц.

56 Сүмийн удирдагчдын хариулт: Жинхэнэ амар амгаланг хэрхэн олж авах вэ?
Ахлагч Квинтин Л.Күк

57 Мартагдсан ном, эргэн санасан гэрчлэл
Абигэйл Б.Фэррэр
Надаас Сүмийн талаар хуваалцахыг хүссэн яг тэр өдөр би Сүмийн материалаа авч явахдаа мартсан байв. Миний хэлсэн энгийн үгс хангалттай байх болов уу?

58 Тэд Түүнийг харсан
Та амилсан Аврагчийн тухай эдгээр гэрчлэлийг уншаад, хэрхэн Түүний амилалтын гэрч бас байж болохоо хар.

62 Бидний орон зай

63 Зурагт хуудас: Урагшаа, Христийн цэргүүд ээ

64 Асуулт, хариулт
Бурхан залбирлыг маань сонсож байгаа гэдгийг би хэрхэн мэдэх вэ?



66 Андрей ба муухай үг
Жюли К.Доналдсон
Ганицхан муухай үг сэтгэлд сэв суулгахгүй байлгүй дээ, тийм ээ?

68 Төлөөлөгчдийн хариулт: Би гэр бүлийнхэндээ хүчтэй байхад нь хэрхэн тусалж чадах вэ?
Ахлагч Дэвид А.Бэднар

69 Өдөр бүр ариун сүмд ороход бэлд
Жой Д.Жонс
Жонс эгч хэрхэн чухал зорилго тавьсныг олж мэд.

70 Стар од мэт гялалзана
Жэйн Макбрайд
Стар анх удаа Хүүхдийн хэсэгт очих гэж байгаадаа сэтгэл нь хөдөлж байв. Тэр найзтай болох болов уу?

72 Гэрэл нь бай!
Элизабэт Пинбороу
Сайн найз байх найман арга

73 Сүмийн түүхэн дэх онцгой хүмүүс: Сайн мэдээг түгээх нь

74 Есүсийн тухай бодох нь
Линдси Таннэр
Миа ариун ёслолын талаар суралцлаа.

76 Есүсийн тухай түүх: Есүс Христ ариун ёслолыг бидэнд өгсөн
Ким Уэбб Райд

79 Христийн амилсны баярын сараана цэцэгс

2017 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР, 18, №2 ЛИАХОНА 14444 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,
Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Рассэлл М.Нэлсон,
Даллин Х.Өүкс, М.Рассэлл Баллард, Роберт Д.Хэйлс,
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк,
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд
А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд

Эрхлэгч: Иосеф В.Ситати

Туслах редакторууд: Рэндэлл К.Бэннэтт, Кэрл Ф.Макконки

Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Жийн Б.Бингхам, Бага Лигранд
Р.Куртис, Кристоффэл Голдэн, Даглас Д.Холмэс, Эрик
В.Көпишкэ, Ларри Р.Лорэнс, Кэрл М.Стэфэнс

Удирдах захирал: Питэр Ф.Эванс

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Крэмилда Амарал

Редакцийн баг: Бэтани Бартокомэв, Бриттани Бийти, Дэвид
Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фуллэр,
Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жилл Хакин, Шарлотт
Ларкэбэл, Майкл Р.Моррис, Салли Жонсон Оджерк, Жошуа
Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни, Минди Аннэ
Сэлу, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Талл Р.Петрссон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрюс, Фэй
П.Андрус, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Дэвид Грийн,
Коллин Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан Лофгрэн,
Скотт М.Моой, Марк В.Робисон, Рачэл Смит, Брэд Тиэри,
К.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун

Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Глэн Адэйр, Коинни Вауторп Бриж, Жюли
Бардэтт, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Гэйл Тэйт
Раффэрти, Дэрэк Ричардсон

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой К.Вэллинга
Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон
үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон
тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернет вэбсайт
liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "заллагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга,
украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад
(хялбаршуулсан), чех, швед, эстонч, япон хэлээр нийтлэгддэг.
(Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2017 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн тухай мэдээлэл: Өөрөөр заагаагүй
бол хувь хүмүүс *Лиахона* сэтгүүлээс арилжааны бус, хувьдаа
(мөн Сүмийн дуудлагат ажилд) ашиглах зорилгоор материал
хувиран авч болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй.
Үзүүлэнгийн материалыг хэрэв зураг чимэглэлийн тухайд
ямар нэг хязгаарлалт тогтоосон бол хуулбарлаж болохгүй.
Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар
хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St.,
FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон
шудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

April 2017 Vol. 18 No. 2. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake
City, Utah. Sixty days' notice required for change of address.
Include address label from a recent issue; old and new address
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt
Lake Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаа

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагааг оруулав.
Доор хоёр жишээ өгөгдсөн болно.



"Тэд Түүнийг харсан," 58-р хуудас:

Христийн гэрч байна гэдэг нь ямар утга-
тай вэ? Өгүүллгийг гэр бүлийнхэнтэйгээ
уншсаны дараа, Христийг өөрийн биеэр
хараагүй ч гэсэн гэрчлэх арга замын
талаар ярилцаж болно. Та нутаг дэвсгэр-
тээ байгаа дүрвэгчдэд үйлчлэх, судраас
судалж байхдаа Аврагчийн амьдралын
талаар олж мэдэх, хосуудад ариун сүмд
орох боломж олгохын тулд хүүхдийг нь
харж өгөх, ядарч байгаа найздаа туслах
зэрэг Аврагчтай илүү ойртуулах арга
замын талаар бодож болно. Түүнчлэн та
mormon.org/easter-ээс видео бичлэг үзэн,
Христийн тухай болон Түүний амилалт
бидний амьдралд ямар ач холбогдолтой
болох талаар тунгаан бодож болно.

"Ариун сүмд ороход өдөр бүр бэлтгэ,"

69-р хуудас: Жой Д.Жонс эгч ариун сүмийг
амьдралдаа эн тэргүүнд тавьж, ариун сүмд
ороход бэлтгэхэд туслах гэр бүлийн түүхийн
ажлыг хийх нь ямар ач холбогдолтой боло-
хыг сануулав. Гэр бүлийн үдшээ "гэр бүлийн
түүх ба ариун сүмийн үдэш" болгох талаар
бодож үз. Та нэр хэрхэн индексжүүлэх мөн
гэр бүлийн мэдээллийг хэрхэн хайх эсвэл
ариун сүмийн ёслолууд ямар ач холбогдол-
той болох талаар ярилцаж, дэлхийн өнцөг
булан бүрд байгаа ариун сүмийн зургуудыг
харж болно. Хэрэв та ариун сүмийн ойрол-
цоо амьдардаг бол ариун сүмийн талбай
дээр очин, ариун сүм биднийг Тэнгэрлэг
Эцэгт хэрхэн илүү ойртуулж, Түүний хайрыг
мэдрэхэд тусалдаг талаар ярилцаж болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО

Лиахона болон Сүмийн бусад материал languages.lds.org дээр олон хэлээр байгаа.
Найзууд болон гэр бүлтэйгээ хуваалцаж болох сүнслэг захиас, гэр бүлийн үдшийн
санаа, материал зэргийг олж мэдэхийг хүсвэл [facebook.com/liahona.magazine](https://www.facebook.com/liahona.magazine)
(англи, португаль, испани хэл дээр байгаа) хуудас руу зочилж орно уу.

ЭНЭХҮҮ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллгийн эхний хуудсыг зааж байгаа.

Амар амгалан, 48, 56,
62, 66

Амилалт, 8, 14, 58, 76, 79

Ариун Сүнс, 50

**Ариун сүмд шүтэн
бишрэх,** 69

Ариун ёслол, 74, 76

Бие, 14

Бэлгийн хүчирхийлэл, 20

Гэр бүл, 28, 42, 48, 68

Гэр бүлийн түүх, 28

Гэрчлэл, 38, 50, 57, 58

Гэрээнүүд, 7

Есүс Христ, 8, 14, 30, 56,
58, 74, 76, 79

Жишээ, 72

Залбирал, 41, 62, 64

Зориг, 40, 57, 63

Итгэл, 4, 38, 41, 48, 80

Мэдлэг, 50, 52

Мөнх амьдрал, 8, 14

Найдвар, 22, 48

Нөхөрлөл, 70, 72

Патриархын адислал, 44

Санваар, 7, 80

Судраас судлах, 43, 52, 57

Сүмийн түүх, 73

Сүнслэг хүч чадал, 4, 30,
63, 80

Тэнгэр дэх дайн, 30

Уруу таталт, 30, 63

Үйлчлэл, 4, 42, 68

Христийн амилсны баяр,
14, 58, 76, 79

Хэл, 40, 66

Цагаатгал, 8, 22, 74, 76

Эдгээлт, 22



Тэргүүн Зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх
Ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф

ЗӨВТ ХҮН ИТГЭЛЭЭР АМЬДАРНА

Рабби ба саван хийгч

Бурханд итгэдэггүй саван хийгчийн тухай эртний еврей үлгэр байдаг. Нэг өдөр тэрээр раббитай хамт алхаж явахдаа “Миний ойлгохгүй нэг зүйл байна. Бид хэдэн мянган жилийн турш шашин шүтсэн. Гэхдээ хаашаа ч харсан хилэнц, авлига, луйвар, шударга бус байдал, зовлон зүдгүүр, өлсгөлөн, хүчирхийлэл байна. Тэгэхлээр шашин дэлхий ертөнцийг огтхон ч сайжруулаагүй бололтой. Тиймээс би танаас шашны чухам юу нь сайн юм бэ? гэж асууя” гэжээ.

Рабби хэсэг хугацаанд юу ч хэлсэнгүй, саван хийгчтэй хамт цааш явав. Эцэст нь тэд тоосонд дарагдсан хүүхдүүд шороогоор тоглож байсан тоглоомын газарт иржээ.

Рабби: “Надад ойлгохгүй нэг зүйл байна. Энэ хүүхдүүдийг хар даа. Бидэнд олон мянган жилийн турш саван байсан ч энэ хүүхдүүд хиртэй заваан хэвээр л байна. Саван байх нь юунд сайн юм бэ?” гэж хэлэв.

Гэтэл саван хийгч: “Рабби, хүүхдүүд бохир заваан байгаад саванг буруутгах нь шударга бус. Саванг хэрэглэж байж л ашиг тусыг нь авна шүү дээ” хэмээн хэлтэл

Рабби инээмсэглэн, “Яг тийм” хэмээн хариулав.

Бид хэрхэн амьдрах ёстой вэ?

Төлөөлөгч Паул Хуучин Гэрээний бошиглогчоос эш татан, итгэгч байх гэдэг нь ямар утга учиртай болохыг “Зөвт хүн итгэлээр амьдарна” (Ром 1:17) хэмээн тоймлон бичжээ.

Бид энэ энгийн тайлбараас хэврэг, үр ашиггүй шашин ба амьдралыг өөрчлөх хүчтэй шашин хоёрын хоорондын ялгааг ойлгож болох юм.

Гэхдээ бид итгэлээр амьдрах гэдэг нь ямар утга учиртай үг болохыг ойлгохын тулд эхлээд итгэл гэж юу болохыг ойлгосон байх ёстой.

Итгэл нь үнэмшлээс илүү болой. Энэ бол Бурханд бүрэн итгэж найдахын зэрэгцээ үйлдэхийг хэлнэ.

Энэ нь хүслээс илүү.

Мөн налайж суугаад, толгой дохин, зөвшөөрч байна гэж хэлэхээс ч илүү зүйл юм. Бид “Зөвт хүн *итгэлээр амьдарна*” гэдгийг итгэлээрээ хөтлүүлэн, удирдуулдаг гэсэн утгаар хэлж байгаа юм. Бид итгэлтэйгээ холбоотой арга замаар буюу муйхраар сүсэглэн дуулгавартай байх гэсэндээ биш, харин Бурхандаа итгэж, Түүнийг чин сэтгэлээсээ хайрладаг учраас мөн Өөрийн хүүхдүүдэд илчилсэн үнэлж баршгүй мэргэн ухааных нь төлөө *үйлддэг*.

Иймээс итгэлийг үйлдэл дагалдаж байх ёстой бөгөөд хэрэв үйлсгүй бол итгэл өөрөө үхмэл юм (Иаков 2:17-г үзнэ үү). Энэ бол итгэл огтхон ч биш. Үүнд дэлхийг байтугай ганц хүнийг өөрчлөх хүч ч байхгүй.

Итгэлтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүс төгс харж, сайн ойлгох боломжгүй ороо бусгаа цаг үед ч мөн эргэлзээ, саад бэрхшээл тулгарах үед ч энэрэнгүй Тэнгэрлэг Эцэгтэй итгэж найддаг.

Итгэлтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүс шавийн замаар чин сэтгэлээсээ алхан, хайрт Аврагч Есүс Христийнхээ үлгэр жишээг дагах гэж хичээдэг. Итгэл бидэнд сэдэл төрүүлж, бидний зүрх сэтгэлийг гарцаагүй тэнгэр өөд чиглүүлэн, эргэн тойрныхоо хүмүүст тусламжийн гараа сунгаж, урам зориг өгч, адислахад урамшуулан дэмждэг.

Үйлдэл хийхгүй бол шашин нь хайрцган дотроо байгаа саван лугаа адил билээ. Түүнд гайхамшигтай чадавх байж болох ч бодит байдалд зорилгоо биелүүлэхгүй л бол аливаа зүйлийг өөрчлөх өчүүхэн төдий ч хүч байхгүй. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ бол үйлдэх сайн мэдээ мөн. Есүс Христийн Сүм жинхэнэ шашин нь итгэл, найдвар, энэрлийн захиас төдийгүй ойр тойрныхондоо сүнслэг хийгээд материалаг байдлаар тусалдаг гэдгийг заадаг.



Ерөнхийлөгч Угдорф охин Энжитэйгээ хамт Грекийн Афины ойролцоох дүрвэгчдийн сууринд зочлов.

Хэдэн сарын өмнө би эхнэр Харриэтэйгээ хамт хэдэн хүүхдээ аваад, Газрын дундад тэнгис рүү гэр бүлээрээ аялсан юм. Бид дүрвэгчдийн зарим суурин дээр очин, дайнд нэрвэгдсэн орнуудаас ирсэн гэр бүлүүдтэй уулзсан. Тэр хүмүүс манай шашных биш ч бидний ахан дүүс байсан бөгөөд тэдэнд тусламж нэн яаралтай хэрэгтэй байлаа. Манай Сүмийн гишүүдийн бодит итгэл эргэн тойрондоо байгаа тусламж хэрэгтэй хүмүүст шашин шүтлэг, яс үндэс, боловсрол зэргийг харгалзахгүйгээр хэрхэн тусалж, дэмжин, найдвар төрүүлж байгааг нүдээрээ харсан маань биднийг ихэд догдуулсан юм.

Байнгын үйлдэл дагуулсан итгэл нь зүрх сэтгэлийг сайхан сэтгэлээр, оюун санааг мэргэн ухаан, ойлголтоор, мөн бодгалийг амар амгалан, хайраар дүүргэдэг.

Бид итгэлээрээ өөрсдийгөө болон

эргэн тойрны хүмүүсийнхээ аль алиныг адисалж, зөв шударгаар нөлөөлөх боломжтой.

Бидний итгэл дэлхийг сайн сайхан, амар амгалангаар мөн дүүргэж чадна.

Түүнчлэн итгэл маань үзэн ядалтыг хайр, дайсныг найз нөхөд

болгон өөрчилж чадна.

Тиймээс зөвт хүмүүс итгэлээр үйлдэж мөн Бурханд найдан, Түүний замаар алхаж амьдардаг.

Ийм л итгэл хувь хүн, гэр бүл, үндэстэн ястан, дэлхийг өөрчилж чадна. ■

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхийлөгч Угдорф итгэл бол зүгээр нэг итгэл үнэмшлийг илэрхийлэх төдий зүйл биш гэдгийг тайлбарласан. Тэнгэрлэг Эцэгт болон Их Эзэн Есүс Христэд итгэх жинхэнэ итгэл нь үйлдэхийг шаарддаг бөгөөд итгэлээр амьдрах нь бусдын амьдрал, гэр орныг өөрчлөх хүчийг өгдөг. Та итгэлтэй амьдарснаар ирэх адислал, хүчийг харж байсан тохиолдлыг өөрийн туршлагаас эсвэл бусдаас харж байсан тухай хуваалцахад заадаг хүмүүсээ урьж болно. Тэднийг сайн мэдээний дагуу хэрхэн илүү сайн амьдарч болох талаар удирдамж хүсэн залбирахад урамшуулан дэмж.

Бусдад итгэлтэй үйлчлэх нь

Ерөнхийлөгч Угдорф бидний Бурханд итгэх итгэлийг “үйлдэл дагалдаж” байх ёстой гэж хэлсэн байдаг. Бидний “байнгын үйлдэл дагуулсан итгэл . . . бодгалийг амар амгалан, хайраар дүүргэдэг” хэмээн тайлбарласан. Бид энэхүү адислалын амлалтыг хүлээн авснаар өөрчлөлтийг авчирч мөн цаг зав гарган итгэл дүүрэн үйлчлэх юм бол үүнийг амьдралдаа харж чадна. Та өглөө бүр бусдад үйлчлэхэд туслахыг Их Эзэнээс гуйн залбирч болно. Жишээлбэл: ах, эгч дүүсийнхээ аль нэгнийх нь гэрийн ажилд туслах юм уу найзыгаа магтаж сайшаах хэрэгтэй байгаа эсэхийг харуулахыг Түүнээс хүсэж болно. Тэгээд өдөөлт хүлээн аваад, үүнийхээ дагуу үйлд! Хэрэв та нар эдгээр залбирал болон үйлчлэлийг дадал хэвшил болгож чадвал таны итгэлтэй, тууштай үйлдэл өөрийн тань болон бусдын амьдралыг адислах болно. Ерөнхийлөгч Угдорф та нар “хувь хүн, гэр бүл, үндэстэн ястан, дэлхийг өөрчилж чадна” гэж амласан.




ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Итгэл хүлээх

Энэ үйл ажиллагааг найзтайгаа хамт хий. Та тэдний өгсөн удирдамжинд итгэж, анхааралтай дагах хэрэгтэй.

Гартаа үзэг эсвэл харандаа бариад, нүдээ ань. Найзаараа энэ нүүрний чухам хаана нүд, хамар, ам, үс зурахыг хэлүүл. Тэгээд нүдээ нээгээд хар. Ямар болсон байна вэ? Та нүүрийг будаад, дахин зурж тоглож болно.

Заримдаа заавар дагах хэцүү. Гэхдээ Ариун Сүнснийг сонсож, Тэнгэрлэг Эцэгийг дагах гэж хичээх юм бол Тэр бидэнд тусална. Бид Түүнд үргэлж итгэж болно.



Санваарын тангараг ба гэрээ

Энэ материалыг залбирч судлаад, юуг хуваалцахаа мэдэхийн тулд сүнслэг өдөөлт эрэлхийл. Халамжийн нийгэмлэгийн зорилгыг ойлгох нь Бурханы охидыг мөнх амьдралын адислалуудад хэрхэн бэлтгэх вэ?

Бид эгч нарын хувьд санваарын тангараг ба гэрээг хувь хүний талаасаа ямар холбоотой болохыг ойлгох тусам санваарын адислал, амлалтуудыг төдий чинээ хүлээн авах болно.

“Их Эзэнтэй ариун гэрээ хийж, тэрхүү гэрээгээ хүндэлдэг хүн бүр хувийн илчлэлт хүлээн аван, тэнгэр элчүүдийн үйлчлэлээр адислагдаж, Бурхантай холбогдон, сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авч мөн эцэст нь Есүс Христтэй хамт Эцэгт байгаа бүгдийн өв залгамжлагчид болох эрхтэй”¹ хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард хэлжээ.

Санваарын тангараг ба гэрээний адислал, амлалтууд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд хамаатай. Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөх асан Шэри Л.Дью эгч: “Их Эзэний өргөөний хамгийн дээд түвшинд санваарын



Итгэл
гэр бүл
халамж

ёслолуудын бүрэн байдлыг зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүн хоёул байж хүлээн авах боломжтой”² хэмээн хэлсэн.

Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Линда К.Бертон эгч: “би та бүхнийг Сургаал ба Гэрээ 84:33–44 дээр байдаг санваарын тангараг ба гэрээг чээжлээрэй хэмээн урьж байна. Тэгэх юм бол Ариун Сүнс санваарын тухай ойлголтыг тань тэлж, гайхамшигт арга замаар сүнслэгээр өдөөж, өргөн дэмжих болно гэдгийг амлаж байна”³ гэж хэлжээ.

Иосеф Смитийн Халамжийн нийгэмлэгт өгсөн заавар нь эмэгтэйчүүдийг “санваарын онцгой эрх, адислал, бэлэгнүүдийг эзэмшихэд” бэлтгэх зорилготой байсан. Үүнийг ариун сүмийн ёслолуудаар дамжуулан гүйцэтгэх боломжтой.

“Ариун сүмийн ёслол[ууд] нь санваарын ёслол хэдий ч шашны албыг эрэгтэй, эмэгтэй хүмүүст өгдөггүй. [Эдгээр ёслол] нь Их Эзэний өөрийн хүмүүс болох эрэгтэй, эмэгтэйчүүдэд өгсөн ‘тэнгэрийн хүчээр хишиг хүртэх болно’ гэсэн амлалтыг биелүүлдэг. [С ба Г 38:32].”⁴

Нэмэлт судар болон мэдээлэл
Сургаал ба Гэрээ 84:19–40;
121:45–46; reliefsociety.lds.org

ЭШЛЭЛҮҮД

1. М.Рассэлл Баллард, “Men and Women and Priesthood Power,” 2014 оны 9-р сар, 36–33.
2. Шэрил Л.Дью, *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 128.
3. Линда К.Бертон, “Санваарын хүч чадал—бүгдэд хүртээмжтэй,” *Ensign*, 2014 оны 6-р сар, 39–40.
4. Gospel Topics, “Joseph Smith’s Teachings about Priesthood, Temple, and Women,” topics.lds.org.



Үүнийг эргэцүүлэн бод

Та санваарын тангараг, гэрээнд амласан адислалыг илүү бүрэн дүүрэн ойлгож, хүртэхийн тулд юу хийж болох вэ?



ГЕСЕМАНИ Ж. КӨРК РИЧАРДС



Арванхоёр Төлөө-
лөгчийн Чуулгын
Ахлагч
Роберт Д.Хэйлс

Аврагчийн Цагаатгал БОЛ ЖИНХЭНЭ ХРИСТИЙН ШАШНЫ ҮНДЭС СУУРЬ

*Бид Есүс Христийн цагаатгагч золиослолын
ачаар бүгд амилж, үхэшгүй мөнх болно.*

Бошиглогч Иосеф Смитээс (1805–1844) “танай шашны тулгуур зарчмууд юу вэ?” гэж асуусан байна. Тэр: “Манай шашны тулгуур зарчим бол Есүс Христ егүүтгэлээр наснаас хальж, оршуулагдаад, гурав дахь өдрөө амилж, тэнгэрт дээш одсон тухай бошиглогч, төлөөлөгчдийн гэрчлэл юм. Ийнхүү манай шашинд холбогдолтой бусад бүх зүйл нь ердөө л эл гэрчлэлийн хавсралтууд юм”¹ хэмээн хариулжээ.

Би бошиглогч Иосефын мэдэгдэл дээр өөрийн дуу хоолойг нэмэх гэсэн юм. Бидний итгэдэг бүх зүйлийн төвд Аврагч ба Түүний цагаатгагч золиослол буюу “Бурханы хүлцэл” (1 Нифай 11:16) байдаг учраас Эцэг Хүүгээ Цагаатгалыг гүйцэлдүүлэхээр дэлхий рүү илгээсэн. Есүс Христийн амьдралын гол зорилго бол цагаатгагч золиослолыг гүйцэлдүүлэх явдал байв. Цагаатгал бол жинхэнэ Христийн шашны үндэс суурь юм.

Яагаад Аврагчийн Цагаатгал Сүм дэх болон бидний амьдрал дахь сайн мэдээний гол зарчим болдог вэ?

Итгэлийн тунхаг 1:3

Итгэлийн тунхгийн гуравт: “Христийн Цагаатгалаар дамжин Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байснаар бүх хүн төрөлхтөн аврагдана гэдэгт бид итгэдэг” гэсэн байна.

“Аврагдана” гэдэг нь энд орсон утгаараа селестиел хаант улс дахь алдар суугийн хамгийн дээд зэрэглэлд хүрэхийг хэлж байгаа. Амилат энэ дэлхийд ирсэн бүх хүнд боломжтой ч хүн нэг бүр мөнх амьдрал, мөнхийн өсөлт хөгжлийн адислалыг бүрэн дүүрэн хүлээн авахын тулд хуулиудыг сахин, ёслолуудыг хүлээн авч, сайн мэдээний гэрээнүүдийг хийх ёстой.

Яагаад зөвхөн Есүс Христ дэлхийн гэм нүглийг цагаатгаж чадсан бэ? Тэрээр бүх шаардлагад нийцэж байв.

Бурхан Түүнийг хайрлаж, Түүнд итгэсэн билээ.

Есүс мөнх бус дэлхийн өмнөх амьдралд Тэнгэрлэг эцэг эхээс төрсөн. Тэрээр Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүдийн ууган нь байв. Тэрбээр бүр эхлэлээс сонгогдож, Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд дуулгавартай байсан. Судруудад Тэнгэрлэг Эцэг Хүүдээ баясдаг байсан тухай олонтоо өгүүлсэн байдаг.

Бид Матайн номоос Есүсийг баптисм хүртсэний дараа Эцэгийнх нь “тэнгэрээс—Энэ бол Миний хайрт Хүү. Түүнд Миний таалал оршдог гэх дуу гарлаа” (Матай 3:17) хэмээн уншдаг.

Харин Лук “Тэгээд үүлнээс—Энэ бол Миний Хүү, Миний сонгосон Нэгэн мөн. Түүнийг сонсогтун гэх дуу гарав” (Лук 9:35) хэмээн цэдэглэжээ.

Түүнчлэн Аврагчийг амилсны дараа Өгөөмөр нутгийн ариун сүмд хүмүүс Эцэгийн “Миний Хайрт Хүүг, миний ихэд таалсан түүнийг болгоогтун” (3 Нифай 11:7) хэмээн айлдахыг сонссон.

Есүсийг Гетсеманийн цэцэрлэгт шаналж байхад Эцэг агуу хайр, энэрлээр Хайрт Хүүгээ тайвшруулж, хүчирхэг-жүүлэхээр тэнгэр элчийг илгээсэн тухай хэсгийг уншихад зүрх сэтгэл минь ихэд догдолдог (Лук 22:43-ыг үзнэ үү).

Есүс сонгох эрхээ ашиглан зарлигуудыг дагахаар шийдсэн

Есүс Христ өөрийн сонголтоор бидний төлөө амиа өгсөн.

Тэнгэр дэх Их зөвлөгөөн дээр “өглөөний хүү” Люсифер (Исаиа 14:12; С ба Г 76:26–27):

“Болгоогтун, би энд байна, намайг илгээгтүн, би таны хүү байх болно, мөн нэг ч бодгаль хаягдахгүйгээр бибээр хүн төрөлхтөнийг гэтэлгэх болно, мөн би үүнийг гарцаагүй хийх болно, иймийн тулд өөрийн алдар хүндэтгэлийг надад өгөгтүн” гэж хэлжээ.

“Гэвч, болгоогтун, миний Хайрт мөн эхлэлээс Сонгогдсон Хайрт Хүү минь, надад хэлэв—Аав аа, таны таалал хэрэгжих болно, мөн алдар суу үүрд таных байх болно” (Мосе 4:1–2; мөн Абрахам 3:27-г үзнэ үү).

Ийнхүү Хүү Эцэгээ болон биднийг гэх агуу хайраараа “Намайг илгээгтүн” хэмээн хэлэв. Тэрээр “Намайг илгээгтүн” хэмээн хэлэхдээ сонгох эрхээ эдэлсэн.

“Би Эцэгээ мэдэхийн адил Эцэг минь намайг мэддэг юм. Би хоньдын төлөө Өөрийн амийг өгнө. . . .

Тиймээс Эцэг намайг хайрладаг. Учир нь Би Өөрийн амийг буцааж авахын тулд амиа өгнө.

Хэн ч Миний амийг Надаас авахгүй. Харин Би Өөрийн санаагаар түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий. Буцааж авах эрх мэдэл ч Надад бий. Энэ тушаалыг Би Эцэгээсээ хүлээн авсан юм” (Иохан 10:15).

Хэрэв Аврагч хүссэн бол тоо томшгүй олон тэнгэр элч Түүнийг загалмай дээрээс шууд Эцэг рүү нь аваачих байсан. Харин Тэр Өөрийгөө бидний төлөө золиослон, мөнх бус дэлхий дэх зорилгоо биелүүлж, эцсээ хүртэл тэвчин, цагаатгагч золиослолыг гүйцээхийн тулд сонгох эрхээ ашигласан.

Есүс дэлхийд ирэхийг хүссэн бөгөөд үүнийг хийх шаардлагыг хангасан нэгэн байв. Тэр дэлхийд ирэхдээ: “Би Өөрийнхөө хүслийг хийхийн тулд бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хийхийн тулд тэнгэрээс бууж ирсэн юм” (Иохан 6:38) хэмээн хэлжээ.

Христийг урьдчилан томилсон

Петр Есүс “ертөнц бүтээгдэхээс өмнө урьдаас мэдэгдсэн” хэмээн заасан (1 Петр 1:19–21-ийг үзнэ үү).

Бүх эрин үеийн бошиглогчид Есүс Христийн ирэхийг болон үйл хэрэг нь юу болохыг урьдчилан хэлсэн. Енох агуу итгэлийнхээ улмаас Аврагчийн төрсөн, нас барсан, дээш одсон болон Хоёр дахь ирэлтийн тухай гайхамшигт үзэгдлийг харсан.



ЭССЭ ХОМО БУДУ ХҮНИЙ ХҮҮГ БОЛЛООГТУН, Ж. КӨРК РИЧАРДС

“Мөн болгоогтун, Енох Хүний Хүүгийн, бүр махан бодь дахь ирэлтийн өдрийг харав; мөн түүний бодгаль баясан хэлэв: Зөв шударгыг үйлдэгчид өргөгдсөн бөлгөө, мөн Хурга дэлхийн сууринаас алагдсан буюу; . . .

Мөн Их Эзэн Еноход хэлэв: Хар, мөн тэрээр харж мөн хүмүүний маягаар загалмайд өргөгдсөн Хүний Хүүт болгоов;

Мөн тэрээр чанга дуу хоолой сонсов; мөн тэнгэр бүрхэгдсэн байлаа; мөн Бурханы бүх бүтээл эмгэнэн гашуудав; мөн дэлхий ёолов; мөн хаднууд цуурсан байв; мөн гэгээнтнүүд босч ирэн мөн алдар суугийн титэмтэйгээр, Хүний Хүүгийн баруун гар талд хүндлэгдсэн байв; . . .

Мөн Хүний Хүү Эцэг өөд дээш ирэхийг Енох болгоов; . . .

Мөнхүү улиран тохиох дор, мянган жилийн туршид дэлхий дээр зөв шударга ёсонд оршин суухаар Хүний Хүү эцсийн өдрүүдэд ирэх тэр өдрийг Енох харав” (Моисе 7:47, 55–56, 59, 65).

Христийг төрөхөөс 75 орчим жилийн өмнө Амюлек “Болгоогтун, би та нарт хэлнэ, Христ хүмүүний үрсийн дунд өөрийн хүмүүсийн зөрчлүүдийг өөртөө авахын тулд ирэхийг, мөн тэр дэлхийн нүглийг цагаатгах болно гэдгийг би мэднэ; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан билээ” (Алма 34:8) хэмээн тунхагласан.

Есүс онцгой чадвартай байсан

Зөвхөн Есүс Христ мөнх бус эх болох Маригаас мэндэлж, Эцэгээсээ амьдралын хүчийг хүлээн авсан учраас цагаатгагч золиослолыг хийх чадалтай байв (Иохан 5:26-г үзнэ үү). Амьдралын хүч байсан болохоор Тэр үхлийг ялж, булшны хүчийг даран, бидний Аврагч, Зуучлагч, Амилалтын Эзэн буюу бид бүхэнд аврал, мөнх байдлыг өгөх арга зам болсон юм. Есүс Христийн цагаатгагч золиослолын ачаар бид бүгд амилж, үхэшгүй мөнх болно.

Есүс өөрийн сонголтоор анхдагч нүглийг цагаатгасан

Итгэлийн тунхгийн хоёрт: “Адамын зөрчлийн улмаас бус, хүмүүн өөрсдийнхөө нүглүүдийн улмаас шийтгүүлэх болно гэдэгт бид итгэдэг” гэжээ.

Бид сонгох эрхээрээ дамжуулан итгэлээ хөгжүүлэх сонголтыг хийж болно. Бид хүчин чармайлт гаргаж байж нүглээ наманчилж чадах ч Цагаатгалгүйгээр наманчлах боломжгүй.



ГОЛГОЛЫН БҮҮДЭГ ӨДӨР Ж. КӨРК РИЧАРДС

Моисе: “Эцэг эхийн нүглүүд хүүхдүүдийнх нь толгой дээр байж үл болох анхны гэмийг Бурханы Хүү цагаатгасан билээ, учир нь тэд дэлхийн сууринаас цэвэр болой хэмээх үг хүмүүсийн дунд эндээс тархсан байлаа” (Моисе 6:54) хэмээн бидэнд заасан.

2 Нифай дээр бидэнд дараах агуу сургамжийг өгсөн байдаг.

“Агуу их Бүтээгчийн нигүүлсэнгүй төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн тулд үхэл бүх хүмүүний дээр улиран ирсэнчлэн амилуулалтын хүч байх ёстой болж, мөн амилуулалт нь хүмүүнд уналтаас шалтгаалан ирэх ёстой нь зайлшгүй; мөн уналт нь зөрчлөөс шалтгаалан ирсэн буюу; мөн хүмүүн уналтанд орсон учир тэд Их Эзэний дэргэдээс зайлуулагдсан билээ.

Иймийн тул, хязгааргүй цагаатгал байх нь зайлшгүй—цагаатгал хязгааргүй байхаас бусдаар бол энэ биеийн ялзрал муудашгүй болж чадахгүй. Иймийн тул, хүмүүний дээр ирсэн эхний шүүлт төгсгөлгүйгээр үлдэх ёстой байсан бөлгөө. Мөн хэрэв тийм аваас, энэ маханбодь дахин хэзээ ч босохгүйгээр ялзран хэвтэж мөн үүний эх болох газарт үйрэх ёстой байсан буюу” (2 Нифай 9:6–7).

Есүс цорын ганц төгс нэгэн байв

Сургаал ба Гэрээн дээр Аврагч: “Эцэг минь, нүгэл үйлдээгүй, таны таалалд нийцсэн түүний зовлон хийгээд үхлийг болгоогтун; мөн Хүүгийнхээ асгарсан цусыг, мөн та өөрөө алдаршихын тулд таны өгсөн, бас түүний цусыг болгоогтун” (С ба Г 45:4) хэмээн айлдсан байдаг.

Есүс цорын ганц гэм нүгэлгүй, төгс нэгэн байв. Хуучин Гэрээнд золиослол нь цусан золиослол гэсэн

утгатай бөгөөд цагаатгагч золиослолыг гүйцэлдүүлэхийн тулд загалмай дээр бидний Их Эзэн Гэтэлгэгчийн хийсэн золиослолыг хэлж байгаа болно. Эртний ариун сүмүүдэд цусан золиослол хийхдээ тахилч нар бузарлуулагүй, бүх талаараа төгс хонийг золионд гаргадаг байжээ. Аврагч цэвэр ариун байсан учраас Түүнийг судруудад “Бурханы хонь” хэмээн нэрлэсэн байдаг (жишээлбэл: Иохан 1:29, 36; 1 Нифай 12:6; 14:10; С ба Г 88:106).

Петр бид “үнэт цусаар, Христийн цус болох гэм зэмгүй бөгөөд толбогүй хурганы цусаар” (1 Петр 1:19) гэтэлгэгдсэн хэмээн заасан.

Есүс дэлхийн гэм нүглийг авсан

Дараах шүлгүүд нь Аврагч Цагаатгалаараа дамжуулан бидний нүглийн төлөөсийг төлсөн гэдгийг тодорхой харуулдаг.

“Бид бүгд, хонь лугаа адил, төөрч одсон; бид нэг бүрээрээ өөрийн замыг хөөж одсон; мөн бид бүгд өөрсдийн алдсуудыг Их Эзэн түүний дээр үүрүүлэх болно” (Мозая 14:6).

“Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм. . .

Учир нь хэрэв бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрүүлэгдсэн юм бол, тэр тусмаа бид Түүний амиар аврагдах болно.

Зөвхөн үүнд ч биш, мөн Бурханы дотор бидний Эзэн Есүс Христээр дамжуулан баярлан хөөрдөг. Түүгээр бид эдүгээ эвлэрлийг авав. . .

Учир нь ганц хүний дуулгаваргүй байдлаас болж олон хүн нүгэлтэн болгогдсоны адил түүнчлэн ганц Хүний дуулгавартай байдлаар олон хүн зөвт болгогдоно (Ром 5:8, 10–11, 19).

“Энэ нь эш үзүүлэгч Исаиагаар бидний сул дорой байдлыг Тэр Өөртөө авч, бидний өвчнийг үүрсэн гэж хэлүүлсэн нь биелэхийн тулд байлаа” (Матай 8:17).

“Гэвч Бурхан Бурхан байхаа болихгүй, мөн нигүүлсэл нь гэмшигчийг шаарддаг, мөн нигүүлсэл нь цагаатгалын учир ирдэг; мөн цагаатгал нь нас барагсдын амилуулалтыг улируулан тохиолгодог; мөн нас барагсдын амилуулалт нь хүмүүнийг Бурханы дэргэд буцаан авчирдаг; мөн ийн тэд, өөрсдийн хийсний дагуу, хууль болоод шударга ёсны дагуу шүүгдэхийн тулд түүний дэргэд байхаар сэргээгддэг. . .

Мөн тийн Бурхан дэлхийн үүслээс бэлтгэгдсэн өөрийн тэр агуу их хийгээд мөнхийн зорилгуудыг авчирдаг. Мөн тийн хүмүүний аврал хийгээд гэтэлгэл нь, мөн түүнчлэн тэдний устгал мөн зовлон нь ирдэг” (Алма 42:23, 26).

Есүс эцсээ хүртэл тэвчсэн

Есүс Христ сорилт бэрхшээл, зовлон зүдгүүр, золиослол, Гетсемани дахь өвчин шаналал болон Голготагийн загалмай дээрх тарчлалыг тэсэн гарсан. Эцэст нь Тэрээр “Гүйцэлдлээ” хэмээн хэлсэн билээ (Иохан 19:30). Тэрээр мөнх бус дэлхий дээрх үйл хэргээ биелүүлэн, эцсээ хүртэл тэвчсэн бөгөөд үүгээр цагаатгагч золиослолыг хийж гүйцэтгэсэн билээ.

Цэцэрлэгт Тэр: “Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог” (Матай 26:39) хэмээн хэлжээ.

Сургаал ба Гэрээ бидэнд:

“Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн тэрхүү зовлон нь—мөн намайг тэрхүү гашуун аяганаас уухгүй, мөн айснаас эргэн буцахад хүргэж болохоор байсан билээ—

Гэсэн хэдий ч, алдар суу нь Эцэгт байх болтугай, мөн бибээр хүртэж мөн хүмүүний үрсийн төлөө өөрийн бэлтгэлүүдийг дуусгасан билээ” (С ба Г 19:18–19) хэмээн заажээ.



ГЭД ТҮҮНИЙГ ХААШЬ НЬ АВАЛМАА ВЭ Ж.КЕРК РИЧАРДС

Есүс Эцэгтээ: “Хий гэж надад өгсөн ажлыг тань гүйцэтгэн Би Таныг газар дээр алдаршуулав” (Иохан 17:4) хэмээн хэлээд,

загалмай дээр “Есүс цууг амсаж—Гүйцэлдлээ! гээд, тэргүүнээ гудайлган сүнсээ даатгав” (Иохан 19:30).

Есүс дэлхийд ирээд, цагаатгагч золиослолыг хийж гүйцэтгэхийн тулд тэнгэрлэг байдлаа хадгалан, эцсээ хүртэл тэвчсэн юм.

Түүнийг ариун ёслолоор дамжуулан дурсан сана

Өнөөдөр бид Аврагчийн гэтэлгэгч золиослолыг Их Эзэний Сүүлчийн зоогийнхоо үеэр төлөөлөгчдөдөө өгсний дагуу, талх, усны бэлгэдлээр—бие, цусыг төлөөлөх тэмдгээр дурсан санадаг.

“Тэр талх авч, талархал өргөөд, тэдэнд хуваан өгөхдөө,—Энэ бол та нарын төлөө өгөх Миний бие мөн. Намайг дурсаж үүнийг үйлд гэж айлдав.

Тийн идэцгээсний дараа Тэр мөн аяга авч,—Энэ нь та нарын төлөө асгагдах Миний цусаар тогтоох шинэ гэрээ юм” (Лук 22:19–20).

Мөн бид Иохан 11:25–26 дээрээс

“Би бол амилалт ба амь мөн. Надад итгэдэг хүн үхэвч амьдарна.

Амьд бөгөөд Надад итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй.

Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн нь энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна. Ертөнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махан бие юм” (Иохан 6:51) хэмээн уншдаг.

“Ертөнцийн амь” гэдэг нь мөнх амьдрал гэсэн утгатай.

Бид өөрсдийгөө болон гэр бүлээ долоо хоног бүр ариун ёслолоос зохистойгоор хүртэж, гэмшсэн зүрх сэтгэлээр гэрээгээ шинэчлэхэд бэлтгэх хэрэгтэй.

Эцэг, Хүү хоёр биднийг хайрладаг

Эцэг Хүүгээ цовдауулж, үзэж туулах ёстой бүх зүйлээ үзэж туулах боломжийг Түүнд олгохын тулд дэлхий рүү илгээсэн. Иоханы номоос бид:

“Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.”

“Хэрэв та нар Намайг мэдсэн бол Миний Эцэгийг ч мөн мэдэх байсан. Одооноос эхлэн та нар Түүнийг мэдэж, Түүнийг харлаа гэлээ” (Иохан 14:6–7) хэмээн уншдаг.

“Бид Бурханыг хайрласан бус, харин Тэр биднийг хайрлаж, бидний нүглийн төлөө Хүүгээ эвлэрүүлэл



ТОМАС БУУ ЭРГЭЛЭ, Ж.КӨРК РИЧАРДС

болгон илгээсэн билээ. Үүнд хайр байгаа юм” (1 Иохан 4:10).

Эвлэрүүлэл гэдэг нь зохицуулах буюу нийцүүлэх гэсэн утгатай.

Дүгнэлт

Дэлхийд ирж, мөнх бус биеийг хүлээн авсан хүн бүр амилах хэдий ч бид хөдөлмөрлөх ёстой бөгөөд итгэлтэй байдал, сонгох эрх, дуулгавартай байдал, наманчлалаараа дамжуулан өргөмжлөлийн адислалыг хүлээн авна. Нигүүлслийг шударга байдалтай хамт тогтоох нь наманчлах боломжийг олгоно.


Бид Есүс Христийг өөрсдийн Гэтэлгэгч хэмээн хүлээн зөвшөөрч, дагах сонголт хийсэн учраас баптисм хүртэн, Түүний нэрийг өөрсөд дээрээ авдаг. Бид бас дуулгавартай байдлын хуулийг хүлээн авдаг. Түүнчлэн Түүнийг дурсан санаж, зарлигуудыг дагана гэж бид амладаг. Мөн бид ариун ёслолоос хүртэж байхдаа гэрээгээ шинэчилдэг.

Гэрээгээ шинэчлэх үед бидэнд Түүний Сүнсийг үргэлж бидэнтэй хамт байлгана хэмээх амлалтыг өгдөг. Хэрэв бид Түүний Сүнсэнд амьдралд маань орж, удирдан чиглүүлэх боломжийг олговол Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү хоёрын бидэнд зориулсан аз жаргалын буюу авралын төлөвлөгөө болох Тэдний оршихуйд эргэн очиж чадна. ■

2008 оны 6-р сарын 24-нд Провогийн Номлогчийг бэлтгэх төвд болж өнгөрсөн номлолын шинэ ерөнхийлөгчдөд зориулсан сургалт дээрх “Цагаатгал” үгнээс авав.

Эшлэл

1. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 59



ЕСҮС ХРИСТИЙН АМИЛАЛТ БА БИЕ МАХБОДЫН ТАЛААРХ ҮНЭН

Дэвид А.Эдвардс

Сүмийн сэтгүүлүүд

“Есүс цууг амсаж—Гүйцэлдлээ! гээд, тэргүүнээ гудайлган сүнсээ даатгав” (Иохан 19:30). Тэр мөчид Есүс Христийн сүнс—Түүнд бүх хүний гэм нүглийг цагаатган, сул дорой байдлынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд зовлон шаналлыг амссан тэрхүү биеэс нь салан одсон юм (Алма 7:12–13-ыг үзнэ үү). Амьгүй болсон тэр биеийг загалмай дээрээс авч, даавуунд ороож, эцэст нь булшинд тавьжээ. Гурав дахь өдөр эмэгтэйчүүд булшинд ойртон, тэрхүү биеийг оршуулах бэлтгэл ажлыг гүйцээж хийхээр ирэв.

Гэтэл бие байсангүй.

Булш хоосон байгааг мэдсэн нь ердөө эхлэл байв. Мари Магделин, төлөөлөгчид болон өөр бусад олон хүн хожим нь нэгэн гайхамшигт үйл явдал болох амилсан, төгс Есүс Христийг бодит биет хүмүүний төрхтэй болохыг гэрчилсэн.

Аврагч амилсныхаа дараа Өөрийг нь гэрчилсэн хүмүүст ямар биетэй болсноо баттай мэдүүлэхэд анхаарсан. Жишээ нь, Тэр төлөөлөгчдөдөө Өөрийг нь хий үзэгдэл биш, харин махан биеэрээ байгаа гэдгийг баттай мэдүүлэхийн тулд биенд нь хүрэхэд тэднийг урьдаг (Лук 24:36–40-ийг

үзнэ үү).¹ Тэр ч бүү хэл тэдэнтэй хамт иджээ (Лук 24:42–43-ыг үзнэ үү).

Дараа нь төлөөлөгчид Есүс Христийн сайн мэдээг номлох үүргээ биелүүлж байхдаа Есүс Христийг амилсан, үүний үр дүнд бүх хүн төрөлхтөн амилна гэж заасан учраас эсэргүүцэл, хавчлагатай тулгарсан юм (Үйлс 4:1–3-ыг үзнэ үү).

Есүс Христийн амилалт тухайн үед Түүний Сүмийн дэлхий дахинаа тунхаглаж байсны адил өнөөдөр ч захиасын гол цөм хэвээр байгаа юм. Бошиглогч Иосеф Смитийн хэлснээр “Манай шашны тулгуур зарчмууд бол Есүс Христийн талаарх, тухайлбал Тэрбээр егүүтгэгдэж, оршуулагдаад, гурав дахь өдрөө дахин босч ирэн, тэнгэрт дээшлэн одсон тухай бошиглогч, төлөөлөгчдийн гэрчлэл юм. Иймд манай шашинд хамаатай бусад бүх зүйл нь зөвхөн уг гэрчлэлийн хавсралт төдий юм.”²

Амилалт нь Бурханы болон бидний мөн чанар, Бурхантай харилцах харилцаа, энэ амьдралын зорилго, Есүс Христэд найдах бидний итгэл найдварын талаарх суурь асуултуудад хариулахад тусалдаг. Есүс Христийн амилалтаар тодорхой болсон үнэнийг доор дурдав.

Есүс Христ өөрийн амилалтаар дамжуулан бие махбодын талаарх чухал үнэнийг бидэнд заасан.



**“Бие мах-
бод бүхий
Бурханы тухай
ойлголтыг
үгүйсгэсэн хэн ч
мөнх бус хийгээд
амилсан Хрис-
тийг үгүйсгэж
байгаа хэрэг.”**

—Ахлагч Жэффри
Р.Холланд

Тэнгэрлэг Эцэг алдар суут бие махбодтой

Бурхан хүмүүний дүр төрхтэй хэмээх санаа Библид³ болон түгээмэл ойлголт дээр үндэслэгдсэн ч теологи болон шашны гүн ухааны уламжлал Бурханд “бие махбод, эрхтэн болон дур хүсэл үгүй”⁴ гэж үздэг учраас уг санааг үгүйсгэдэг. Тэд ийм өнцгөөс хардаг тул бие махбод (ерөнхийдөө матери) нь чөтгөрийн эсвэл бодит бус харин сүнс, оюун ухаан эсвэл үзэл санаа нь дээд түвшний биет буюу бодит байдлын жинхэнэ мөн чанар болж байгаа юм.

Тэгвэл Хүү Есүс Христээрээ дамжуулан өгсөн Бурханы мөн чанарын талаарх илчлэлт хэчнээн гайхалтай энгийн бөгөөд үндсээр нь бүрэн өөрчилсөн илчлэлт байсан юм.

Аврагч тохинуулж байхдаа “Намайг харсан хүн Эцэгийг харсан” (Иохан 14:9) хэмээн хэлсэн. Энэ нь “Эцэг хүмүүнийхтэй адил мах хийгээд ясан биетэй болой; Хүү ч бас адил” (С ба Г 130:22) гэдгийг Түүнийг төгс, үхэшгүй биетэйгээр амилсны дараа үнэхээр үнэн болохыг нотолсон юм.

Ийнхүү Тэнгэрлэг Эцэгийн бие махбодын мөн чанар илчлэгдсэн билээ. Иосеф Смит хожим нь: “Биегүй эсвэл биеийн эрхтэнгүй юм бол юу ч биш. Мах ясан биетэй

Бурханаас өөр Бурхан тэнгэрт үгүй”⁵ хэмээн тайлбарласан.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд: “Хэрэв Бурханд бие махбод хэрэггүйгээс гадна хүсүүштэй зүйл байгаагүй юм бол яах гэж хүн төрөлхтний Гэтэлгэгч Өөрийн махбодыг үхэл, булшнаас гэтэлгэж, энэ амьдралд болон мөнх амьдралд сүнснээс нь дахин салахгүй байхаар баталгаажуулсан байж таарах вэ? *Бие махбодтой Бурханы талаарх ойлголтыг үгүйсгэдэг хэн ч бай мөнх бус хийгээд амилсан Христийг үгүйсгэж байна гэсэн үг*” гэж хэлжээ.⁶

Тэнгэрлэг Эцэг бүхнээс хүчтэй, бүхнийг мэддэг, бүхнийг хайрладаг

Есүс Христ амилсан хэмээх бодит үнэн нь Тэнгэрлэг Эцэгийн зан чанарын төгс байдлыг мөн адил илчилдэг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффersonы хэлснээр “Христийн амилалт үнэн бодитой учраас дэлхийн гэтэлгэлийн төлөө Өөрийн Төрсөн Ганц Хүүг өгсөн Бурхан Эцэгийн хүч, мэдлэг, хайр энэрлийн талаарх аливаа эргэлзээ үндэслэлгүй юм.”⁷

Бурханы хүч, мэдлэг, нинжин сэтгэлийг Есүс Христийн Цагаатгал нотолсон бөгөөд энэ нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний мэргэн ухаан, хайр болон энэ бүхнийг биелүүлэх Өөрийнх (Хүүгийнх) нь чадварын гэрч болдог.

Бид Бурханы хүүхэд

Библид биднийг “Бурханы дүр төрхөөр . . . эрэгтэй, эмэгтэй” болгон бүтээсэн гэж заадаг (Эхлэл 1:27). Харин Есүс Христ амилснаар энэ үнэнийг баталсан. Үнэндээ, Амилалтын яг тэр мөчид Есүс Христ Тэнгэрлэг Эцэг болон бидний хоорондох харилцааг: “Би Миний Эцэг *бата нарын Эцэгт*, Миний Бурхан ба та нарын Бурханд очно” (Иохан 20:17; онцлон бичилт нэмэв) хэмээн хэлж онцолсон билээ.

Аврагч Бурхан, хүн төрөлхтөн хоёрыг мөн чанарын хувьд нэг нэгнээсээ тийм ч өөр биш болохыг илчилсэн. Бидний биеийн ерөнхий хэлбэр сүнстэй маань адил⁸ бөгөөд эх эцэг, үр хүүхдийн харилцааны үндсэн

шинж учраас бидний сүнс Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн билээ.

Бие бол боломж олгодог, эрхэм хүндтэй бэлэг юм

Аврагч Амиалтаараа дамжуулан бодит, бие махбодын оршихуй бол Бурханы болоод Түүний хүүхдүүдийн мөнх биесийн салшгүй нэгэн хэсэг гэдгийг харуулсан. Их Эзэний Иосеф Смитэд илчилснээр, “Элементүүд мөнх юм, мөн салшгүй холбогдсон сүнс ба элемент нь баяр хөөрийн бүрэн байдлыг хүлээн авдаг” (С ба Г 93:33). Энэхүү салшгүй холбоо нь сүнс болоод махан биесийг хамтад нь нэгтгэдэг бөгөөд тэд нэгдмэл мөнх бус, бохирдошгүй, алдар суут, төгс буюу өөрөөр хэлбэл Их Эзэнд байдаг тэрхүү баяр баясгалангийн бүрэн байдлыг хүлээн авах боломжтой бие болдог юм.

Үүнтэй харьцуулбал, махан биесийг хүлээн авсныхаа дараа сүнсний дэлхийд орохын тулд биеэсээ салахыг “нас барагсад өөрсдийнх нь сүнс биенээс нь сал[ахыг] . . . боолчлол хэмээн [үздэг ажгуу]” (С ба Г 138:50; мөн С ба Г 45:17-г үзнэ үү).

Бидний мөнх бус бие хүртэл Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний амин чухал хэсэг бөгөөд тэнгэрлэг бэлэг юм. Бидний сүнс мөнх бус байдлын өмнөх оршихуйгаас энэ дэлхийд ирэхэд бие махбод түүн “дээр нэмэгддэг” (Абрахам 3:26). Бошиглогч Иосеф Смитийн зааснаар “Бид бие махбодтой болж, үүнийгээ селестиел хаант улсад Бурханы өмнө цэвэр ариунаар аваачихын тулд дэлхийд ирсэн. Аз жаргалын агуу зарчим нь бие махбодтой болоход оршино. Чөтгөрт бие махбод байдаггүй. Энэ нь түүнд оногдуулсан шийтгэл юм.”⁹

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар: “Бидний бие махбод мөнх бус оршихуйн өмнөх дэлхийд байхдаа хүлээн авч чадахааргүй байсан туршлагуудыг өргөн хүрээнд, гүн гүнзгий, хүч чадалтайгаар олж авах боломжийг олгодог. Иймээс, бусад хүнтэй харилцах харилцаа, ялган таних ба үнэний дагуу үйлдэх, Есүс

Христийн сайн мэдээний зарчим, ёслолуудыг дагах чадварууд нь бидний бие махбодоор дамжуулан боломжтой болсон билээ. Мөнх бус амьдралд бид өрөвч зөөлөн сэтгэл, хайр энэрэл, сайхан сэтгэл, аз жаргал, уйтгар гуниг, урам хугаралт, өвчин шаналал болон бие махбодын хөгжлийн бэрхшээл зэрэг зүйлсийг даван туулснаар мөнх амьдралд бэлтгэгдэж байдаг. Энгийнээр хэлэхэд, “махбодод оршсоны дагуу” (1 Нифай 19:6; Алма 7:12–13)¹⁰ гэж сударт бичсэнчлэн бидний сурах ёстой хичээл, олж авах ёстой туршлагууд гэж байдаг” гэж заасан.

Түүнчлэн Иосеф Смит: “Бие махбодтой бүх юмс биегүй юмсаас илүү хүчтэй байдаг.”¹¹ Сатан биднийг сорьж чадах ч биднийг албадаж чадахгүй. “Хэрэв бид чөтгөрт боломж олгохгүй бол биднийг уруу татах хүч түүнд байдаггүй”¹² хэмээн заасан.

Эцэстээ, төгс бөгөөд амилсан бие биднийг Сатаны хүчнээс үүрд хол байхад тусалдаг. Амиалат байгаагүй бол “дахин хэзээ ч босохгүйгээр . . . чөтгөр[ийн] . . . харьяалалд бидний сүнс орох ёстой болой. Мөн бидний сүнс түүнтэй адил болж, бид чөтгөр, чөтгөрийн элчүүд болж, Бурханыхаа дэргэдээс таслагдаж, мөн худал бүхний

Бидний мөнх бус бие махбод Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний амин чухал хэсэг бөгөөд тэнгэрлэг бэлэг юм. Бидний сүнс энэ дэлхийд ирэхэд бие махбод түүн “дээр нэмэгддэг” (Абрахам 3:26).



эцэгтэй хамт, өөртэй нь адилаар зовлонд үлдэх байсан” (2 Нифай 9:8–9).

Сүнс хийгээд бие нь нэг нэгнийхээ дайсан биш болой

Хэдий өөр ч гэлээ, сүнс болон бие махбод нь үнэн хэрэгтээ өөр хоорондоо ялгаатай, эвлэршгүй бодит байдалд харьяалагддаггүй. Иосеф Смит: “Бодит бус матери дугаа адил зүйл гэж үгүй. Бүх сүнс матери мөн, харин энэ нь илүү нарийн, эсвээс цэвэр, мөн гагцхүү илүү цэвэр мэлмийгээр ялгагдан танигдаж болох бөлгөө. Бид үүнийг харж чадахгүй, харин бидний бие цэвэршигдсэн үед энэ нь бүгд матери болохыг бид харах болно” (С ба Г 131:7–8) гэдгийг ойлгож мэджээ.

Есүс Христ Өөрийн алдар суут, амилсан байдалд сүнс, бие махбодын төгс нэгдлийг төлөөлсөн бөгөөд бидэнд “Мөн сүнс хийгээд мөн бие нь хүмүүний бодгаль бөлгөө” (С ба Г 88:15) гэдгийг харуулсан. Бид энэ амьдралд “биеэ бодохоос” илүү “сүнсээ бодох” (2 Нифай 9:39), “эгэл хүнээ [орхих]” (Мозая 3:19), “бүх хүслээ хазаарлахыг” (Алма 38:12) хичээдэг. Гэхдээ энэ нь сүнс, бие махбод хоёр нэг нэгнийхээ дайсан гэсэн үг биш ээ. Есүс Христийн бидэнд үзүүлснээр бие махбодыг дорд үзэж, дээр нь гарах биш, харин эзэн нь болж, өөрчлөх ёстой.

Мөнх бус биет амьдралын зорилго утга учиртай болой

Энэ амьдрал бол шалгуур гэсэн ойлголт өмнөх болоод дараах амьдралынхаа талаар мэддэг зүйлээ эргэцүүлэн бодох үед илүү утга учиртай болдог. Бид энэ дэлхийд ирэхээсээ өмнө сүнсэн байдлаар амьдарч байсан бөгөөд Тэнгэрлэг Эцэг биднийг Өөртэй нь адил болж, үүрд мөнх бие махбодтой болж амьдраасай гэж хүссэн. Эдгээр үнэн нь мөнх бус бие махбодтой

өнгөрүүлэх энэ шалгуурын цаг үе бол тохиолдлынх бус харин бодит утга учир, зорилготой гэдгийг харуулж байгаа юм.

Ахлагч Кристоффэрсоны хэлснээр: “Их Эзэн, [бидний] Бурхан [бидэнд] зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн хийх” сонголт хийвэл “хоёр дахь байдлаа” хадгалсанд тооцогдох байв. Энэ нь бид сонголтоороо дамжуулан Түүний оршихуйгаас тусдаа, бие махбодыг бүх хүч чадал, дур хүсэл, хэрэгцээтэй нь эзэмшиж, Түүний селестиел хуулийн дагуу амьдрах амлалт болон чадвараа харуулна гэсэн үг юм. Бид бие махбодоо хазаарлаж мөн үүнийг сүнснийхээ эзэн нь бус зэмсэг нь болгож чадах уу? Бидэнд амьдрал бүтээх хүчийг багтаасан бурханлаг хүчнүүдийг мөнх бус амьдралд болон үүрд мөнхөд ашиглах итгэл хүлээлгэж болох уу? Бид тус бүрдээ хилэнцийг даван туулах болов уу? Харин үүнийг хийсэн хүмүүсийн дээр ‘алдар суу үүрд мөн мөнхөд нэмэгдэх’ [Абрахам 3:26] бөгөөд энэ нь амилуулагдсан, үхэшгүй, мөн алдар суутай болсон бие махбодын тэрхүү алдар суугийн нэн чухал хэсэг юм.”¹³

Бидний өөр хоорондоо харилцах харилцаа гээд энэ бие махбодтойгоо олж авсан туршлага нь ирээдүйд ирэх зүйлтэй адил учраас учир утгатай билээ. Иосеф Смитийн олж мэдсэнчлэн: “Энд бидний дунд байгаа тэрхүү харилцаа тэнд бидний дунд байх болно, гагцхүү энэ нь эдүгээ бидний эдэлдэггүй тийм алдар суу болох мөнхийн алдар суугаар хоёр дахин ихсэх болно” (С ба Г 130:2).

Есүс Христэд найдах найдвар бидэнд буй

Булш хоосон байсан өдрөөс хойш Есүс Христийн амилалт бидэнд найдвар авчирсан. Учир нь бид Түүний



Есүс Христ алдар
суут, амилсан
байдлаараа сүнс ба бие
махбодын төгс нэгд-
лийг төлөөлдөг бөгөөд
“Мөн сүнс хийгээд мөн
бие нь хүмүүний бодгаль
бөлгөө” (С ба Г 88:15)
гэдгийг харуулдаг.



Буули хоосон байсан өдрөөс хойш Есүс Христийн амилалт бидэнд найдвар авчирсан. Учир нь бид Түүний амилалтаас өөрсдийн ирээдүйг харсан.

амилалтаас өөрсдийн ирээдүйг харсан бөгөөд “Үргэлжлүүлэн итгэлтэй байж чадах л юм бол алдсан бүх юмаа авна”¹⁴ гэдгээ олж харсан.

Аврагчийн эртний төлөөлөгчид Түүний бие махбодыг харж, мэдэрсэн учраас Түүний Амилалтын тухай зоригтой гэрчилж чадсан. Гэхдээ энэ нь үүнээс ч илүү утга учиртай зүйл байв. Есүс Христ гэм нүглийг өршөөх хүч (Лук 5:23–25-ыг үзнэ үү) Өөрт нь байдгийг үзүүлэхийн тулд бие махбодын өвчинг эдгээсний адил Түүний Амилалт буюу бие махбодын үхлийг ялан дийлэх бодит хүчтэй гэдгийн нотолгоо нь сүнсний үхлийг ялан дийлэх хүчин чадлынх нь баталгаа болсон юм. Сургаалаараа дамжуулан өгсөн амлалтууд нь гэм нүглийн өршөөл, энэ амьдрал дахь амар амгалан, Эцэгийн хаант улс дахь мөнх амьдрал бөгөөд бодит болж, итгэлийг нь хөдөлшгүй бат болгосон.

“Хэрэв Христ амилуулагдаагүй бол та нарын итгэл хэрэггүй байжээ” (1 Коринт 15:17). Гэхдээ Тэр үхэгсдээс

боссон учраас бид “Христийн цагаатгал, мөн түүний амилалтын хүчээр, мөнх амьдралд босгогдохын тулд найдахыг би та нарт хэлье, мөн энэ нь амилалтын дагуу түүнд итгэлтэй” (Моронай 7:41) байж чадна.

Есүс Христ мөнх бус амьдралынхаа туршид хүмүүсийг Өөрийг нь дагахад урьж байсан. Түүний үхэл болон Амилалтын дараа очих газар нь улам тодорхой болсон. Хэрэв бид сайн мэдээний хууль, ёслолуудыг дагаснаар дотор байх “селестиел сүнсийг” хөгжүүлэх юм бол “ердийн биетэйгээ адил тийм биеийг хүлээн авч,” “селестиел алдар суугийн хувь хэмжээгээр амьдруулагддаг. Тэгээд үүнийг бүр бүрэн байдлаар нь хүлээн авах” (С ба Г 88:28–29) боломжтой. Есүс зам заасан. Есүс бол зам мөн. Амилсан биетэйгээр баяр баясгаланг бүрэн мэдрэх буюу энэхүү селестиел бүрэн дүүрэн байдал нь Түүний хүч болох Цагаатгал болон Амилалтаар боломжтой болсон. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Есүс Христ Шинэ дэлхийн хүмүүс дээр ирэхдээ мянга мянган хүнээс “нэг нэгээрээ” ирж, гар, хөл, хажуу талд нь хурч, амилсан Их Эзэнийг харсан, мэдэрсэн гэдгээ гэрчлэхийг хүссэн (3 Нифай 11:14–15; 18:25-ыг үзнэ үү).
2. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 59.
3. Эхлэл 1:27; Египетээс гарсан нь 33:11; Үйлс 7:56-г үзнэ үү.
4. Хэдийгээр үүнтэй адил үзэл санаа эртний Христийн шашны урсгалуудад байсан ч яг энэ томъёолол нь Английн сүмийн гучин сөн тунхгаас гаралтай.

5. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит*, 50.

6. Жэффри Р.Холланд, “Цорын ганц үнэн Бурхан болон Түүний илгээсэн Есүс Христ,” *Liahona*, 2007 оны 11-р сар, 42.
7. Д.Тодд Кристоффэрсон, “Есүс Христийн амилалт,” *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 132.
8. Мөнх бус байдлын өмнөх Есүс Христийн талаарх илчлэлт ч гэсэн энэ баримтын гэрч болдог. Учир нь Түүний сүнсний бие хүмүүний хэлбэрээр байсан (Ифер 3:16-г үзнэ үү).

9. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит, 239.

10. Дэвид А.Бэднар, “Бид ариун явдал итгэдэг,” *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 41.
11. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит, 239.
12. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит*, 241.
13. Д.Тодд Кристоффэрсон, “Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 35.
14. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит, 51.

Түүнд, Түүнд ирэгтүн

Сэтгэлээсээ ♩ = 44-48

Үг: Стивэн К. Жөүнс

Ая: Майкл Ф. Мүүди

mp

1. Бид -
2. Өнд -
3. Шана-

5

нийг хайр - лан, Тэр би - дэнд ир - сэн. Бүх - ний тө - лөө Тэр га -
рөөс буун ирж, Хү - ний а - дил байж, Өр зурх - ний шана - лал бүр -
лал зов - лон бүр - ийг амс - сан Тэр Шавь бол - он дага - санд тайт -

8

раа сун - га - даг; Га - шууд - са - ныг Тэр тайт - га - руулж, Ганс -
ийг туул - сан Тэр Өл - сөж, цанга - сан нэг - нийг ойл - гож, Өн -
гар - лыг хүр - тээнэ. Ном - хон да - руу ит - гэгч - дийн - хээ Нү -

rall.

11

рал, гуни - гийг дава - хад Тэр тус - ал - даг. Түүнд, Түүнд и - рэг -
чирч, туйлд - сан зур - хийг эд - гээж чад - на. Түүнд, Түүнд и - рэг -
дийг нь нээж, нүг - лийг нь өр - шөө - дөг. Түүнд, Түүнд и - рэг -

a tempo

2



14

түн. _____
түн. _____ Түүнд ирц - гээ. Түү - нээс су - ралц. _____ Тэр
түн. _____

17

хүл - цэн - гүй да - руу нэ - гэн би - лээ. Түүнд, Түүнд и - рэг -

20

түн. _____ 1, 2. _____ 3. _____ Түүнд,
2. Өнд - _____
3. Шана - _____

23

Түүнд бүгд и - рэг - түн. _____ *rall.*

Зохиогчийн эрх © 2016 Стивэн К.Жөүнс ба Майкл Ф.Мүүди. Бүх эрх хамгаалагдсан.
Энэхүү дууг арилжааны бус зорилгоор сүмд болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан олшруулж болно.



Найдвар, эдгэрэл ТИЙШ ХӨТЛӨХ ГҮҮР

Бэлгийн хүчирхийллийн хохирогчид зохих тусламж хүлээн авснаар сэтгэлийнхээ гүнд хүсэж буй эдгэрлийг хүлээн авах боломжтой.

Нанон Тэйлий

ХҮГ Гэр бүлийн үйлчлэлийн алба, АНУ, Техас

Өөрийгөө хадан цохионы ирмэг дээр зогсоод, хэн нэгний хэлсэн үгээр гүн хавцлын нөгөө талд хүлээж байгаа тэр агуу их аз жаргал руу очихыг хүсэж байна гэж төсөөл. Нөгөө талд гарах замыг эрж хайж байхдаа, хэрэв зөв угсарвал гүн хавцлаар гарах гүүрийг барьж болох овоолсон материал байхыг олов.

Хэрвээ та гүүр хэрхэн барихыг мэдэхгүй бол тэнд байгаа материал ямар ч хэрэггүй бөгөөд сэтгэлээр унаж, итгэл найдвараа алдах болно. Хэрвээ та гүүр барьж байсан туршлагатай хүнээс тусламж хүсвэл мэдлэг, ойлголт тань өсөн нэмэгдэж, хамтдаа гүүрийг барьж чадах билээ.

Сүүлийн 18 жилийн турш би сэтгэл санааны эсвэл оюун ухааны зовлон шаналлын гүн хавцлыг туулахад туслах арга хэрэгсэл, заавар зөвлөгөө өгөх ажил хийлээ. Зөвлөгөө өгсөн хүмүүсийн дундаас хамгийн их шарх сорвитой нь бэлгийн хүчирхийллийн хохирогчид байсан юм шиг санагддаг. Энэ бэрхшээл хувь хүний эцсээ хүртэл тэвчих чадварт хэрхэн нөлөөлдгийг би харсан.

Гэсэн хэдий ч бид Аврагчаараа дамжуулан бэрхшээл, зовлон шаналлаасаа үүрд ангижран салах боломжтой гэдгийг бас би олж мэдсэн. Түүний хайр хүмүүсийг харанхуйгаас гэрэлд гаргаж ирдэг.

Яагаад бэлгийн хүчирхийлэл ийм их гарз хохирол учруулдаг вэ?

Хүчирхийллийн хохирогчид сэтгэлээр унах, өөрийгөө үгүйсгэх зэрэг сэтгэлийн бусад гүн гүнзгий өвчин шаналлаар дүүрэн амьдралынхаа тухай надад өгүүлдэг. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) бэлгийн хүчирхийллийн ийм гүн гүнзгий шарх үлдээдэг шалтгааны талаар ойлгоход бидэнд тусалсан.

“Бэлгийн хүчирхийлэл гэх аймшигтай, гутамшигт зүйл байдаг. Үүнийг ойлгоход түвэгтэй юм. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүн нэг бүрд байх ёстой ёс журамт байдлыг гутаан доромжилдог. Энэ нь *ариун нандин, бурханлаг зүйлийг зөрчиж буй хэрэг*. Энэ нь бас хүүхдүүдийн амьдралыг сүйтгэдэг. Түүнээс гадна энэ нь *хамгийн хатуу чанга ял авах хэмжээний зүйл юм*.”

Хүүхдийг бэлгийн замаар хүчирхийлсэн эрэгтэй, эмэгтэй хэн ч бай юутай шившигтэй еэ. Үүнийг үйлдсэн хүчирхийлэгч *хамгийн ноцтой шарх сорви үлдээхээс гадна*, Их Эзэний өмнө буруушаагдах болно.”¹

Үр удмаа үлдээх хүч нь Тэнгэр дэх Эцэгийн хүүхдүүдээ өгсөн ариун нандин, бурханлаг хүч юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар: “Үр удмаа үлдээх хүч нь сүнслэг байдлын хувьд чухал. . . .

Бидний Тэнгэрлэг Эцэг, Түүний Хайрт Хүү хоёр бол бүтээгчид бөгөөд бүтээлтийн хүчнийхээ нэгээхэн хэсгийг бидэнд өгсөн билээ”² хэмээн заасан. Тиймээс энэхүү ариун нандин хүчийг уландаа гишгэх нь “хамгийн хатуу чанга ял авах хэмжээний” мөн “хамгийн ноцтой шарх сорвийг” үлдээдэгт гайхах хэрэггүй.

Сэтгэлийн шархыг ойлгох нь

Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь нэг хүн бэлгийн дур хүслээ хангахын тулд нөгөө хүнээ хүсээгүй байхад нь хүрэх эсвэл хүрэхгүйгээр ашигладаг харилцааг хэлнэ. Ихэнх тохиолдолд бэлгийн хүчирхийллийн хохирогчид яах учраа ч мэдэхгүй болохоос гадна ямар ч үнэ цэнгүй, бараг дааж давшгүй мэт ичгэвтэр байдалд үлддэг. Хохирогчдын зовиур, шаналал нь ихэвчлэн бэлгийн хүчирхийлэл болон үүнээс үүдэн гарах үр дагаврын талаар буруу ойлгодгийн улмаас болж хэлсэн бусдын үгээр улам гүнзгийрдэг. Зарим хохирогч худлаа хэлсэн хэрэгт унаж, ямар нэгэн байдалаар өөрсдийн буруугаас болж хүчирхийлэлд өртсөн мэт гүтгүүлдэг. Харин заримыг нь хохирогч болсноор нүгэл үйлдсэн мэт үзэн, наманчлах ёстой гэж итгүүлсэн байдаг.

Хүүхэд байхдаа эсвэл өсвөр насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчдэд маань “одоо боль,” “өнгөрснийг орхи,” “зүгээр л уучлаад, март” гэх мэтээр хэлсэн байдаг. Ялангуяа эдгээр мэдэгдэл дотны найз, гэр бүлийн гишүүн эсвэл Сүмийн удирдагчдаас ирсэн бол хохирогчдод эдгэрэлт, амар амгаланг авчрахын оронд асуудлаа улам бүр нуун дарагдуулж, ичгэвэртэй байдалд ороход хүргэж болно. Бие махбодын ноцтой шарх, халдвартай адил тэдгээр сэтгэлийн шарх нь үл ойшоогоод орхилоо гээд өөрөө аяндаа эдгэрнэ гэж үгүй. Харин хүчирхийллийн үед үүссэн төөрөгдөл нь нэмэгдсээр, үүссэн сэтгэлийн зовлон шаналалтай нь нийлж, улмаар уг хүний бодол санаанд өөрчлөлт орж, эцсийн эцэст эрүүл бус зан авир гаргахад хүргэж болно. Хохирогчид өөрсдөд нь тохиолдсон зүйл хүчирхийлэл гэдгийг мэдэхгүй байх нь элбэг боловч эрүүл бус зан авир, сэтгэл хөдлөлтэй болсон байдаг.

Ханна (нэрийг өөрчлөв) бага балчир байхдаа бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Бусад хохирогчийн адил тэр өөрийгөө ямар ч үнэ цэнгүй, муу хүн гэсэн бодолтой өссөн байна. Тэр Тэнгэрлэг Эцэгийн эсвэл өөр хэн нэгний хайрыг хүртэх “хангалттай сайн” биш гэсэн мэдрэмжээ дарахын тулд бусдад үйлчлэхэд амьдралынхаа ихэнх цаг хугацааг зориулжээ. Харилцааны хувьд хэн



нэгэн хүн түүнийг үнэхээр хэн болохыг нь мэдэх юм бол бодож явдагтайгаа адил өөрийг нь аймшигтай муухай хүн гэж бодох вий гэхээс тэр айдаг байв. Тэр өөрийг нь хүлээн авахгүй байх гэсэн гүн гүнзгий айдсаасаа болж амьдралдаа шинэ зүйл туршиж үзэх эсвэл хэн нэгэн рүү утсаар ярих зэрэг энгийн зүйлийг хүртэл хийхээс эмээдэг байжээ. Тэр зураг зурах авьяасаар адислагдсан ч шүүмжлэл хүлээн авч чадахгүй байх вий гэсэн айдсаасаа болж орхисон байна.

50 жилийн турш арга мухардаж, хүчин мөхөсдсөн болон айдас, уур уцаар, эргэлзээ, ичгүүр, ганцаардал, өөрийгөө тусгаарлах гэсэн мэдрэмж өдөр тутмын шийдвэрт нь нөлөөлсөөр ирсэн байв.

Зүрх сэтгэлийн зовлон шаналлыг амар амгалангаар солих нь

Аврагч “бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг” тэвчсэн. Тэр “бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд” (Алма 7:11–12) үүнийг хийсэн. Аврагч зөвхөн бидний үйлдсэн нүглээс биш, харин бусдын нүглээс болж зовох үед маань биднийг эдгээхийн тулд мөн зовж шаналсан юм.

Хэрэв Аврагч өнөөдөр энд байсан бол нифайчуудтай хамт байсантай адил бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүмүүстэй хамт уйлж, тэднийг адислах байсан байх гэж би боддог (3 Нифай 17-г үзнэ үү). Хэдийгээр Тэр энд махан биеэрээ байхгүй байгаа ч Түүний Сүнс бидэнтэй хамт байгаа бөгөөд бидэнд эдгэх, амар амгаланг мэдрэх, уучлах арга замыг өгсөн.



Сэтгэлийн шархтай олон хүн үүрч яваа ачааг нь амар амгалангаар солих бараг боломжгүй гэдэгт итгэдэг. Хүчирхийлэлд автсан хүний сэтгэлийн шархыг бусад хүн олон жилийн турш анзаарч харахгүй, хүлээн зөвшөөрөхгүй явсан байдаг. Тэд зовлон шаналлаа инээмсэглэсэн царай, бусдад үйлчлэхэд бэлэн байдал, ямар ч муу зүйл болоогүй мэт амьдрах гэсэн багаар халхалдаг боловч үнэн хэрэгтээ зовлон шаналал нь үргэлж байсаар л байдаг.

Сэтгэл санааны эдгэрэх үйл явцыг бие махбодын шархыг арчилж, эмчлэхтэй харьцуулъя. Та бага байхдаа хөлөө хугалсан гэж төсөөл. Хугарсан ясыг нийлүүлэхээр эмч дээр очихын оронд хүчтэй өвдөлтөө намдтал доголж алхсаар, улмаар алхах тоолондоо эмзэглэж, өвдөлтийг үргэлж мэдэрнэ. Ингээд олон жил өнгөрсний дараа та өвдөлтөө бүрмөсөн намдаахын тулд эмч рүү очно. Эмч ясыг тань дахин нийлүүлж, илүү ургасан бүх зүйлийг тайрч цэвэрлэн, хөлийг тань хүчирхэгжүүлэхийн тулд физик эмчилгээнд явуулах хэрэгтэй болно.

Хүчирхийлэлээс үлдсэн шархаа эдгээх явц яг үүнтэй адил бөгөөд үүний тулд хохирогч юуны түрүүнд сэтгэлийн шарх нь бодит бөгөөд

ХОХИРОГЧДЫН ГАРГАДАГ НИЙТЛЭГ ЗАН АВИР

Ихэнх тохиолдолд хохирогчид хүмүүстэй харилцах тал дээр асуудалтай байдаг ба бусдаас үргэлж зөвшөөрөл авахыг хүсэх, идэвхгүй байдал гаргах, сэтгэлээ шархлуулахаас зайлсхийхийн тулд саад босгон, хүмүүсээс зайгаа барих, хайр халамж мэдрэхийн тулд бэлгийн үйл ажиллагаанд замбараагүй орох (тухайлбал, порнограф, өөрийгөө хангах гэх мэт) эсвэл яг үүний эсрэг буюу бэлгийн харилцаатай холбоотой аливаа зүйлээс бүрэн татгалздаг. Хувь хүмүүс өөрсдөд нь тохиолдсон явдал, гаргаж буй зан авирынхаа хоорондох уялдаа холбоог сайн ойлгодоггүй учраас дээрх зан авиртай холбоотой ичгэвтэр байдал нь тэднийг эцэг эх, санваарын удирдагчид, мэргэжлийн хүнээс тусламж эрэлхийлэхэд саад болдог.

Хохирогчид сайн мэдээний дагуу амьдрахдаа аль нэг талыг хэт баримтлан туйлшрах буюу зарим нь бүр хэт шашинлаг болдог. Тэд зохисгүй гэж бодож байгаа зүйлээ далдлахын тулд бүх зүйлийг зөв хийхийг хичээдэг. Бусад нь өөрсдийгөө хэзээ ч мөнх амьдралаас хүртэх зохистой болохгүй гэсэн бодлоосоо болж яваандаа хичээхээ больдог.

СУРГААЛ БА ГЭРЭЭ 123-ААС СУРАХ СУРГАМЖУУД

Бошиглогч Иосеф Смит Миссуригийн Либерти шоронд хоригдож байхдаа Сургаал ба Гэрээ 121–124-р хэсгээс бүрдсэн захидлыг Сүмийнхэнд бичжээ. Үүнд “мөрдөн мөшгөгчдийн талаар өгөгдсөн илчлэлтэд толилуулагдсан гэгээнтнүүдийн үүрэг” (С ба Г 123, хэсгийн оршил) орсон байдаг. Тэр хавчлага мөрдлөг, бие махбодын бэртэл гэмтлээс болж зовж шаналж байгаа гэгээнтнүүдэд үүнийгээ дотроо хадгалж, юу ч болоогүй мэт дүр эсгэ гэж хэлээгүй. 123-р хэсэг дэх зөвлөгөөг хүчирхийллийн асуудалтай хэрхэн холбож болох талаар бодож үз.



ямар нэгэн арга хэмжээ авах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнд болсон зүйлийг хүлээн зөвшөөрөх мөн зовж шаналах, айх, гутрах зэрэг мэдрэмжийг мэдрэх, ухаарах, бататгах үйл явц орно. Ихэнх тохиолдолд энэхүү эдгээх үйл явцаар мэргэшсэн туршлагатай хүнтэй ажиллах нь тустай. (ХҮТ Гэр бүлийн үйлчлэлийн алба танай бүс нутагт байгаа эсэхийг мэдэхийн тулд санваарын удирдагчтайгаа ярилц.)

Хохирогч мэргэжлийн тусламж авах боломж байгаа эсэхээсээ үл хамааран залбирч, Аврагчийн амьдрал, Цагаатгалаас судалж, санваарын удирдагчтайгаа ойр ойрхон уулзах нь зүйтэй. Тэр хохирогчийн ачааг хөнгөлж, тэнгэрлэг үнэ цэнээ мөн Тэнгэр дэх Эцэг болон Аврагчтай ямар харилцаа холбоотой болохоо ойлгоход туслах сүнслэг өдөөлтийг хүлээж авахад тусална. Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Кэрол М.Стэфэнс: “Эдгэрэх явц урт удаан үргэлжилж магадгүй. Та залбирангаа удирдамж болон зохих ёсоор томилогдсон санваартнуудтай зөвлөлдөх зэрэг тусламжийг эрэлхийлэх шаардлагатай болно. Та хүмүүстэй нээлттэй харилцаж сурснаар зохих хил зааг тогтоож, мэргэжилтнээс зөвлөгөө авахыг эрэлхийлэх хэрэгтэй

ч болж магадгүй. Энэ үйл явцад сүнслэг байдлаараа эрүүл байх нь туйлын чухал!”³ хэмээн саяхан заасан билээ.

Ханнагийн хувьд амьдрал нь үнэхээр тавгүй болж, тусламж эрэлхийлжээ. Тэр амар амгалан, сэтгэл хангалуун байж болно гэдгээ гэрчлэлээрээ мэдэж байсан ч эдгээр мэдрэмжийг байнга мэдэрдэггүй байв. Тэр залбирч, бишоптойгоо ярилцсаны үр дүнд зөвлөгөө авч, харанхуйгаас үнэнийг гаргаж ирэн, ганцаараа үүрч явсан аймшигт хүнд ачаагаа хуваалцахад хэрэгтэй байсан зэмсгүүдийг олж авах боломжтой болсон. Үүнийг хийснээр тэр зовлон шаналлаасаа салж, Аврагчийн амласан тэрхүү амар амгаланг олж чадсан билээ (Иохан 14:27-г үзнэ үү). Түүнд энэхүү амар амгалан, тайтгарлын хамт уучлах хүсэл, чадвар ирсэн юм.

Уучлах хэрэгцээ шаардлага

Хүчирхийллийн хохирогчдод уучлах гэсэн ойлголтыг хүлээж авахад ихэнхдээ хэцүү байдаг төдийгүй энэ талаар гол төлөв буруу ойлголттой байдаг. Хэрэв уучлах гэдэг нь хүчирхийлэгчийг хариуцлага үүрэхээс нь чөлөөлөх эсвэл тэдний хийсэн зүйл одоо ямар ч хамаагүй гэж хэлэхийг хэлж байна гэж бодох юм бол хохирогч үүнийг хүлээн зөвшөөрөхгүй. Бидэнд уучлахыг зарлигласан байдаг ч (С ба Г 64:10-ыг үзнэ үү) гүнзгий хор хөнөөл учруулсан

тохиолдолд хохирогч хүчирхийлэгчийг бүрэн уучлахаас өмнө эдгээх үйл явц эхэлсэн байх ёстой.

Хүчирхийллээс болж зовж шаналж байгаа хүмүүс Мормоны Номын “Иаков, би, зүрх сэтгэлээрээ цэвэр байх та нарт ярихыг хүснэ. Бурханд шийдэмгий оюунаар хандаж, мөн түүнд үлэмж итгэлтэйгээр залбирагтун, мөн тэрбээр та нарыг зовлонд чинь тайтгаруулна, мөн тэрбээр та нарыг өмгөөлж, мөн та нарын устгалыг эрэлхийлэх тэдэнд шударга ёсыг доош илгээх болно” (Иаков 3:1) хэмээх зөвлөгөөнөөс тайтгарч болно. Шударга ёсны шаардлага, нөхөн барагдуулах эрхийг Их Эзэнд гардуулан өгөх боломжтой бөгөөд Тэр бидний зовлон шаналлыг амар амгалангаар сольж чадна.

Эцэст нь Ханна шударга ёсны шаардлагыг Аврагчид шилжүүлэн, оронд нь урьд өмнө хэзээ ч мэдэрч байгаагүй тэрхүү амар амгаланг амьдралдаа олж авах боломжтой гэдгээ мэдсэн юм. Өмнө нь тэр өөрийг нь хүчирхийлсэн хүн байгаа гэр бүлийн цугларалтад очихоос айдаг байжээ. Харин одоо эдгэрэх явцдаа оюун санааны гүн шархтайгаа нүүр тулахыг хүсэх болсон учраас түүний хажууд байхаас айхаа больж, тэр байтугай түүнийг өтөл насанд нь өршөөж уучилжээ.

Шаардлагагүй ачаа дарамтаас чөлөөлөгдөх

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г. Скотт (1928–2015) “бүрэн дүүрэн эдгэрэл нь Есүс Христэд болон Түүний хүч чадал, чадавхад итгэх таны итгэлээр мөн шударга бус, үүрэх ёсгүй зүйлсийн шархыг эдгээх Түүний Цагаатгалаар дамжин ирдэг. . . .

Тэр танд хайртай. Тэр таныг шаардлагагүй ачаа дарамтаас чөлөөлөхийн тулд Өөрийн амийг өгсөн билээ. Тэрээр танд үүнийг хийхэд туслах болно. Түүнд таныг эдгээх хүч байгааг би мэднэ”⁴ хэмээн хэлсэн.

Дайсан өөрөө зовлонт учраас хүмүүсийг сэтгэлийн өвчин зовлондоо боолчлогдоосой хэмээн хүсдэг (2 Нифай 2:27-г үзнэ үү). Аврагч Есүс Христийн тусламжтайгаар зовлон шаналлыг үнэхээр зөвхөн Түүний өгч чадах амар амгалангаар солих боломжтой бөгөөд бид баясгалантай амьдарч чадна. “Адам хүмүүн байж болохын тулд унасан; мөн тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө” (2 Нифай 2:25). Баяр баясгалантай амьдрах нь бидэнд хүнд хэцүү үеийг тэсвэрлэж чадахууц болгож, суралцаж, өсөж хөгжих мөн Тэнгэр дэх Эцэгтэйгээ илүү адилхан болох боломжийг өгдөг.

Би амьдралдаа хүчирхийллийн хор хөнөөлийг амссан хүмүүстэй хамт суугаад, зөвхөн Аврагчаар дамжин ирэх эдгэрлийн гайхамшигийг харах боломжоор адислагдсандаа даруусдаг. Хэрэв та зовж шаналж байгаа бол залбирч, тусламж эрэлхийлээрэй. Та хүнд ачааг ганцаараа үүрэх шаардлагагүй. Тэр эдгээдэг гэдгийг би мэднэ. Би үүнийг тоолохын аргагүй олон удаа харж мөн гэрчилсэн билээ. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Гордон Б.Хинкли, “Save the Children,” *Ensign*, 1994 оны 11-р сар, 54; онцлон тэмдэглээт нэмэгдсэн.
2. Дэвид А.Бэднар, “Бид ариун явдал итгэдэг,” *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 50.
3. Кэрол М.Стэфэнс, “Эдгээгч Эзэн,” *2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 129.
4. Ричард Г.Скотт, “To Be Free of Heavy Burdens,” *Liahona*, 2002 оны 11-р сар, 88.

УДИРДАГЧИД, ГЭР БҮЛ, НАЙЗ НӨХДӨД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Хохирогч танд итгэн, өөрийнхөө зовлон шаналал, хүчирхийллийн талаар хуваалцах үед тэдэнтэй хийх ярилцлагаа хайр, өрөвч энэрэнгүй сэтгэлээр эхэл. Надтай маш олон хохирогч бишопоосоо тусламж авахаар очих үед тэд хамгийн түрүүнд хүчирхийлэгчийг уучлахад илүү ач холбогдол өгч байсан тухай хуваалцсан юм. Энэ нь хохирогчдод зөвхөн хүчирхийлэгчид ач холбогдол өгч байна гэсэн мэдрэмж төрүүлдэг. Ийм зүйл тохиолдвол хувь хүмүүс ихэвчлэн бишоп руугаа дахин тусламж хүсэж очдоггүй бөгөөд сүмийн хайр, дэмжлэгээр хүлээн авах боломжтой сүнслэг эдгэрлийг авч чаддаггүй.

Уучлах нь эдгэрэл хэмээх үйл явцын чухал хэсэг, зарлиг хэдий ч эхлээд тухайн хүний зовлон шаналлыг хүлээн зөвшөөрч, сэтгэлийнх нь шархнаас хуваалцаж, эдгээр зүйлийн талаар итгэл даах хүнтэй ярилцах нь аажмаар хүчирхийлэгчийг уучилж, улмаар эдгэрэл тийш хөтөлнө гэдэгт итгээрэй.

Сүмийн удирдагчид илүү дэлгэрэнгүй мэдээллийг ministering.lds.org дээрх “Abuse: Help for the Victim” -аас авна уу.

Гэр бүлийн хуучин ЗУРГИЙН ЦОМОГ:

Гэр бүлийн түүхийн хүч

*Өвөг дээдсийн маань өв надаар
дамжин үргэлжилсээр байгаа
бөгөөд амьдралаа илүү сайн болгоход
нөлөөлсөөр байгаа билээ.*

Амнэрис Пускасу

Дэлхийн II дайны өмнө, нэгэн зуны өглөө элэнц эцэг маань яг л бусад өдрийн адил нар мандахаас өмнө сэрэв. Тэрээр нов ногоон хөндий, Румын дахь тосгон руу харсан толгод дээрх байшингаасаа гарч ирэн, өглөөний шүүдэр буусан зүлгэн дээр сууж, гүн бодолд автан сууна. Уг бодол түүний оюун санаанаас гарахгүй нэлээн удаан явсан аж. Өрөвч зөөлөн сэтгэл, сониуч зантай бас боловсролтой уг эрийг тосгон дахь бүх хүн хайрлаж, хүндэтгэдэг байв.

Нар мандсаны дараа тэр гэртээ ороод, өөрийнхөө оршуулах

ёслолыг ямар байх нь сонин байна гэж мөн оршуулгын ажлын сургуулилт хийж үзэхийг хүсэж байгаагаа эхнэртээ хэлжээ. Тэр өдрөө товлож, авс худалдаж аваад, санваартан болон мэргэжлийн гашуудагчдыг хөлсөлж, грек ёс заншлын дагуу шаардлагатай бүх зүйлийг бэлдэв. Оршуулгын сургуулилт хийх өдөр ч ирлээ. Тосгоны голд дурсамжийн зоогийн ширээ засаж, гэр бүл нь бүгд хар хувцас өмсжээ. Мөн санваартан ч ирж, элэнц эцэг маань авсанд хэвтээд, илүү тав тухтай харж болохын тулд дэрээ янзлан, оршуулах ёслол эхэлсэн гэдэг. Ёслол дууссаны дараа тосгоны хүмүүсийг бүгдийг нь зоогонд урьсан ба өвөө маань өөрийн оршуулах ёслол дээр бүжиглэх мөрөөдлөө биелүүлсэн аж. Тэр дахиад 20 жил амьдарсан бөгөөд ойр ойрхон авсандаа багтаж байгаа эсэхээ шалгадаг байсан юм.

Зүгээр л нэг нэр, огноо төдийхөн биш

Би элэнц эцэгтэйгээ уулзаж байгаагүй ч түүний түүх өвөө эмээгээс маань уламжлан ирсэн түүхүүдээс хамгийн дуртай түүхийн нэг байсаар ирсэн. Өвөө эмээ маань ах, эгч, дүү нарт маань болон надад бидний өвөг дээдэс хаанаас ирсэн, ямар хүмүүс байсныг мөн тэдний үнэ цэнт зүйлс, хүсэл мөрөөдөл, найдварын талаарх түүхийг өдөр бүр ярьж өгдөг байв. Ням гаргийн зоог болгоны дараа өвөө эмээ маань гэр бүлийн зургийн цомгоо гаргаж ирээд, хуудас бүрийг эргүүлэхдээ түүхийг нь нүдэнд харагдтал ярьж, өмнөх зургаан үеэ



хайрлах хайрыг сэтгэл зүрхэнд маань суулгаж өгдөг байсан билээ. Тэдгээр нь зүгээр л нэг ард нь нэр, огноо тавьсан гэрэл зургууд байсангүй. Зурган дээрх хүн бүр эцэг эсвэл эх, хүү эсвэл охин, ах эсвэл эгч байсан бөгөөд тэдний өв гэр бүлийн бусад уламжлалын хамт надад уламжлагдан үлдсэн юм.

Сорилт бэрхшээлтэй үе дэх хүч чадал

Намайг 19 настай байхад эцэг эх маань болон ихэнх ойрын гэр бүлийн гишүүд нас барж, өвлөж үлдсэн ихэнх эд зүйл алга болж, хулгайд алдагдсан юм. Гэсэн хэдий ч байгалийн гамшиг, тэр ч бүү хэл үхэл ч устгаж чадахааргүй нэг зүйл үлдсэн байсан бөгөөд тэр нь гэр бүлийн гишүүн бүрийн өнгөрсөн, одоо, ирээдүйг холбосон гүүр байсан билээ. Тэдний хичээл зүтгэлийн ачаар гэр бүлийн гишүүдийн зүрх сэтгэлийг хооронд нь холбосон утас хэцүү цаг мөчийг даван туулах хүч чадлыг надад өгч байв.

Би эцэг эх, эмээ өвөөгөө нас барсны дараа цаашид амьдарч чадах хүч чадал байгаа эсэхдээ эргэлзэн, сэтгэлийн гүн шаналалд автсан юм. Би хөшигний цаанаас тэдний нөлөөг мэдрэх адислал хүлээн авсан бөгөөд энэ нь надад авралын төлөвлөгөө болон үхлийн дараах амьдралын тухай мөн хожим нь аврал нэн хэрэгтэй ариун сүмийн ёслолуудын талаар хүчтэй гэрчлэлтэй болоход тусалсан билээ. Би элэнц эцэг, авга болон нагац ах, эгчтэйгээ уулзаж байгаагүй ч тэдний

зурагтай гэр бүлийн хуучин зургийн цомгоо үзэх бүрдээ нүднээс нь өөрийгөө олж хардаг. Надаас өмнө амьдарч байсан бүх хүн одоогийн хувь хүн болоход маань нөлөөлсөн. Тэдний туршлага, мэргэн ухаан зан чанарыг маань төлөвшүүлж, амьдралыг маань удирдан чиглүүлсэн билээ.

Бага балчир байхад гэр бүлийнхний минь надад өгсөн хамгийн агуу бэлэг бол гэр бүлийн түүхийн талаарх мэдлэг бөгөөд би өөрөө өнгөрсөн, ирээдүй хоёрын холбоос юм гэсэн итгэл үнэмшил юм. Би энэ дэлхийд өөрийн түүхийг бүтээж амьдрахаар, тухайлбал эрэл хайгуул хийж, хал үзэн хашир сууж, үүнийгээ нандигнан хадгалахаар ирсэн гэдгээ бас мэднэ. Гэр бүлийн түүхийн тухай энэ мэдлэг амьдралын бүхий л саад бэрхшээлийн үед намайг дэмжин тусалж байсан.

Би хөшигний нөгөө талд буй гэр бүлийнхээ тухай мөн надад илүү сайхан амьдрал өгөхийн тулд тэдний гаргасан золиослолын талаар байнга боддог. Би хэзээ нэгэн өдөр гэр бүлээрээ дахин хамт байх боломжийг олгодог ариун сүмийн ёслолуудын тухай бас боддог. Би бас энэ бүхнийг боломжтой болгосон Аврагчийнхаа Цагаатгалын тухай боддог. Тэр бидэнд амьдрал өгөхийн тулд төлөөс төлсөн. Иймээс бид Түүнийг хайрлаж, өнөөдөр төдийгүй үүрд талархаж, шүтэн биширдэг юм. ■

Зохиогч нь АНУ-ын Нью-Йоркод амьдардаг.





Далын
Ахлагч Ларри
Р.Лорэнс



Дайн үргэлжилсээр

*Тэнгэрт эхэлсэн дайн өнөөдрийг хүртэл үргэлжилсээр.
Үнэндээ гэгээнтнүүд Аврагчийг эргэж ирэхэд бэлтгэж
байгаа энэ цаг үед дайн улам бүр ширүүсэж байна.*

Олон улсын мэдээ сонсдог хүн бүр бид “дайнууд хийгээд дайнуудын цуурхал сонсогдох” (С ба Г 45:26) үед амьдарч байгааг хүлээн зөвшөөрнө. Аз болж дэлхий дээрх хүн бүр дайнд тулалдаж байсан ахмад дайчид юм. Биднийг төрөхөөс өмнө, мөнх бус байдлын өмнөх оршихуйд эхлээд, өнөөдрийг хүртэл үргэлжилж байгаа дайнд бид чөтгөрийн дайчидтай тулалдсаар ирсэн.

Бид бие махбод хараахан хүлээн аваагүй байсан учраас тэнгэр дэх дайнд сэлэм, буу, тэсрэх бөмбөгөөр тулалдаагүй. Гэхдээ уг тэмцэл нь орчин үеийн ямар ч дайнтай адил ширүүн байсан ба үрэгдэгсдийн тоо хэдэн тэрбумаар хэмжигдэж байв.

Мөнх бус байдлын өмнөх дайнд үг, санаагаар болон мэтгэлцэх, итгүүлэх аргаар тулалддаг байсан юм (Илчлэлт 12:7–9, 11-ийг үзнэ үү). Сатаны арга барил хүмүүсийг айлгахад чиглэж байсан. Айдас бол итгэлийг үгүй хийх хамгийн шилдэг арга гэдгийг тэр мэдэж байсан. Тэр “Үнэхээр хэцүү юм байна,” “Цэвэрхэн эргэж ирэх боломжгүй,” “Хэт эрсдэлтэй юм байна,” “Та нар ямар үндэслэлээр Есүс Христэд итгэж байгаа юм бэ?” зэргээр маргах байсан байж болно. Тэр Аврагчид маш их атаархаж байсан.

Аз болж Бурханы төлөвлөгөө Сатаны худал үгийг ялан дийлсэн билээ. Бурханы төлөвлөгөөнд хүн төрөлхтний сонгох ёс зүйн эрх, агуу их золиослолыг багтаасан байсан. Бидний мэдэх Есүс Христ буюу Иехова сайн дураараа өөрийгөө золиосолж, бидний бүх нүглийн төлөө зовж шаналах болсон юм. Наманчилсан хүмүүст цэвэр байдалтай эргэн ирж, эцсийн эцэст Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болох боломж олгохын тулд Тэрээр өөрийн амийг ах дүүсийнхээ төлөө өргөхөд бэлэн байв. (Мосе 4:1–4; Аврахам 3:27-г үзнэ үү.)

*Тэнгэр дэх дайнд бид Тэнгэр дэх
Эцэгээ хайрлаж мөн дэмжсэн.
Бид Түүнтэй адил болохыг хүссэн.*

Иеховад Бурханы хүүхдүүдийн зүрх сэтгэлийг татахад тусалсан өөр нэгэн давуу зүйл нь тэргүүн тэнгэр элч Михаилаар удирдуулсан Түүнийг дэмжигчдийн хуваалцсан хүчирхэг гэрчлэл байсан юм (Илчлэлт 12:7, 11; С ба Г 107:54-ийг үзнэ үү). Мөнх бус байдлын өмнөх амьдралд Адамыг Михаил, харин Сатаныг Люцифер буюу “гэрэл тээгч”¹ гэж нэрлэдэг байсан. Энэ нь харанхуйн ханхүүд ахадсан нэр мэт санагдаж болох ч (Моисе 7:26-г үзнэ үү) судрууд Сатаныг унахаасаа өмнө “Эцэгийн дэргэд эрх мэдэлд байсан Бурханы нэг тэнгэр элч” (С ба Г 76:25–28-ыг үзнэ үү) байсан хэмээн заадаг.

Ийм их мэдлэг, туршлагатай сүнс яаж ийм гүнзгий ангалд унасан бэ? Үүний шалтгаан бардамнал байсан юм. Люцифер Бурханы хаант улсыг өөртөө авахыг хүсэж байсан учраас Тэнгэр дэх Эцэгийн эсрэг бослого гаргасан.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) “Beware of Pride” хэмээх нэгэн алдартай үгэндээ Люцифер “бусдаас илүү их хүндэтгэлийг авахыг хүссэн” ба “Бурханыг хаан сэнтийнээс нь буулгах бардам хүсэлтэй байсан”² хэмээн заажээ. Сатан хүмүүний сонгох эрхийг устгахыг хүссэн гэдгийг та нар бас сонссон байх. Гэхдээ энэ нь түүний ач ивээлээс хүртэхээ больсон цорын ганц шалтгаан биш юм. Тэр Эцэг, Хүүгийн эсрэг бослого гаргасан учраас тэнгэрээс хөөгдсөн (С ба Г 76:25; Моисе 4:3-ыг үзнэ үү).

Яагаад та бид чөтгөрийн эсрэг тулалдсан бэ? Бид үнэнч байсан учраас тулалдсан. Бид Тэнгэр дэх Эцэгээ хайрлаж, дэмжсэн. Бид Түүнтэй адил болохыг хүссэн. Харин Люцифер өөр зорилготой байв. Тэр Эцэгийг орлохыг хүссэн (Исаиа 14:12–14; 2 Нифай 24:12–14-ийг үзнэ үү). Сатан урвасан нь Тэнгэрлэг эцэг эхийг хэчнээн их шархлуулсныг төсөөлөөд үз. Бид судраас “тэнгэр түүнээс болж уйлсан” (С ба Г 76:26) гэж уншдаг.

Ширүүн тулалдааны дараа Михаил армитайгаа хамт ялсан юм. Тэнгэрийн дайчдын гуравны хоёр нь Эцэгийг дагахаар сонгосон (С ба Г 29:36-г үзнэ үү). Сатан



дагалдагчдынхаа хамт тэнгэрээс хөөгдсөн ч тэднийг тэр даруй гадаад харанхуй руу илгээгээгүй. Эхлээд тэднийг энэ дэлхий рүү илгээсэн (Илчлэлт 12:7–9-ийг үзнэ үү) бөгөөд энд Есүс Христ төрж, цагаатгагч золиослолоо хийх ёстой байсан.

Яагаад Сатаны элчүүдийг дэлхийд ирэхийг зөвшөөрсөн бэ? Тэд энд соригдохоор ирсэн хүмүүст сөрөг талыг үзүүлэхийн тулд ирсэн (2 Нифай 2:11-ийг үзнэ үү). Тэд эцэстээ гадаад харанхуй руу хөөгдөх үү? Тийм ээ. Мянган жилийн дараа Сатан элчүүдтэйгээ хамт үүрд хөөгдөнө.

Сатан өөрт нь богинохон хутагаа үлдсэн гэдгийг мэддэг. Есүсийн Хоёр дахь ирэлтийн дараа Сатан элчүүдтэйгээ хамт 1000 жилийн турш хоригдоно (Илчлэлт

20:1–3; 1 Нифай 22:26; С ба Г 101:28-ыг үзнэ үү). Хутацаа нь ойртож байгаа учраас хилэнцгийн хүч аль болох олон бодгалийг боолчлохоор шаргуу тэмцэж байна.

Илчлэгч Иоханд тэнгэр дэх дайныг нэгэн агуу үзэгдлийн хэсэг болгон харуулсан. Сатан хүн төрөлхтнийг уруу татахаар дэлхий рүү хэрхэн хөөгдөж байгааг түүнд үзүүлсэн билээ. Иохан үүнийг хараад, “Тазар ба тэнгис золгүй еэ! Яагаад гэвэл диавол үлэмж их уур хилэнтэйгээр та нар уруу бууж ирсэн. Өөрт нь богинохон хугацаа байгааг тэр мэдэж байгаа” (Илчлэлт 12:12) хэмээн хариулсан байна.

Сатан дэмий үрэх цаг байхгүй гэдгээ мэддэг учраас тэр цагийг хэрхэн зарцуулж байгаа бол? Төлөөлөгч Петр: “Диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг” (1 Петр 5:8) гэж бичжээ.

Юу Сатанд сэдэл төрүүлдэг вэ? Тэр хэзээ ч бие махбодтой, эхнэр хүүхэдтэй болж мөн бүрэн дүүрэн баяр баяслыг эдэлж чадахгүй учраас бүх эрэгтэй, эмэгтэй хүнийг “өөрийн адил зовлонт байж болохыг эрэлхийлдэг” (2 Нифай 2:27).

Чөтгөр бүх хүнийг, ялангуяа мөнхийн аз жаргалд хүрэх хамгийн их чадавхтай хүнийг өөрийн бай болгодог. Тэр өргөмжлөлд хүрэх зам дээр байгаа хэнд ч болов атаархдаг нь тодорхой. Сатан “Бурханы гэгээнтнүүдтэй дайтдаг, мөн тэднийг тойрон бүсэлдэг” (С ба Г 76:29) гэж сударт заадаг.

Тэнгэрт эхэлсэн дайн өнөөдрийг хүртэл үргэлжилсээр. Үнэндээ, гэгээнтнүүд Аврагчийг эргэж ирэхэд бэлтгэж байгаа энэ үед дайн улам бүр ширүүсэж байна.

Ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877) “энэ Сүмийн эхэн үед Сүм тархан хөгжиж, өсөн нэмэгдэж мөн өргөжих бөгөөд дэлхийн бүх үндэстний дунд сайн мэдээ түгэхийн хэрээр Сатаны хүч улам бүр өсөн нэмэгдэх болно”³ гэж бошиглосон билээ.

Хилэнцэт нөлөө дэлхийн нийгмийн тогтолцоонд хэрхэн нэвчин орж буйг харахдаа энэ бошиглол биелж байгааг бид бүгд хүлээн зөвшөөрөх байх гэж би бодож байна. Бид дайснаа ялахын тулд арга барилыг нь судлах хэрэгтэй гэж ерөнхийлөгч Янг заасан. Би Сатаны нотлогдсон дөрвөн арга барилыг мөн тэдгээрийг хэрхэн эсэргүүцэх тухай зарим санааг хуваалцъя.

Сатаны арга барил

1. Уруу таталт. Чөтгөр бидний оюун ухаанд ёс бус бодол санааг ямар ч ичгүүр сонжуургүй оруулдаг. Сатан бохир, муу бодол санааг бидэнд шивнэн, эргэлзээ

төрүүлдэг гэж Мормоны Номонд заадаг. Тэрээр донтуулагч хүслийнхээ дагуу үйлдэж, амин хувиа хичээх, шунахай сэтгэлээ хангахыг өөгшүүлэн дэмждэг. Тэр эдгээр санаа хаанаас ирж байгааг бидэнд мэдүүлэхийг хүсдэггүй учраас “Би бол чөтгөр биш, учир нь тийм юм гэж үгүй” (2 Нифай 28:22) гэж чихэнд маань шивнэдэг.

Бид өөрсөд рүүгээ чиглэсэн энэ уруу таталтыг хэрхэн сөрөн зогсох вэ? Хамгийн үр дүнтэй аргын нэг бол зүгээр л Сатаныг хөөж явуулах юм. Есүс ингэх л байсан.

Шинэ Гэрээнд уулан дээр уруу татагдсан Аврагчийн тухай сургамжтай түүх байдаг. Чөтгөр уруу татах болгонд Есүс хоёр шатлалт хамгаалах арга барилыг хэрэглэжээ. Эхлээд, Тэр Сатанд зайл гэж тушааж, дараа нь судраас эш татсан.

Та нарт нэг жишээ өгье. Есүс: “Зайл, Сатан аа!” хэмээн тушаагаад, “Чи өөрийн Бурхан Эзэндээ мөргөж, зөвхөн Түүнд үйлчил гэж бичигдсэн байдаг юм” (Матай 4:10) гэсэн. Дараагийн шүлэгт: “Тэгээд диавол Түүнийг орхиод, тэнгэр элч нар ирж Түүнд үйлчилж эхлэв” (Матай 4:11) гэж гардаг. Аврагчийн хамгаалалт үнэхээр үр дүнтэй байсан!

Ерөнхийлөгч Хибэр Ж.Грантын (1856–1945) намтарт ерөнхийлөгч Грант залуу байхдаа хэрхэн чөтгөрийн эсрэг зогссон талаар өгүүлдэг. Сатан чихэнд нь шивнэн, зүрх сэтгэлд нь эргэлзээ төрүүлэхийг завдаж байгааг ерөнхийлөгч Грант мэдээд, зүгээр л чангаар “Ноён чөтгөр өө, дуугүй бай”⁴ гэж хэлжээ.

Уруу таталттай нүүр тулах үедээ Сатанд яв гэж хэлэх эрх танд бий. “Диаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна” (Иаков 4:7) гэж сударт заадаг.

Аврагчийн өөр нэг хамгаалалтын арга нь судраас эш татах байсан. Есүстэй адил судруудыг чээжлэх нь маш хүчтэй нөлөөтэй. Судрын шүлгүүд нь сүнслэг зэр зэвсгийн нөөц болж чадна.

Та уруу татагдахдаа “Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтун,” “Дайснаа хайрла,” эсвэл “бодол санааг чинь ариун журам зогсолтгүй чимэн гоёг” (Египетээс гарсан нь 20:8; Лук 6:27; С ба Г 121:45) зэрэг зарлигийг эш татаж болно. Судрын хүч Сатаныг сүрдүүлэхээс гадна Сүнсийг зүрх сэтгэлд тань авчирч, дахин баталж, уруу таталтын эсрэг хүчирхэгжүүлдэг.

2. Худал үгс, хууран мэхлэлт. Судрууд Сатан “худал бүхний эцэг” (2 Нифай 9:9) гэдгийг илчилдэг. Тэр танд “Чи хэзээ ч юуг ч зөв хийж чадахгүй,” “Чи өршөөгдөх боломжгүй хэт их нүгэлтэй нэгэн,” “Чи хэзээ ч өөрчлөгдөхгүй,” “Хэн ч чамайг хайхардаггүй,” “Чамд ямар ч



авьяас чадвар байхгүй” гэх мэт санааг шивнэж байвал түүнд бүү итгэ.

“Чи зүгээр л туршлага хуримтлуулахын тулд бүх зүйлийг ядаж нэг удаа хийж үзэх хэрэгтэй. Ганцхан удаа хийх нь чамд ямар ч хор уршиг учруулахгүй” гэх нь түүний өөр нэгэн байнга хэрэглэдэг худал үгс юм. Нүгэл нь донтуулдаг болохыг танд мэдүүлэхгүй байх нь түүний бяцхан бохир нууц билээ.

Сатаны тан дээр хэрэглэх гэж үзэх өөр нэг үр дүнтэй худал үгс нь “Хүн бүхэн л үүнийг хийдэг шүү дээ. Зүгээр ээ, зүгээр” гэх үгс юм. Зүгээр биш ээ! Иймээс бусад бүх хүн телестиел хаант улс руу явж байсан ч та тийшээ явмааргүй байна гэдгээ чөтгөрт хэл.

Хэдийгээр Сатан танд худал хэлж болох ч Сүнс танд үнэнийг хэлэнэ гэдэгт бүү эргэлз. Иймээс Ариун Сүнсний бэлэг юунаас ч илүү чухал.

Чөтгөрийг “агуу хууран мэхлэгч”⁵ хэмээн нэрлэсээр ирсэн. Тэр Их Эзний санал болгосон бүх үнэн зарчмыг дуурайж хийх гэж оролддог.

Дуураймал зүйл эсрэг тэсрэг байдлаас өөр гэдгийг сана. Цагааны эсрэг тал нь хар боловч цагааны дуураймал нь цайвар эсвэл цагаан саарал байж болно. Дуураймал зүйл нь итгэмтгүй хүмүүсийг хууран мэхлэхийн тулд бодит зүйлтэй төстэй байдаг. Тэдгээр нь ямар нэгэн сайн зүйлийн мушгин гуйвуулсан хэлбэр буюу хуурамч мөнгөтэй адил үнэ цэнгүй. Би танд үүнийг тайлбарлан харуулъя.

Сатаны итгэлийн дуураймал хэлбэр нь мухар сүсэг юм. Харин хайрын дуураймал хэлбэр нь шунал тачаал. Тэрээр санваарыг санваараар мэргэших явдалаар, харин Бурханы гайхамшигийг илбэ, ид шидээр дуурайлгадаг.

*Сүнс та нарт үнэнийг хэл-
нэ гэдэгт бүү эргэлз. Иймээс
Ариун Сүнсний бэлэг үнэхээр
юу юунаас ч илүү чухал юм.*



Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлт Бурханаас томилогдсон ба харин ижил хүйстний гэрлэлт нь үүний зөвхөн дуураймал хэлбэр юм. Энэ нь өсөж үржих, өргөмжлүүлэх хоёрын аль алиныг авчрахгүй. Хэдийгээр түүний дуураймал зүйлс олон хүнийг мэхэлдэг ч гэлээ бодит зүйл биш билээ. Тэдгээр нь мөнхийн аз жаргалыг авчрахгүй.

Бурхан дуураймал зүйлсийн талаар Сургаал ба Гэрээнд сэрэмжлүүлсэн байдаг. Тэр “Сэнхэрдэггүй тэр нь Бурханаас бус, мөн харанхуй болой” (С ба Г 50:23) хэмээн хэлсэн.

3. Зөрчилдөөн. Сатан нь зөрчилдөөний эцэг юм. Аврагч “тэрбээр хүмүүний зүрх сэтгэлийг нэг нэгэндээ уурлан зөрчилдөхөд өдөөн хатгадаг” (3 Нифай 11:29) хэмээн заадаг.

Чөтгөр олон зууны туршлагаараа зөрчилдөөн байгаа

газар Их Эзэний Сүнс байдаггүй гэдгийг мэдсэн билээ. Сатан Абелыг хөнөө хэмээн Каиныг ятгаснаас хойш ах дүү нарт өөр хоорондоо зөрчилдөн, тэмцэлдэхэд нөлөөлсөөр ирсэн. Тэр гэрлэлтэд мөн тойргийн гишүүдийн дунд болон номлолын хамтрагчдын хооронд зөрчил үүсгэдэг. Тэр сайн хүмүүсийг хэрэлдэхэд баясаж суудаг. Тэр ням гарагт, яг сүм рүү явах мөчид, даваа гарагт гэр бүлийн үдэш хийхэд мөн хосууд ариун сүмийн хуралдаанд суухын яг өмнө гэр бүлийн хэрүүлийг эхлүүлэх гэж оролдог. Түүний цагийг урьдчилан таах боломжтой.

Гэр оронд эсвэл ажлын газарт тань зөрчилдөөн гарвал тэр даруй хийж байгаа зүйлээ орхиод, эвлэрэх гэж оролд. Хэн зөрчилдөөнийг эхлүүлсэн нь чухал биш.

Зөрчилдөөн нь ихэвчлэн хэн нэгнээс бурууг хайснаар эхэлдэг. Иосеф Смит “бид бусдын алдаа дутагдал дээр анхаарал төвлөрүүлэхэд чөтгөр биднийг маш зөв шударга байна хэмээн зусарддаг”⁶ гэж заажээ. Үүнээс үзэхэд, өөрийн зөвт байдалд итгэх нь жинхэнэ зөв шударга байдлын дуураймал хэлбэр юм.

Сатан Сүмд зөрчилдөөн үүсгэх дуртай. Тэрээр Сүмийн удирдагчдаас өө хайж олоход мэргэшсэн нэгэн. Урвалт руу хөтлөх эхний алхам бол Сүмийн удирдагчдад итгэх итгэлээ алдах явдал гэдгийг Иосеф Смит гэгээнтнүүдэд анхааруулжээ.⁷

Бараг бүх Мормон шашны эсрэг ном зохиол Иосеф Смитийн зан чанарын талаарх худал хуурмаг дээр тулгуурласан байдаг. Сэргээлтийн захиас ариун ойн цоорхойд юу болсон талаарх бошиглогчийн түүхтэй холбоотой учраас дайсан Иосефийн нэр хүндийг унагаах гэж шаргуу зүтгэдэг. Чөтгөр гишүүдийг Сэргээлтийн тухай гэрчлэлдээ эргэлзэхэд хүргэхийн тулд урьд өмнөхөөсөө ч илүү шаргуу ажиллаж байна.

Манай эрин үеийн эхэнд олон санваартан ах бошиглогчид үнэнч байж чадаагүйдээ харамсан гашуудсан. Тэдний нэг нь зөв шударга бус үйлдлийнхээ улмаас Сүмийн гишүүнчлэлээс хасагдсан Лайман И.Жонсон байсан юм. Тэр хожим нь: “Би үүнд дахин итгэхийн тулд баруун гараа тасдан өгөхөд ч бэлэн байна. Тэр үед би баяр баяслаар дүүрэн байсан. Би сайн сайхан мөрөөдөлтэй байж, өглөө сэрэхэд сүнс маань баяртай байдаг байсан. Би өдөр, шөнийн алинд ч амар амгалан, баяр баясгалан, талархлаар дүүрэн байсан. Харин би одоо дэндүү харанхуй, өвчин, зовлон, гуниг, харуусал дунд байна. Би тэр үеэс хойш дахин аз жаргалтай цаг мөчийг харсангүй”⁸ хэмээн Сүмийг орхисондоо харуусан гашууджээ.

Эдгээр үгийн талаар тунгаан бод. Энэ нь Сүмийн гишүүдэд сэрэмжлүүлж байна.

Би Сүмд хөрвөсөн гишүүн юм. Би АНУ-ын Аризона дахь Анагаах Ухааны Их Сургуульд сурч, 23 настай ганц бие залуу байхдаа баптисм хүртэж билээ. Сатан сонирхогчдыг үнэнийг эрэлхийлэх үед нь төөрөгдүүлж, сэтгэлээр унагахын тулд хэрхэн ажиллагийг би өөрийн биеэр мэднэ.

Би өсвөр насандаа хожмын үеийн гэгээнтэн найзуудынхаа үлгэр жишээг хардаг байсан. Тэдний амьдралаа авч яваа байдал надад гүн сэтгэгдэл төрүүлдэг байж билээ. Би Сүмийн талаар илүү ихийг мэдэх шийдвэр гаргасан ч мормон шашныг судалж байгаага хэнд ч мэдэгдэхийг хүсээгүй. Би найз нөхдийнхөө дарамт шахалтаас зайлсхийхийн тулд нууцаар судлахаар шийдсэн юм.

Энэ нь интернэт үүсэхээс олон жилийн өмнөх үйл явдал тул тэр үед би нийтийн номын сан руу явдаг байв. Би Мормоны Ном болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Лигранд Ричардсын (1886–1983) *A Marvelous Work and a Wonder* нэртэй номыг олсон. Би эдгээр номыг маш их хүсэл эрмэлзэлтэй уншиж эхэлсэн бөгөөд надад урам зориг өгсөн юм.

Сүнс маань илүү ихийг мэдэхийг хүсэж байхад Сатан чихэнд минь шивнэж эхлэв. Тэр бүрэн үндэслэлтэй болгохын тулд Сүмийг шүүмжлэгчдийн бичсэн зүйлсийг бас унших ёстой гэж хэллээ. Би нийтийн номын сан руу буцаж очоод, хайж эхлэв. Мэдээж, би бошиглогч Иосефийн нэр хүндийг гутаасан нэгэн ном оллоо.

Мормон шашны эсрэг энэ номыг унших нь намайг эргэлзэхэд хүргэсэн юм. Би эрэл хайгуулыг маань чиглүүлж байсан тэр сайхан сүнс, нөлөөллийг алдав. Би сэтгэлээр унаж, үнэнийг эрж хайх ажлаа орхих гэж байлаа. Би мормон шашны эсрэг ном уншиж байхдаа хариу авахаар залбирч байсан гээд бод доо!

Харин гайхалтай нь тэр үед Бригам Янгийн Их Сургуульд сурч байсан дунд сургуулийн найз маань

над руу ярьсан юм. Тэр намайг Ютад зочлон ирэхийг урьж, байгалийн сайхантай танилцах аялал болно гэж амлав. Тэр намайг Сүмийн талаар нууцаар судалж байгааг огт мэдээгүй байлаа.

Харин би түүний урилгыг хүлээн авав. Найз маань Ариун сүмийн талбай руу очихын тулд Солт Лэйк хот руу явахыг санал болголоо. Тэр намайг саналыг баяртай хүлээн авахад ихэд гайхаж билээ. Надад Иосеф Смит болон Сэргээлтийн талаар үнэнийг олж мэдэх ямар их сонирхол байгааг тэр мэдээгүй байв.

Ариун сүмийн талбай дахь номлогч эгч нар үнэхээр их тусалсан. Тэд өөрсдөө ч мэдэлгүй олон асуултад маань хариулсан юм. Тэдний гэрчлэл надад “эргэлзээн-дээ эргэлзээ[хэд],” нөлөөлж, итгэл маань өсөж эхэлсэн



**Чөтгөр бүх хүнийг, ялангуяа
мөнхийн аз жаргалд хүрэх
хамгийн их чадавхтай хүнийг
өөрийн бай болгодог.**

билээ. Сэтгэлийн угаас гарсан гэрчлэлийн хүчийг хэт-рүүлэн үнэлэн гэж үгүй.

Найз маань ч гэсэн надтай гэрчлэлээ хуваалцаж, Бурханд залбирч, энэ Сүм үнэн эсэхийг асуухад намайг урив. Аризона руу буцах урт замын турш би анх удаа “чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр” (Моронай 10:4) итгэлээр залбирсан юм. Уг аялын үеэр сууж явсан машин маань хэсэг хугацаанд гэрлээр дүүрэх шиг санагдсан. Гэрэл харанхуйг сарниулан хөөдөг гэдгийг би мэдэж авав.

Намайг баптисм хүртэхээр шийдсэний дараа чөтгөр эцсийн дайралтаа хийж билээ. Тэр гэр бүлийнхэн дээр маань ажиллаж, тэд ч миний зоригийг мохоохын тулд чадах бүхнээ хийн, баптисмын ёслолд маань оролцохоос татгалзав.

Би ямар ч байсан баптисм хүртэж, тэдний зүрх сэтгэл ч бага багаар зөөлөрсөн юм. Тэд надад гэр бүлийн түүхээ судлахад тусалж эхэлсэн. Хэдэн жилийн дараа би эрэгтэй дүүдээ баптисм хүртээсэн бөгөөд намайг Ютад зочлон ир гэж урьсан найз маань одоо миний эхнэр болсон.

4. Урам хугарах. Өөр ямар ч арга үр дүнгээ өгөхгүй байгаа үед Сатан энэ аргыг хамгийн их итгэлтэй гэгээнтнүүдэд ашигладаг. Миний хувьд урам хугарч эхлэх үедээ хэн намайг сэтгэлээр унагахыг оролдож байгааг мэддэг. Энэ нь намайг яаж ч байсан чөтгөрт дийлдэхгүйн тулд уурандаа баяр хөөртэй болоход хүргэдэг.

Хэдэн жилийн өмнө ерөнхийлөгч Бэнсон “Do Not Despair” буюу битгий сэтгэлээр уна гэсэн сэдвээр үг хэлсэн юм. Энэхүү гярхай, гүн ойлголт өгсөн үгэндээ тэр: “Сатан гэгээнтнүүдийн горьдлогыг таслах, урмыг хугалах, бухимдуулах, сэтгэлээр унагаах зэрэг байдлаар дийлэхийг илүү их хичээх болжээ”¹⁰ хэмээн анхааруулсан. Ерөнхийлөгч Бэнсон Сүмийн гишүүдэд эрэмжтэй байхыг уриалан, урам хугарахтай тэмцэх 12 бодит зөвлөгөөг өгсөн юм.

Түүний зөвлөсөн зүйлд бусдад үйлчлэх, шаргуу хөдөлмөрлөх, залхуурлаас зайлсхийх түүнчлэн дасгал хийх, боловсруулаагүй хоол хүнс хэрэглэх зэргээр эрүүл мэндэд ашиг тустай дадал хэвшлийг дагах, санваарын адислалыг эрэлхийлэх, сүнсийг өдөөх дуу хөгжим сонсох, адислалаа тоолох, зорилго тавих зэрэг зүйлс орсон байна. Судруудад зааснаар хамгийн чухал нь Сатаныг ялан дийлэхийн тулд үргэлж залбирах ёстой (С ба Г 10:5-ыг үзнэ үү).¹¹

*Сатан бол
хамгийн сул дорой гэгээнтнийг залбирахаар
өвдөг сөхрөхөд л¹² дагжин чичирдэг.*

Чөтгөрийн хүч хязгаартай гэдгийг мэдэх нь чухал. Бурхан Тэргүүтэн тэдгээр хязгаарыг тогтоодог ба Сатан тэдгээрийг давах эрхгүй. Жишээлбэл, судрууд бидэнд “бага насны хүүхдүүдийг уруу татах хүч Сатанд өгөгдсөн нь үгүй” (С ба Г 29:47) гэдгийг баталдаг.

Түүнээс гадна Сатан бидний бодол санааг өөрсдөө хэлэхгүй л бол мэдэхгүй гэдэг нь өөр нэгэн чухал хязгаарлалт юм. Их Эзэн “Бурханаас өөр чиний санаа бодол хийгээд зүрх сэтгэлийн тань хүсэл эрмэлзлэлийг мэдэх хэн ч үгүй” (С ба Г 6:16) хэмээн тайлбарласан.

Тиймээс л Их Эзэн “бүү бувтна” (С ба Г 9:6) мөн “Чи хөршийнхөө талаар шүүмжлэх . . . ёсгүй” (С ба Г 42:27) зэрэг зарлигийг бидэнд өгсөн байх. Хэрэв та хэл амаа хазаарлаж чадвал (Иаков 1:26-г үзнэ үү) чөтгөрт хэт их мэдээлэл өгөхгүй байх боломжтой. Тэр бувтнаж, гомдоллож, шүүмжилж байгааг сонсохдоо нарийн тэмдэглэл хөтөлж байдаг. Таны сөрөг үг хэллэг дайсанд сул талыг тань харуулдаг.

Харин надад та нарт хэлэх сайхан мэдээ байна. Бурханы арми Люциферийн армиас их. Та эргэн тойрноо хараад, “Дэлхий улам бүр ёс бус болж байна даа. Сатан дайнд ялж байгаа бололтой” гэж бодож байж магадгүй. Үүнд бүү хуурт. Үнэндээ бид тоогоороо дайснаас илүү. Бурханы хүүхдүүдийн гуравны хоёр нь Эцэгийн төлөвлөгөөг сонгосон гэдгийг санаарай.

Ах, эгч нар аа, та нар Их Эзэний талд тулалдахад анхаар. Та нар Сүнсийн сэлмийг авч явахад анхаар.

Та нар амьдралынхаа эцэст төлөөлөгч Паултай хамт “Би сайн тэмцлээр тэмцсэн. Би замаа дуусгасан, итгэлээ сахисан” (2 Тимот 4:7) гэж хэлээсэй хэмээн би залбирч байна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Судруудын удирдамж, “Люцифер,” scriptures.lds.org.
2. Эзра Тафт Бэнсон, “Beware of Pride,” *Ensign*, 1989 оны 5-р сар, 5.
3. *Discourses of Brigham Young*, эмхэтгэсэн Жон А. Видцөү (1954), 72.
4. Францис М. Гиббонс, *Heber J. Grant: Man of Steel, Prophet of God* (1979), 35–36-г үзнэ үү.
5. Жишээлбэл, Дийтр Ф. Угдорф, “Та нар Түүнд чухал,” *2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 22; Гордон Б. Хинкли, “The Times in Which We Live,” *Аиахона*, 2002 оны 1-р сар, 86-г үзнэ үү.
6. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 563.
7. *Teachings: Joseph Smith*, 318-ыг үзнэ үү.
8. Лайман И. Жонсон, Бригам Янгийн бичсэн нийтлэлд, *Deseret News*, 1877 оны 8-р сарын 15, 484.
9. Дийтр Ф. Угдорф, “Ирж, бидэнтэй нэгд,” *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 29.
10. Эзра Тафт Бэнсон, “Do Not Despair,” *Ensign*, 1974 оны 11-р сар, 65.
11. Эзра Тафт Бэнсон, “Do Not Despair,” 65–67-г үзнэ үү.
12. Вилиам Каупэр, Орбэрт Андрыозийн, *The Concise Columbia Dictionary of Quotations*-ны эмхэтгэлд, (1987), 78.

ИТГЭЛИЙН ХӨРӨГ

Скайдрайт миний уулзаж байсан хамгийн аз жаргалтай хүмүүсийн нэг юм. Түүний амьдрал төгс зураг шиг санагддаг. Тэр бага байхдаа өөрийг нь болон охин дүүг нь асарч халамжлах чадваргүй архичин ээжтэйгээ амьдардаг байжээ. Скайдрайт дүүгээ өлсөж үхэх үед гарыг нь атгаж байв. Скайдрайт найман настайгаасаа эхлэн хэд хэдэн асрамжийн газраар дамжин амьдарсан юм. Тэр өшиглүүлж, зодуулж, залбирах эрхээ хүртэл хасуулж байлаа. Түүнд яг боол шиг хандаж байв.

Тэр олон жилийн турш амиа хорлох тухай бодож байсан. Олон жилийн дараа Скайдрайт итгэл найдвар эрэн, ХҮТ цуглааныг байр руу оржээ.

ГЭРЭЛ ЗУРАГЧИН ЛЭСЛИЙ НИЛССОН

Скайдрайт Бокума

Латвийн Лиэпажа хот

“Номлогч эгч надтай мэндлээд, инээмсэглэсэн. Би түүнийг тэнгэр элч юм байна гэж бодсон шүү. Энэ өдрөөс эхлэн миний амьдрал өөрчлөгдсөн юм. Одоо 17 жил өнгөрчээ. Амиа хорлоё гэсэн бодол ул мөргүй алга болж, би эерэг бодолтой болсон. Ачаа дарамттай үедээ би тэдгээрийг Бурханд үүрүүлдэг болж, бүх зүйлд Түүнд найдаж сурсан. Миний хувьд амьдрал үнэхээр сайхан байна.”

Амиа хорлох гэж буйг нь олж мэдээд, түүнд хэрхэн туслах талаар мэдэж авахыг хүсвэл lds.org/go/41739 руу орж үзнэ үү.





ТЭР ДУУГ БИТГИЙ ТАВИАЧ, ГУЙЖ БАЙНА

Өмнө нь би гэр бүлийн хамт Мексикийн Веракрузад амьдарч байсан бөгөөд тэнд хүүхдүүд маань бага сургуульд явдаг байв. Өглөө бүр гурван хүүхдээ сургуульд нь явуулахаар бэлдэж байхдаа бид нэгэн залуу хөтөлгчийн хөтлөн явуулдаг аятайхан хөтөлбөртэй, хотын хамгийн нэр хүндтэй радиог сонсдог байлаа.

Бид тун сонирхол татсан нэгэн дууг сонсож эхлэв. Шүлгийнх нь үгийг анхааралтай сонсоход хэдийгээр бүдүүлэг биш ч гэсэн бэлгийн харьцааг далдуур санал болгосон, эрээ цээргүй байгааг ойлгохоор байв.

Би хүүхдүүддээ “Бид ийм үг хэллэгтэй дуу сонсож болохгүй” гэж эрс шийдэмгий хэлсэн юм. Тэд дууны үгэнд онцгой анхаараагүй ч аянд нь ач холбогдол өгч, амандаа аялж байлаа.

Тэд намайг стерео системийн дууг хаахыг хараад, юу хийж байгааг маань асуув. “Би радионы нэвтрүүлэгчид энэ дууг хөтөлбөрөөсөө хас гэж хэлнэ.” Тэдний гайхширсан байдал намайг дараагийн алхмыг хийхэд хүргэв.

Утсаа аваад, радио руу залгасандаа би өөрөө ч, тэд ч итгэсэнгүй. Би хариу өгнө гэж бодоогүй ч шоун дээр сонссон радионы хөтөлгч бараг тэр даруй дуудлагыг маань авсанд гайхлаа.

Өглөөний яг тэр цагт олон гэр бүл радио сонсдог учраас энэ дууг тавихтай санал нийлэхгүй байгаагаа

Биднийг радиогоор тун сонирхол татсан нэгэн дууг сонсох үед би шүлгийнх нь үгийг анхааралтай сонсож эхлэв.

би түүнд хэлэв. Тэр надаас ямар дуугаар солихыг хүсэж байна гэж үнэхээр эелдэг асуусан учраас би зөвхөн хүүхдүүдийг гэртээ байх цагт тэр дууг тавихгүй байхыг хүссэн юм.

Миний утасны дуудлага нэвтрүүлэгт нөлөөлөх эсэхийг би мэдээгүй ч радионы хөтөлгч намайг сонсонд үнэхээр их баярласан. Харин дараагийн хэдэн өдөр хүслийг минь хүлээн авсан болохыг би олж мэдсэн билээ.

Бид шийдвэр гаргаж, үр хүүхдээ сөрөг нөлөөнөөс хамгаалахад шаардлагатай зүйлийг хийх боломж гарсан үед зоригтой байх хэрэгтэй гэдгийг энэ үйл явдал надад баталсан. Бид ингэж чадвал Ариун Сүнс бидний байнгын хамтрагч байх болно. ■

Мариа Хэрнандэз, АНУ-ын Техас муж



АЛДАГДСАН ТҮРИЙВЧ

Би саяхан шинэ газар руу нүүсэн бөгөөд Сүмийн хэдэн гишүүнээс гэр орныхоо ажилд туслахыг хүссэн юм. Тэднийг тусалж байх хооронд би ажлаа хийж дуусгахад шаардлагатай эд материалыг худалдаж авахаар гарлаа. Би ажлаа хийж дууссаныхаа дараа түрийвчээ байхгүй байгааг анзаарав. Түрийвчин дотор миний бүх хувийн бичиг баримтаас гадна өглөөхөн үйлчлүүлэгчээсээ хүлээн авсан мөнгө байсан учраас би маш их тэвдлээ. Би худалдан авалт хийсэн газар руугаа буцаж, явсан замаараа явж шалгасан боловч олсонгүй. Гэр рүүгээ буцаж очоод, хаа нэгтээ унагасан байж магадгүй гэж хайсан боловч бас л олсонгүй. Би ч бүх бичиг баримтаа шинээр авах хэрэг гарах нь дээ гэж бодож эхэллээ. Тэгээд гэрээсээ гарах гэж байтал найз маань “Чи залбирсан уу?” гэж асуув.

Тэр даруй “Мэдээж, би аль хэдийн залбиралгүй дээ!” гэсэн бодол зурсхийв.

Үнэн хэрэгтээ би чин сэтгэлээсээ залбираагүй байсан юм. Харин би өөрийнхөө хүслийг Тэнгэрлэг Эцэгт тулгаж, түрийвчээ олоход туслах үүргийг Түүнд оногдуулсан байлаа. Яг тэр үед би Исаиа 55:8 дахь “Учир нь Миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр” хэмээх судрыг санасан юм.



Би Тэнгэрлэг Эцэгээс эхнэр, хүүхдүүдийн маань итгэлийг хүчирхэгжүүлэхийн тулд залбиралд маань хариулахыг гуйсан юм.

Намайг ням гарагт сүм дээр очиход урьд өдөр нь надтай хамт байсан гишүүн түрийвчээ олоосой гэж Тэнгэрлэг Эцэгт чин сэтгэлээсээ залбирсан тухайгаа хэллээ. Тэр намайг түрийвчээ олох юм байна гэж мэдэрснээ хэлэв. Дараа нь би хувиараа судраас судлахаар сууж, Далын ахлагч асан Жин Р.Күкийн *Receiving Answers to Our Prayers* (Залбирлынхаа хариултыг хүлээн авах нь) үгийг уншиж эхэлсэн юм. Эхний хуудсанд минийхтэй адил асуудлын тухай түүх байв. Ахлагч Күкийн хүү түрийвчээ гээсэн тул гэр бүл нь хамтдаа цуглаараад, түрийвчийг олохын төлөө Их Эзэнд хандан залбирсан байна.

Энэ үйл явдлын талаар уншсаныхаа дараа би сурсан зүйлээ хэрэгжүүлэхээр эхнэр, хүүхдүүдээ цуглууллаа. Бид тойрог болоод, хүн

нэг бүр залбирч, энэ нь Их Эзэний хүсэл мөн юм бол түрийвчийг олоход тусална хэмээн найдаж гуйв.

Би залбирлын хүчийг өмнө нь харж байсан бөгөөд дараа нь ганцаараа үлдэн, Тэнгэрлэг Эцэгээс эхнэр, хүүхдүүдийн минь итгэлийг хүчирхэгжүүлэхийн тулд залбиралд маань хариулахыг гуйсан юм.

Маргааш нь нэгэн эрэгтэй над руу утсаар ярьж, мөнгөтэй түрийвчийг маань олсон гэж хэллээ. Залбирлыг маань хариулж, гэр бүлийн минь итгэл хүчирхэгжсэн учраас би яг л хүүхэд шиг мэгшин уйлж билээ.

Тэнгэрлэг Эцэг харж хандах маш олон хүүхэдтэй ч бидний хүн нэг бүрд Өөрийн цаг хугацаа, тааллаар хариулдаг гэдгийг би мэднэ. ■ Луйз Марселино, Бразилийн Гоиас

ҮҮДНИЙ ТАНХИМД АВАРСАН НЬ

Нөхөр маань ихэнх ням гарагт ажилладаг тул би дөрвөн хүүгээ сүм рүү ганцаараа авч явах үүрэгтэй үлддэг. Нэгэн ням гарагт ариун ёслолын цуглааны үеэр хоёр бага маань хоорондоо таарамж муутай байлаа. Би аль нэг хүүгийнхээ анхаарлыг номоор татвал нөгөөдөх нь номыг авах гэнэ. Би хөнгөн зууш, тоглоом, будгийн харагдаа гэх мэт зүйлээр анхаарлыг нь татахыг оролдсон ч аль нь ч бүтсэнгүй. Би ганцхан цаг ч томоотой сууж чадахгүй байгаа хөвгүүдтэйгээ зууралдаад цөхрөнгөө барж байлаа.

Би цүнхнээсээ жижиг тоглоом гаргаж ирээд, нэг настай хүүдээ өглөө. Тэр даруй гурван настай Тайсон хашхичин, дүү рүүгээ дайрч, тоглоомыг нь булаахыг завдав. Би ичиж зовсондоо орилж хашхичсан, зодолдсон хоёр хүүгээ аваад үүдний танхим руу гарлаа.

Тэр даруй би мэлмэртэл уйлав. Яагаад ийм хэцүү байгаа юм бэ? Би гэр бүлээ сүм дээр авчран, Тэнгэрлэг Эцэгийн хүссэнийг хийсэн биз дээ, тийм биш гэж үү? Харин би залхсан байв. Долоо хоног бүр ганцаараа ариун ёслолын цуглаанд хөвгүүдтэйгээ тэмцэлдэхээс ядарч, ичиж байлаа. Би дахиж ирэхийг хүсэхгүй байв.

Энэ бодол миний оюун санаанд 15-хан секунд л байсан бөгөөд зүс таних төдий нэгэн эгч араас үүдний танхим руу гарч ирлээ. Түүний нэрийг Бэус эгч гэдэг. Нөхөр нь бишопын зөвлөлд үйлчилдэг бөгөөд хүүхдүүд нь өсөж том болсон учраас тэр ихэвчлэн ганцаараа сууж харагддаг. Тэр

Би ганцхан цаг ч томоотой сууж чадахгүй байгаа хөвгүүдтэйгээ зууралдаад цөхрөнгөө барж байлаа.





ЧАДСАН ШҮҮ!

надад “Та үргэлж ганцаараа байх юм. Таны үнэхээр их хичээж байгааг би харж байна. Тайсонг надтай хамт суулгаж болох уу?” гэж хэллээ. Би юу гэж хариулахаа ч мэдсэнгүй. Намайг зүгээр л толгой дохитол тэр хүүг маань хөтлөн явав. Хүү минь тайван, аз жаргалтай болж, ариун ёслолын танхим руу эргэж орлоо.

Би ч нулимсаа арчин, бага хүүгээ аваад, цуглааны үлдсэн цагт амар тайван суухаар ариун ёслолын танхим руу даруухан гэгч эргэн алхав.

Дараагийн ням гарагт бид ариун ёслолын цуглаандаа ирэнгүүт Тайсон шинэ найзаа хайв. Оройдоо тэр “Тэнгэрлэг Эцэг минь, Бэус эгчийг өгсөнд баярлалаа. Би түүнд маш их хайртай!” гэж залбирдаг байлаа.

Одоо тэр цагаас хойш хэдийн 3 жил өнгөрсөн ч Тайсон ариун ёслолын танхимаас Бэус эгчийг хайсан хэвээр. Өнгөрсөн жил түүнийг Тайсоны Хүүхдийн хэсгийн багшаар дуудсан бөгөөд тэр хамгийн аз жаргалтай бяцхан хөвгүүн байдаг байв.

Би Бэус эгчид мөн түүний бусдыг хайрлаж, үйлчлэх хүсэлд маш их талархдаг. Бид Аврагчтай адил үйлчлэх юм бол бусдын амьдралыг адисалж чадна гэдгийг би мэднэ. ■ Крист Льюис, АНУ-ын Юта муж

Би нэгэн ням гарагт бишопын хувьд ярилцлага хийж байхдаа нэгэн сайн найзтайгаа хамт суун, тулгарч байгаа сорилт бэрхшээлийн нь талаар ярилцах боломж гарсан юм. Сэтгэлийг нь зовоож буй зүйлсийг хэдэн минут сонссоны дараа тэр судраа тууштай унших шаардлагатай болохыг би мэдэрлээ. Би бас түүний бишопын хувьд асуудал болоод байсан зүйлээ буюу судраа илүү тогтмол унших хэрэгтэй болохыг сануулсан юм. Тиймээс би түүнд судраас илүү тууштай судлах хүсэлтэй “хариуцлагатай хамтрагчид” болж болохыг санал болгов.

Бид өдөр бүр судраа уншиж дуусаад, бие биен рүүгээ *Чадсан шүү!* гэж мессеж бичдэг байлаа. Аль нэг нь тухайн өдөр судраа уншсан эсэхийг сонсохоор хүлээж байгаа гэдгийг мэдэх нь бид хоёрт хоёуланд агуу хөдөлгөгч хүч болсон билээ. Хэрэв хэн нэгэн нь мартсан байвал мессеж түүнд сануулга болдог байв. Хэрэв аль нэг нь мессеж бичихгүй бол яасан бэ гэж сануулдаггүй байсан. Бид хоёрт нэг нэгэндээ гэм буруутай мэт мэдрэмж төрүүлэлгүй, энэ үүрэг даалгаврыг хийх боломж гарч байлаа.


Одоо бид даалгавраа хийж эхлээд 6 сар болж байгаа бөгөөд судраа

уншихаа мартсан нэг ч өдрийг би санахгүй байна. Энэ ах хоёр сарын өмнө мацаг ба гэрчлэлийн цуглаанаар индэр дээр гарч, өдөр бүр судар уншсанаар өөрт нь болон гэр бүлд нь ямар эерэг нөлөө үзүүлсэн тухай гэрчлэлээ хуваалцсан.

Би энэ ахад төдийгүй түүнтэй нөхөрлөсөндөө мөн өдөр тутам бичдэг мессежид нь талархдаг. Би техник технологийг зөв зүйтэй ашиглавал бидний амьдралыг сайжруулдаг болохыг харсан. Би судруудаа болон тэдгээр нь хэрхэн Христийн тухай гэрчиж байдаг талархаж байна. Аврагчийн цагаатгагч золиослол бидний хүн нэг бүрд хэзээ нэгэн өдөр Өөртэй нь хамт амьдрахаар эргэж очих боломжийг олгодог гэдгийг би мэднэ. ■ Алэкс Уиблий, Канадын Бритиш Колумбия



Бид судрыг илүү тууштай судлах хүсэлтэй “хариуцлагатай хамтрагчид” болсон юм.



ТАНЫ ХУВИЙН ЛУУЖИН

“Таны адислалыг цэвэрхэн нугалж, цааш хийж хадгалахад, мөн жаазанд хийж эсвэл нийтэд зарлахад зориулаагүй. Харин үүнийг унших, хайрлан нандигнах, мөн дагахад зориулсан юм. Патриархын адислал хамгийн хүнд хэцүү цаг мөчид танд тусална. Энэ нь таныг амьдралын аюул дундуур хөтлөх болно. . . . Таны патриархын адислал бол аяллыг тань чиглүүлж, замыг тань хөтлөх хувийн луужин юм.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Your Patriarchal Blessing: A Liahona of Light,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 66.

Патриархын адислалаа ОЙЛГОХ НЬ



Аллий Арнэлл, Маргарэт Виллден

Амьдрал *Би ямар сургуульд сурах хэрэгтэй вэ?, Би ямар мэргэжлээр сурах вэ?, Би номлолд үйлчлэх үү?, Би хэнтэй гэрлэх вэ? гэх мэт үл мэдэх зүйлээр дүүрэн.* Хэрэв танд амьдралынхаа шийдвэрийг гаргахад чиглүүддэг хувийн газрын зураг өгсөн бол та түүн дээр заасан замыг дагах байсан уу?

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бидэнд ийм газрын зураг буюу амьдралыг маань удирдан залах патриархын адислалыг өгсөн. Хэдийгээр бидэнд өөрсдийн хүслийн дагуу шийдвэр гаргах сонгох эрх өгсөн ч гэлээ, патриархын адислал нь аль арга зам бидэнд илүү их аз жаргал авчрахыг тодруулж өгдөг.

Гэхдээ зөвхөн газрын зурагтай байх нь хангалттай бус. Бид газрын зурган доторх утга агуулгыг судалж, ойлгож, хэрэгжүүлэх ёстой. Үүний адилаар, та амьдралынхаа хувийн хөтөч болох патриархын адислалд тань хэрэглэсэн хэлийг ойлгох юм бол Бурханы мэлмийд өөрийгөө хэн болохыг мөн ямар хүн болох боломжтой гэдгээ харж чадна.

Язгуур угсаагаа олж мэд.

Хамгийн чухал зүйл бол таны патриархын адислал язгуур угсааг тань эсвэл таны харьяалагдах Иаковын (хожим Израиль хэмээн нэрлэсэн) арван хоёр овгийг тодорхойлдог. Хэдийгээр бид Иаковын шууд угсааных биш ч Сүмийн гишүүдийг Израилийн угсаанд үрчлэн авдаг болохыг судрууд “Учир нь энэ Сайн мэдээг хүлээн авах болгон нь чиний нэрээр дуудагддаг байх болно, мөн чиний үр удам хэмээн тооцогддог байх болно, мөн тэдний эцгийн хувьд, чамайг магтан дуулах болно” (Абрахам 2:10) хэмээн заадаг.

АНУ-ын Ютагийн Шэлиса Шроупэл: “Иаковын угсааных гэдгээ олж мэдсэн маань энэ амьдралынхаа зорилгыг болон яагаад Сүмийн тодорхой дуудлагад дуудагдсан гэдгээ ойлгоход надад тусалдаг” гэж хэлжээ.

Түүнчлэн патриархын адислал тань таны патриархын овогтой холбогдсон адислалуудыг тайлбарласан байж болно. Жишээлбэл: Сүмийн олон гишүүн Ефраимын овогт харьяалдаг. Энэ овог нь сэргээсэн сайн мэдээний захиасыг дэлхийд

Адислалынхаа зарим хэсгийг тодорхойлох нь танд амьдралын зүг чигээ олоход тусална.

түгээх онцгой үүрэг хариуцлага үүрдэг юм (Дэд хууль 33:13–17; С ба Г 133:26–34-ийг үзнэ үү).

Өөртөө чиглэсэн зөвлөгөөг олж ав

Газрын зургийг зөв хэрэглэх юм бол энэ нь аялагчийг төөрөлдөхөөс урьдчилан сэргийлдэг. Үүнтэй адил, патриархын адислал нь энэ дэлхий дээрх аялалд тань мөн амьдралд тань тус болох зөвлөгөө, удирдамжийг өгч болно. Патриархын адислал танд



ХЭРХЭН СУДЛАХ ЗӨВЛӨМЖ

- Патриархын адислалд өгсөн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, авьяас, амлалтуудыг олж тодорхойл. Та эдгээрийг амьдралынхаа энэ үе шатанд хэрхэн хэрэгжүүлж болох талаар залбир.
- Амьдралынхаа туршид адислалаа маш нарийн, байнга судалж бай. Нэг өгүүлбэр амьдралын тань өөр өөр үе шатанд өөр утга агуулгатай ойлгогдож болно.
- Патриархын адислал амьдралын тань бүх талыг дурддаггүй гэдгийг сана. Чухал гэж бодож байгаа зорилго тань адислалд ороогүй ч гэсэн хичээл зүтгэл гаргах чухал зүйл хэвээр байж болно.
- Сайн мэдээнд дуулгавартай бай. Патриархын адислал дээрх адислалууд таны зөв шударга байдлаас шалтгаална.
- Бэлэгнүүдээ эрэлхийлж, авьяасаа хөгжүүлэх зорилго тавь.
- Та амьдралд хаашаа явж байгаагаа, яваандаа хаана хүрэхийг хүсэж байгаагаа тунгаан бод. Таны зорилго патриархын адислалтай хэр нийцэж байна вэ?
- Судлахад хэрэглэхийн тулд патриархын адислалаа хуулж авах тухай бодож үзнэ үү. Та өөрт төрсөн бодол санааг бичиж, онцгой үгсийг тодруулан, адислалтайгаа холбоотой судруудыг тэмдэглэж болно.

юу хийхийг зүгээр л хэлээд өгдөггүй, харин Тэнгэрлэг Эцэгийн хүсэлтэй амьдралаа нийцүүлэх юм бол аль зам нь мөн итгэлтэй дагаж чадвал танд хэрхэн тустай болох талаар зөвхөн танд зориулсан ойлголтыг өгнө. Та патриархын адислалаа судалж, Их Эзэний Сүнснийг урих байдлаар амьдрахыг эрэлхийлбэл аюулгүй байдал, баяр баясгалан, удирдамж зааврыг олох боломжтой.

Перугийн Лимагийн Габриэл Парэдэс: “Адислалаар дамжуулан надад өгсөн зарим зөвлөгөөг би зөвхөн эхнэртэйгээ лацдан холбуулсны дараа гэр бүлдээ хэрэгжүүлэх боломжтой байсан.

Саяхнаас бид шинэ гэр бүлээ хүчирхэгжүүлж, хөгжүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ гэж бодох боллоо. Бидний асуултын хариу патриархын адислалаар минь дамжин ирсэн. Адислал дээр Есүс Христийн сайн мэдээний чухал үндэс суурь бол гэр бүл учраас надад гэр бүлийн доторх хүндэтгэл, тэвчээр, хайрыг нэгд тавихыг зөвлөсөн байв.

Эхнэр бид хоёр үүн дээр анхаарлаа хандуулах болсноор асуудлыг даван туулах боломжтой болсон юм. Гэр бүлийн хувьд бидэнд асуудал тулгарсан хэвээр байгаа ч бид аз жаргалтай байдаг. Их Эзэний надад өгнө гэж амласан тэр гэр бүлийг би хэрхэн бий болгох боломжтой гэдгийг Тэр сануулж байгаа юм шиг санагдсан. Их Эзэн патриархын адислалаар дамжуулан ярьдаг бөгөөд түүнд орсон зөвлөгөөг бид амьдралдаа ашиглах ёстой гэдгийг би мэднэ” гэв.

Сануулгыг чих тавин сонс

Газрын зураг дээр замын туршид учрах аюул бүрийг заавал тэмдэглэдэггүй ч аз болоход патриархын

адислал дээр замын туршид биднийг хамгаалах сэрэмжлүүлэг орсон байдаг. Зарим сануулга нь биднийг Сатаны нөлөөнөөс хамгаалж тусалдаг байхад зарим нь өөрийн доторх эгэл хүнийг хэрхэн ялан дийлэх тухай сэнхрүүлдэг.

Ютагийн Кэйтлин Каррын хувьд түүний патриархын адислалд дээрх зарим сануулгыг тэр даруй ойлгоогүй ч адислалаа судалсны дараа түүнд шинэ ойлголт төрсөн байна.

“Намайг адислалаа авч байхад сэтгэл татам үг яриагаар үнэнээс холдуулах гэж оролдох хүмүүсийн талаар анхааруулсан. Би энэ тухай нэг их бодоогүй бөгөөд заалгасан сургаалдаа итгэл төгс байв.

Гэтэл дараа жил нь өнгөн дээрээ шударга ёс, хайранд үндэслэсэн мэт санаа, гүн ухааны үзэлтэй тулгарсан юм. Эдгээр захиас нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сургууль, тэр бүү хэл дотно найз нөхөд гээд тал талаас ирж байгаа мэт санагдсан. Хэдийгээр эдгээр гүн ухааны үзэл нь Бурханы төлөвлөгөөний эсрэг гэдгийг би мэдэж байсан ч дэлхийнхний энэхүү шинэ үзэл бодол болон Сүмийн сургаалын аль алиныг дэмжих хүсэлтэй байгаагаа олж мэдсэн юм. Тун удалгүй би ‘хэн ч хоёр эзэнд үйлчилж чадахгүй’ (Матай 6:24) мөн хүмүүний мэргэн ухаанд найдах хэрэггүй гэдгийг ухаарсан. Тэнгэрлэг Эцэг судраар дамжуулан миний эргэлзээг тайлсан бөгөөд оюун ухаан, зүрх сэтгэлд минь амар амгаланг өгсөн билээ. Үүний үр дүнд миний гэрчлэл хүчирхэгжин, үнэн болохыг мэддэг зүйлээ илүү шийдэмгий хамгаалдаг болсон.”

Бэлэг болон авьяасаа хөгжүүл

Таны патриархын адислал дээр Их Эзэний хаант улсыг байгуулахын

тулд танд өгсөн сүнслэг бэлэг болон авьяасыг мөн дурдаж болно. Хэрэв адислал дээр мэдэхгүй авьяас дурдсан байвал энэ нь танд авьяасаа нээж илрүүлэх эсвэл хөгжүүлэх боломж хараахан гараагүй байгаа учраас байж болох юм. Та шаргуу эрэлхийлснээр мөн Их Эзэний тусламж дэмжлэгээр энэ болон өөр олон авьяасаа таньж нээхийн тулд өсөж хөгжих боломжтой.

Авьяасаа хөгжүүлэх нь Их Эзэний ажилд хувь нэмэр оруулж болох онцгой зүйлсээ танин мэдэхэд танд тусалдаг. АНУ-ын Калифорнийн Жоанна Блэквэлл өөрийгөө бусадтай харьцуулах уруу таталттай тулгарах үедээ адислал дээрх авьяас, бэлгийнхээ тухай тунгаан боддог байна. Тэр: “Патриархын адислал дээрх үгс сорилт бэрхшээлийг даван туулах, Их Эзэний ажлыг яаравчлуулахад оролцоход хувь хүнийхээ хувьд хэрэгтэй бэлгээр адислагдсан гэдгийг надад сануулдаг.

Адислал маань миний хайрлах, уучлах чадвартайг мөн эргэн тойронд байгаа хүмүүстэйгээ харилцах

зүрх зоригтой гэдгийг хэлсэн. Эдгээр бэлгээ ашиглахын хэрээр Их Эзэн намайг шинэ хүмүүс, шинэ соёлтой танилцах, холбоо тогтоох илүү их хүслээр адисалсан. Ингэснээр, бидний Тэнгэрлэг Эцэгийн хайртай хүүхдүүд хэмээх гэрчлэл өссөн бөгөөд бидний хүн нэг бүр Христтэй илүү адил болохыг эрэлхийлдэг учраас би бусдад үйлчлэх боломжтой болсон” гэв.

Амлагдсан адислалуудыг эрэлхийлэх нь

Эцэст нь хэлэхэд, хэрэв бид итгэлтэй хэвээр үйлдвэл бидний патриархын адислал Тэнгэрлэг Эцэгийн амлагдсан адислалуудыг илчилдэг. Эдгээр амлалт хэзээ биелэхийг хэлж мэдэхгүй ч сайн мэдээний дагуу дуулгавартай амьдарч чадах юм бол энэ амьдралд эсвэл дараачийн амьдралд биелэх болно гэдгийг би мэднэ.

АНУ-ын Невадагийн Сэржио Гуттиеррээ ирээдүйн ажил мэргэжлийнхээ талаар санаа зовох болгондоо патриархын адислал дээрх

амлалтад найддаг. Тэр: “Ирээдүйн амьдралаа тодорхой бус байгаад санаа зовох үед сэтгэл санааг маань тайвшруулдаг нэгэн амлалт патриархын адислал дээр минь байдаг. Энэ амлалт нь шаргуу хөдөлмөрлөж, итгэлтэй хэвээр байвал гэр бүлээ авч явах мөн Сүмийг хүчирхэгжүүлэхэд шаардлагатай эх сурвалж надад байна гэдгийг олж мэдэхэд надад тусалдаг. Яг одоо ямар ажил мэргэжлийн замаар явахыг хүсэж байгаагаа мэдэхгүй байгаа ч ийм амлалт байгаа нь надад итгэл, найдвар төрүүлдэг.

Хэрэв та өмнө нь Тэнгэрлэг Эцэгийн өөрөөс тань хүсэж байгаа зүйл юу болох талаар бодолхийлж байсан бол ганцаараа биш гэдгийг чинь хэлэх гэсэн юм. Та амьдралдаа замнаж болох олон замтай учирна гэдгийг Их Эзэн ойлгодог учраас амьдралыг тань сайн мэдээтэй нийцүүлэхийн тулд танд зориулсан газрын зураг өгсөн. Патриархын адислал бидний өмнөөс шийдвэр гаргахгүй ч хувийн илчлэлт биднийг хөтлөх боломжтой. Бид патриархын адислалаар дамжуулан ямар овгийнх болохоо мэдсэнээр Израилийг цуглуулах Их Эзэний төлөвлөгөөнд хэр тохирч байгаагаа харж, хувь хүн рүү чиглэсэн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, амлалтыг хүлээн авдаг төдийгүй Тэнгэрлэг Эцэгээс бидэнд өөрсдөдөө үйлчлэхэд зориулан өгсөн онцгой бэлэг, авьяасын талаар заадаг. Та патриархын адислал дээрх энэ бүх зүйлийнхээ дагуу амьдрахаар хичээх л юм бол гаргаж буй шийдвэр тань Их Эзэний хүссэн тэр амьдралд нийцсэн гэдгийг мэдэх болно” гэжээ. ■

Зохиогчид нь АНУ-ын Иллинойс, Нью-Йорк мужид тус тус амьдардаг.



Их Эзэн таныг амьдралаа Түүний сайн мэдээтэй нийцүүлж байхад туслах газрын зургаар хангажээ.

Шинэ аялалд бэлдэх нь

**Карина Мартинс Пэрэйра
Коррэйа дэ Лима**

Би гэрлэж, ариун сүмд лацдан холбуулахын өмнөх долоо хоногуудад шинэ гэр бүлтэй болохоосоо өмнө хийх хэрэгтэй олон зүйлийн талаар бага зэрэг тэвдэн сандарч эхлэв. Тухайн үед баяр баясгалантай байсан ч шинэ дэг жаяг тогтоох, санхүүгээ зохицуулах, эд зүйлсээ хадгалах агуулах олох гээд эхнэр хүний бүхий л үүрэг хариуцлагын талаар санаа зовниж байлаа. Хэдийгээр бид завгүй байсан ч зарлигуудыг сахих, эхнэр нөхрийн хувьд хамтдаа цагийг өнгөрүүлэх гэх мэтээр чухал үйл ажиллагаанд цаг зав гарган, гэрлэлтээ зөв замаар эхлүүлэхийг хүссэн юм.

Хуримын өдөр ойртох тусам гэр бүлд нөлөөлж болох янз бүрийн бэрхшээлийн талаар хар даран зүүдлэх болсондоо би гайхаж билээ. Би бие биенээ хайрладаг ч байнгын, хурц хэрүүл маргаантай, шархалсан зүрх сэтгэлээс болж цөхөрч ядарсан гэр бүлээс гаралтай болохоор

хар дарсан зүүд маань бусад хүнтэй харьцуулахад надад илүү их нөлөөлж байв. Нэгэн шөнө би ийм зүүдийг хэд хэдэн удаа зүүдэлсний дараа хамаг бие маань хөлөрчихсөн сэрээд, Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Нийл Ф.Марриот эгчийн “Зүрх сэтгэлээ Бурханд зориулах нь” (2015 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 14–16) үгэндээ өгсөн зөвлөгөөг дагахаар шийдсэн юм. Би нүдээ аниад, “Тэнгэрлэг Эцэг минь, би энэ бүх муу зүйлээс гэр бүлээ хамгаалахын тулд юу хийж болох вэ?” гэж залбирав.

Хариулт нь хэн нэгэн хүн толгойд маань нэгэн бодол хийчихэж байгаа мэт маш хурдан, маш хүчтэй ирсэн юм. Намуухан, зөөлөн дуу хоолой “Хийх ёстой зүйлээ л хий. Алхам бүрдээ итгэлтэй бай” гэсэн сүнсэлэг өдөөлтийг надад өгсөн билээ. Сүнс надад тодорхой зөвлөгөө өгсөн бөгөөд тэрхүү зүйлийг хийх л юм бол бүх зүйл сайхан болно гэсэн мэдрэмж надад төрсөн юм.”

Нифай үл таних газар руу завиар аялж байсантай адил би ч бас гэр бүлтэй болох талаар Их Эзэнд итгэх итгэлээ хөгжүүлэх хэрэгтэй байлаа.

Би инээмсэглэсэн ба чээж маань халуу оргих мэт болов. Би энэ бүхэн үнэн гэдгийг мэдэж байсан учраас санааг маань зовоож байсан бүх зүйл гэв гэнэт замхран алга болсон юм. Би урьд нь Ариун Сүнсийг мэдэрч байсан ч гэлээ, хэзээ ч тэр шөнийнх шиг хүчтэй мэдэрч байгаагүй. Би Тэнгэрлэг Эцэгийн болоод Аврагчийн хайрыг эргэн



тойрноосоо мэдэрч, гэр бүлийн маань амар тайван байдал, аврал миний хувьд ямар чухал байдгийн адил Тэнгэрлэг Эцэгт ч чухал гэдгийг мэдсэн.

Үүний зэрэгцээ Их Эзэний Нифайд усан онгоц барихыг зааварласан судрын түүх санаанд минь орж ирснээр илүү их итгэл өгсөн юм. “Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад ярьж, өгүүлсэн нь: Би чиний хүмүүсийг энэ усыг гаталгахын тулд, *чамд миний үзүүлэх тэр жаягаар*, чи усан онгоц барих болно хэмээв” (1 Нифай 17:8; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Нифай гэр бүлийн хамт аглаг буйдаа олон жил амьдарч, бүхий л зовлон зүдгүүрийг амссан. Тэр далайг гатлах аяллыг эхлүүлэхээс айж, айдас нь итгэлийг нь дарж болох байсан. Гэвч тэр айгаагүй бөгөөд Бурханы зааврыг хүлээн авч, дагасан билээ. Тэр Бурханы өгсөн амлалтууд биелнэ гэдэгт итгэж байсан. Их Эзэн Нифайд шуурга болохгүй, давалгаа завийг нь нүдэхгүй гэж хэлээгүй. Харин Өөрийнх нь удирдамжийг дагавал далай дундуур гэр бүлийг нь эсэн мэнд гатлуулан, амлагдсан нутаг руу хүргэнэ хэмээн Нифайд хэлсэн юм.

Би ч гэсэн олон жил аглаг буйдаар аялсан ч яг одоо далайн өмнө зогсоод, гэрлэлт гэх шинэ аялалд бэлтгэж байгаагаа ухааран ойлгосон. Би өөрийгөө бүх хожмын үеийн гэгээнтэн гэр бүлийн адил Бурханы зааврын дагуу усан онгоц барихаар дуудагдсан гэж боддог.

Нөхөртэйгөө гэрлэсний дараа асуудлууд гарч билээ. Би өвдөж мөн санхүүгийн хувьд зохицуулж, дагахаар шийдсэн бүх сайн дадал хэвшлээ амьдралдаа суулгах гэж хичээв.

Гэхдээ тэр оройн хүлээж авсан зөвлөгөө зүрх сэтгэлд маань хоногшин үлдсэн юм. Бид өдөр бүр Бурханы үгнээс судалж, зүрх сэтгэлдээ нандигнаж, хайрт удирдагчдынхаа болон Христийн сайн үлгэр жишээг дагаж, зан чанараа сайжруулахыг хичээж байлаа. Би залбирлын талаар илүү хүчтэй гэрчлэлтэй болсон бөгөөд биднийг хайрлах Эцэгийн хайраас амссан. Мөн итгэл маань өсөж, айдас маань багассан. Бидний амссан зовлон бэрхшээл өсөлт хөгжил рүү хөтөлсөн шатууд байсан гэдгийг бид ухаарсан юм. Өнөөдөр манай гэр орон яг л бяцхан диваажинтай адил санагддаг.

Бид аяллынхаа эхэнд явж байгаа ч гэрлэж, гэр бүлтэй

болох нь миний хийж байсан хамгийн зөв сонголт байв. Хүлээн авсан ариун сүмийн ёслолынхоо талаар бодоход мөн уг холболтыг Бурханы эрх мэдлээр хийлгэсэн гэж бодоход зүрх сэтгэл маань баяр баяслаар дүүрдэг. Би Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх гэр бүлийн ач холбогдол болон хийсэн гэрээнийхээ ариун нандин байдлын тухай илүү ихийг мэдэх тусам бусад гэр бүлд уг ёслолыг хүлээн авахад нь туслахыг төдий чинээ хүсдэг.

“Бурхан бидэнд айдсын сүнснийг бус, харин хүч, хайр ба биеэ захирахын сүнсийг өгсөн” (2 Тимот 1:7) учраас бид ирээдүйд юу болох талаар санаа зовох хэрэггүй гэдгийг би олж мэдсэн. Бид зүгээр л дуулгавартай байж, судруудаар болон орчин үеийн бошиглогчдын үгсээр дамжуулан өгсөн заавруудыг даган, илүү олон хувийн зааварчилгаа авахын тулд залбирах хэрэгтэй. Хэрэв бид эдгээр зүйлийг хийвэл, ямар ч саад бэрхшээл тулгарсан байлаа ч хайртай хүмүүс маань хожмын өдрүүд гэх далайгаар эсэн мэнд гаталж чадна. ■

Зохиогч нь Бразилийн Паранад амьдардаг.



Би хэрхэн ОЮУН САНАА, ЗҮРХ СЭТГЭЛДЭЭ *судлах* вэ?

Сургаалын болоод түүхэн эсвэл хувийн асуулт гарч ирвэл та юу хийх ёстой вэ? Та хэрхэн хариултаа олж болох вэ? Их Эзэн “Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно” (С ба Г 8:2) хэмээн амласан билээ. Та сүнслэг өдөөлтийг танин мэдэхийн тулд оюун санаа *мөн* зүрх сэтгэлээ хэрхэн ашигладаг вэ? Энд хэдэн жишээ авч үзье.

ОЮУН САНАА

Судал, залбир, сонс

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс: “амьдралын гол чухал шийдвэрийг гаргах үед . . . Тэнгэрлэг Эцэг биднээс иймэрхүү асуудлаа сонгох эрхээ ашиглан, сайн мэдээний зарчмуудын дагуу нөхцөл байдлыг оюундаа тунгаан бодож, залбирлаар дамжуулан өөрийн шийдвэрийг Түүнд хэлж танилцуулахыг хүсдэг” хэмээн хэлсэн (“Ариун Сүнс,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 92).

Энэ нь бүх асуултын хувьд адилхан юм. Та судалж байхдаа хариултаа олж авах талаар чин сэтгэлээсээ залбираарай. Ариун Сүнс сүнслэг өдөөлтийг оюун ухаанд тань санаа өгөх, үгс хэлэх эсвэл бусад хувийн чанартай сануулга өгөх зэргээр дамжуулан хэрэгтэй бусад хариулт руу тань хөтөлнө.

Эх сурвалжуудыг ашигла

Судрууд болон судруудын удирдамжаас судалж, өөр бусад зүйлээс суралцах нь танд тустай. Та бас LDS.org дээрх Ерөнхий чуулганы үгс, Gospel Topics, Сүмийн сэтгүүл, Joseph Smith Papers Project болон өөр бусад ХҮГ эх сурвалжуудыг эрж хай. (Сүмийн тус нэмэр болох эх сурвалжуудыг 54-р хуудаснаас үзнэ үү.)

Үүний талаар ярилц

Тусламж хүсэхээс бүү эмээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роналд А.Расбанд: “Би та нарт нэг даалгавар өгье. . . . Та [хариултуудаа олоход туслах] хэн нэгний талаар бодох хэрэгтэй. Итгэл даасан найз, эцэг эхийн аль нэг нь эсвэл хоёулаа, өвөө эмээ, багш, бишопын зөвлөлийн гишүүн эсвэл зөвлөгч гээд аль нь ч байж болно. . . . Та нар эдгээр асуултын хариултыг олох хэрэгтэй” хэмээн биднийг урамшуулсан юм (Face to Face broadcast, 2016 оны 1-р сарын 20). Оролдоод үзээрэй! Асуултынхаа талаар итгэл даах хэн нэгэнтэй ярилцаад, хамтдаа хариултыг ол.

Залбир

Сонс

Ярь

гэрэл зургийг жош талбот

Асуулт гарч ирвэл юу хийж болох талаар олж мэд.

Судал

Судал

Залбир

Сонс

Тэвч



БУРХАНААС ИРЭХ ХАРИУЛТ

“Үнэн шударга асуултууд тавих нь итгэлээ өсгөх үйл явцын чухал хэсэг бөгөөд ингэхийн тулд бид оюун ухаан, мэдрэмжүүдээ ашигладаг Их Эзэн ‘оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно’ [С ба Г 8:2] хэмээн хэлсэн. Хариулт бүр агшин зуур ирэхгүй ч, чин сэтгэлээсээ судалж, Бурханаас хариулт авахаар эрэлхийлснээр ихэнх асуултыг шийдвэрлэж чаддаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн, “Итгэлийг тохиолдлоор бус, сонголтоор олж авдаг,” 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 55.

ЗҮРХ СЭТГЭЛ

Судал, залбир, сонс

Дараах үгс нь оюун санаа болон зүрх сэтгэлийн аль алианаар тунгаан бодоход танд туслах нэн чухал алхмууд юм. Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф: “Хэрвээ та сүнслэг үнэнийг олж танихыг хүсвэл зөв хэрэгсэл ашиглах ёстой. Та сүнслэг үнэнийг олж мэдрэх боломжгүй хэрэгслээр түүнийг олж мэднэ гэж үгүй” хэмээн хэлсэн (“Гэрэл ба үнэний талаарх гэрчлэлийг хүлээн авах нь,” 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 23). Ариун Сүнс бол сүнслэг зүйлсэд суралцдаг зэмсэг юм. Иймээс та залбирч, Сүнсийг сонсох юм бол эцэст нь хариултаа олох боломжтой.

Тэвчээртэй бай

Ерөнхийлөгч Угдорф: “Бид зүрх сэтгэл, оюун ухаанаа Бурхан руу хэдий их хандуулна, тэнгэрлэг гэрэл бидэн дээр төдийн чинээ их хуралдах болно. . . . Урьд нь бүдэг, тас харанхуй, асар хол мэт байсан зүйлс танил бөгөөд тод томруун болж ирдэг” гэж тайлбарласан (Гэрэл ба үнэний талаарх гэрчлэлийг хүлээн авах нь,” 23). Хариултыг эрж хайх нь урт үйл явц юм. Гэхдээ та удаан хүлээх хэрэгтэй байсан ч хариултыг сонсоход бэлэн байвал тэдгээрийг олох болно.

Сүнслэг өдөөлтийг таньж мэдэх дадлага хий

Та сүнслэг өдөөлтийг таньж, Сүнсийг зүрх сэтгэлд тань шивнэх үед хэдий чинээ үйлдэхэд бэлэн байна, ирээдүйд ирэх бусад өдөөлтийг танихад төдий чинээ амархан байна. Та “зөв юм байна гэдгийг мэдрэх болно” эсвэл буруу байвал “дүйнгэ бодол санааг” ч мэдрэх болно (С ба Г 9:8-9-ийг үзнэ үү). Та мөн аядуу зөөлөн сануулга, амар тайван мэдрэмжийг эсвэл өөрт тань онцлог өөр мэдрэмжийг ч хүлээн авч болно. Их Эзэн таныг мэддэг бөгөөд Сүнсийг хэрхэн ойлгодгийг тань бас мэддэг. Тэрээр хайраар дүүрэн, зөвхөн танд зориулсан онцгой удирдамжийг өгөх болно. Тиймээс үргэлжлүүлэн сонсож, дадлага хийсээр бай. ■


САЙН МЭДЭЭГ СУДЛАХ ӨӨРИЙН ГЭСЭН АРГА БАРИЛТАЙ БОЛ

Сайн мэдээг судалж, сүнслэг асуултандаа хариулт авах дараах зөвлөгөөг туршиж үзээрэй.

Бэтани Бартоломэй

Сүмийн сэтгүүлүүд

Та сүнслэг асуултанд хариулт эрж эсвэл судрыг илүү сайн ойлгох гэж хичээхдээ ямар арга барилаар суралцдаг вэ? Би үүнийг хувь хүний тань хувьд асууж байгаа болно. Хүн бүр сургуульдаа өөр өөр суралцах дадал хэвшилтэй байдаг бөгөөд сайн мэдээнээс суралцахдаа ч гэсэн өөрийн гэсэн арга барилтай байж болно гэдгийг бид мартдаг. Дараагийн удаа сүнслэг асуулт эсвэл сургаалын талаар асуулт гарч ирвэл дараах арга барилын аль нь танд хамгийн тохиромжтой болохыг олж мэдэхийн тулд туршиж үзээрэй.



1. БИЙ БОЛГОХ

Жагсаалт гаргаж, хүснэгт эсвэл газрын зураг зур. (Жишээг доороос харна уу.)

Судлах холбоосыг бий болго. Үг, санаа бодлоо бичиж тэмдэглэн, дараа нь тэдгээрийг хооронд нь зураас, бөмбөлгөөр холбон хэрхэн холбогдож байгааг харуул.



ЖАГСААЛТ ГАРГАЖ, ХҮСНЭГТ ЭСВЭЛ ГАЗРЫН ЗУРАГ ЗУР.

Зарим үед сайн мэдээг судалж байхдаа өөрийн бодол санааг жагсаалт, хүснэгт, газрын зураг зэрэгт оруулах зэргээр харж болох хэлбэрт оруулан цэгцлэх нь тустай байдаг. Шинэ Гэрээн дэх Паулын захидлуудыг судлахдаа гаргаж болох хүснэгтийн жишээг доор өгөв. Та аль ч форматыг ашиглан хамгийн сайн тус болох өөрийн гэсэн жагсаалт гаргаж, хүснэгт, газрын зураг зурж болно. Бүтээлч бай! Хөгжилтэй арга замаар сайн мэдээнээс суралцах үйл явцаа зохион байгуул.

ПАУЛЫН ЗАХИДЛУУД

ЗАХИДАЛ	ХАМТРАГЧТАЙ БАЙСАН УУ?	ХААНААС БИЧСЭН БЭ?	ЗАХИДЛЫН ГОЛ СЭДЭВ
Жишээлбэл: 1 Тимот	Дурдаагүй	Лаодик (1 Тимот 6-гийн төгсгөлд байгаа тэмдэглэлийг үзнэ үү)	Үнэн сургаал, Аврагч, залбирал, итгэл ба энэрэл, удирдлагын зан чанар, урвалт, ядуусыг халамжлах, итгэлтэй байх, дэлхийн баялгаас зайлсхийх

2. БИЧИХ

Судар судлах явцад орж ирсэн бодол санаа, төрсөн сэтгэгдлээ судлах тэмдэглэлдээ бичин, ойр ойрхон харж бай.

Залбирлын дараа орж ирсэн бодол санаа, төрсөн сэтгэгдлээ таны судалж байгаа сэдэвтэй шууд холбоогүй байсан ч бичиж тэмдэглэ. Сүнсний зааж байгаа зүйлийг хэсэг хугацааны дараа харж бай.

Өдөр бүр юу сурч байгааг сануулж, тунгаан бодоход тань тус болох үүднээс асуултуудаа тэмдэглэлийн дэвтэр, гар утас, эсвэл цаасан дээр бичээд орныхоо дэргэд тавь.



4. СУДАЛГАА ХИЙХ

Судалгаа хийж суралцах нь судраас болон онлайнгаар суралцахад тусалдаг (тустай ХҮГ эх сурвалжуудын жагсаалтыг доороос үзнэ үү.)

Сурч байгаа сэдэвтэй тань холбоотой видео бичлэг, дуунуудыг LDS.org-оос хай.

Хам сэдвийг судал. Судалж байгаа сэдэв, сударт тань хамаатай түүхийг эсвэл тойрсон бүлгүүдийг судал.



LDS.ORG ДЭЭР

- Судрууд (scriptures.lds.org)
- Ерөнхий чуулган (conference.lds.org)
- Gospel Topics (topics.lds.org)
- Сэтгүүлүүд (iahona.lds.org)
- Сүмийн түүх (history.lds.org)
- Судлах тусламж (scriptures.lds.org)
- Хичээлүүд ба заах эх сурвалжууд (lds.org/go/41754a)
- LDS Media Library (lds.org/media-library)
- Бэрхшээлүүдэд туслах нь (lds.org/go/41754b)

СУДЛАХ ТУСЛАМЖУУДААС ТУСЛАМЖ АВ

Чухал сэдвүүдийг судлах үед танд туслах болон онлайнд байдаг. Ашиглах боломжтой зарим эх сурвалжийн жагсаалтыг мөн үүнийг хаанаас олж болохыг доор оруулав.



СУДРУУД ДЭЭРХ

- Судрын удирдамж
- Библийн он дараалал (Хуучин ба Шинэ Гэрээний үйл явдлуудыг ойролцоо огноотой нь, цаг хугацааны дарааллаар тавьсан)
- Сайн мэдээнүүдийн уялдаа холбоо (Матай, Марк, Лук, Иоханы сайн мэдээн дээрх Аврагчийн тухай түүхийг үйл явдал, газар, ойролцоо огноогоор нь байрлуулсан)
- Библийн Иосеф Смитийн орчуулга
- Газрын зураг болон гэрэл зургууд
- Товчилсон үгийн удирдамж



БУСАД ОНЛАЙН ЭХ СУРВАЛЖ

- Гэр бүлийн түүх (familysearch.org)
- Мормон суваг (mormonchannel.org)
- Ерөнхий чуулган дээр эш татсан судрууд (scriptures.byu.edu)
- Мормон мэдээний булан (mormonnewsroom.org)
- Номлолын ажил ба сайн мэдээг хуваалцах нь (mormon.org)
- Joseph Smith Papers Project (josephsmithpapers.org)

3. СОНСОХ МӨН ЯРИЛЦАХ

Эцэг эх эсвэл итгэл даах удирдагчтайгаа ярилц. Хамтдаа хариултыг ол. Үүнд цаг их шаардаж болох ч та хоёр хоёулаа өсөж хөгжинө.

Өөр хүнд заа. Мэдэж *байгаа* зүйлээ ээлж дараалан хуваалц. Бие биенээсээ сурсан зүйлээ ярилц.

Судар болон ХҮГ түүх, эх сурвалжуудыг чангаар сонс.

5. ҮЙЛДЭХ

Судрууд эсвэл бусад эх сурвалж дээрх түүхүүдийг амьдралдаа хэрэгжүүл. Өөрийгөө тухайн хүний оронд тавьж үзэх нь судалж байгаа зүйлээ илүү сайн ойлгоход тань хэрхэн туслах вэ? Амьдралдаа үүнтэй адилхан нөхцөл байдалд орвол яах вэ?

Судруудаас олсон хариулыг хооронд нь холбох судрын холбоос хий. (Жишээг доороос харна уу.)

СУДАР СУДЛАХ ХОЛБООСЫГ БИЙ БОЛГО

Заримдаа нэг сэдвийг хамарсан хэд хэдэн судрыг тэмдэглэж авах нь тустай. Судалж байгаа сэдэвтэй тань холбоотой судруудыг Судрын удирдамжаас хар. Дараа нь зүүлт тайлбар, хам сэдвийг ашиглан судруудыг адилхан сэдвийн илүү их мэдээлэлтэй холбо. Өмнөх судрынхаа захад холбоост орсон дараагийн судрыг бичих гэх мэтчилэн үргэлжлүүл. Та мөн судалгаанд тань туслах тодорхой сэдвээр Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг хайж болно (conference.lds.org оос сэдвийн жагсаалтыг хар). Тухайлбал: Найдвар гэх сэдвийн судар судлах холбоосыг үзүүлье.

СУДАР СУДЛАХ ХОЛБООС

Найдварын талаарх судрууд:



Найдварын талаарх үгс:

- Бишоп Дийн М.Дэйвийс, “Шүтлэг бишрэлийн адислал,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган.
- Ахлагч Пол В.Жонсон, “Тэнд цаашид үхэл үгүй болно,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган.
- Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, “Тэр таныг мөрөн дээрээ тавиад, гэртээ авчрах болно,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган.
- Ахлагч Л. Витни Клэйтон, “Итгэхийг сонго,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган.
- Ерөнхийлөгч Боид К.Пакэр, “Бидний найдварын учир шалтгаан,” 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган.
- Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, “Үнэлж баршгүй найдварын өв,” 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган. ■





Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
Ахлагч
Квинтин Л.Күк

ЖИНХЭНЭ АМАР АМГАЛАНГ ХЭРХЭН ОЛЖ АВАХ ВЭ?

Хаа газрын сайн хүмүүсийн тэнгэрлэг хүсэл тэмүүлэл үргэлж энэ дэлхийн амар амгалан байсаар ирсэн, байх ч болно. Бид зорилгодоо хүрэхийн тулд хэзээ ч бууж өгч болохгүй. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1838–1918) “Хүн төрөлхтөн Бурханы үнэн, Бурханы захиасыг хүлээн авч, . . . тэнгэрлэг болох түүний хүч, эрх мэдлийг хүлээн зөвшөөрөхөөс нааш амар амгалан, хайрын сүнс энэ дэлхийд хэзээ ч ирэхгүй” хэмээн заасан.

Бид ертөнцийн амар амгалангийн төлөө жинхэнээсээ найдаж, залбирдаг хэдий ч хувь хүн болон гэр бүлүүдийнхээ хувьд амлагдсан **зөв шударгын шагнал** болох амар амгаланд хүрдэг. Энэхүү амар амгалан бол Аврагчийн номлол, цагаатгагч золиослолын амлагдсан бэлэг юм.

Амар амгалан гэдэг нь зөвхөн аюулгүй байх эсвэл дайн дажин, хүчирхийлэл, зөрчил сөргөлдөөн, өрсөлдөөнгүй байх явдал биш юм. Амар амгалан бол **Аврагч бидний хэн болохыг мэддэг** гэдгээс мөн **Түүнд итгэлтэй, Түүнийг хайрладаг**, саад тотгор хийгээд зовлон зүдгүүртэй үед ч **тушаалуудыг нь дагадаг** болохыг мэдсэнээс ирдэг (С ба Г 121:7–8-ыг үзнэ үү).

“Хаанаас би амар тайвныг олох вэ? Хаанаас ч би амар тайвныг юу хийвч эс олно. Хэрхэн би амар байж, тайвшрах вэ?” “Хаанаас би амар тайвныг олох вэ?” *Нутмс*, х. 129). **Хариулт нь Аврагч бэлгөө**. Тэрээр амар тайвны эх сурвалж, бүтээгч юм. Тэрбээр “Энхийн жонон” (Исаиа 9:6) билээ.

Бурханы өмнө **өөрсдийгөө даруусгах, үргэлж залбирах, нүглээ наманчлах, гэмшсэн сэтгэл, харууссан сэтгэлтэйгээр баптисмын усанд орох, Есүс Христийн үнэн шавь болох** зэрэг нь амар амгаланд оршихоор шагнуулах зөв шударга хүмүүсийн төгс жишээ юм.

Сүм бол Христийн дагалдагчдын амар амгаланг олж авах хоргодох газар юм. Дэлхий дээрх зарим залуу өөрсдийгөө сүнслэг боловч шашинлаг бус гэдэг. Сүнслэг байдалтай байна гэдэг бол сайн эхлэл. Гэхдээ Сүм дээр биднийг **хүлээн авч, бидэнд заадаг** төдийгүй Бурханы **сайн үгээр тэжээдэг**. Хамгийн чухал нь, Сүм дэх санваарын эрх мэдлээр гэр бүлүүдийг хамтад нь холбож, бидний хүн нэг бүрийг селестиел хаант улсад Бурхан Эцэг, Есүс Христ хоёрт эргэж очиход тэнцэхүйц болоход шаардлагатай **ариун нандин ёслолууд болон гэрээнүүдийг**



хийдэг. Эдгээр ёслол нь Их Эзэнтэй хийдэг гэрээнүүд учраас амар амгаланг авчирдаг юм.

Ариун сүмүүд бол эдгээр ариун нандин ёслолыг гүйцэтгэх мөн дэлхийгээс хоргодох амар амгалан эх үүсвэр болох газар юм. **Ариун сүмийн талбайд очин**, ариун сүмийн нээлттэй хаалганы үйл ажиллагаанд оролцдог хүмүүс ийм амар амгаланг мэдэрдэг.

Эцсийн эцэст Аврагч бол амар амгалангийн эх ундарга мөн. Амьдралд хүнд сорилтууд тохиолддог ч гэсэн, Аврагчийн Цагаатгал болон нигүүлслийн ачаар зөв шударга амьдралын хариуд хувь хүнд амар амгалангийн шагнал ирэх болно (Иохан 14:26–27; 16:33-ыг үзнэ үү). ■

2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс.

Мартагдсан ном, эргэн санасан гэрчлэл

Бүгд над руу харж байв. Би зөвхөн өөрийн энгийн гэрчлэлээр Сүмийг хамгаалж чадах уу?

Абэгэйл Б.Фэррэр

Нэг жил би сүнслэг байдлын хувьд суралцах явцаа сайжруулах зорилго тавьсан юм. Би Бурханы үгээр өлсөж байсан учраас Сүмийн холбогдолтой ном, товхимол, гарын авлага, судрыг сургууль гээд л хаана ч байсан авчирдаг байлаа. Гэтэл удахгүй болох шалгалтандаа бэлдэх гээд завгүй болсноос хойш миний энэ хүчин чармайлт багасаж эхлэв.

Нэг өдөр багш маань ярилцлага өрнүүлэх явцдаа ангид байсан католик шашны бус оюутнуудыг босож зогсохыг хүсэв. Би ангидаа ганцаараа хожмын үеийн гэгээнтэн байсан юм. Өөр зургаан оюутан бас босож зогсов.

Тэгээд бидэнд дараах асуултыг тавив. Та нар ямар сүмд явдаг вэ? Үндэслэгч нь хэн байсан бэ? Танай сүм хэрхэн үүсгэн байгуулагдсан бэ?

Би хамгийн сүүлд хариулах байлаа. Би Сүмийн номнуудаасаа авчраагүйгээ мэдээд сандарч, сурч мэдсэн зүйлээ санах гэж оролдов. Тэр үед Библийн нэг шүлэг санаанд минь орж билээ.

“Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ.

Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно” (Сургаалт үгс 3:5–6).

Би ангийнхныхаа өмнө зоригтой зогсоод, айж сандарснаа ч мартав. Би бол Есүс Христийн Хожмын

үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн гэж хэллээ. Тэгээд би Иосеф Смит хэмээх нэгэн хөвгүүн Бурханыг харсан тухай түүхийг хуваалцав. Чээжинд минь гал дүрэлзэх мэт санагдаж, нүднээс минь нулимс урслаа. Сүм 1830 оны 4-р сарын 6-нд байгуулагдсан гэдгийг хуваалцаад, Бурханы бошиглогч дуудагдан, санваар сэргээгдсэн, мөн энэ бүхнийг үнэн гэдгийг мэддэг хэмээн би гэрчиллээ.

Олон цагаар сайн мэдээг судалж байсан маань хэрэг болов. Энэ нь надад итгэлээ хамгаалан, сайн мэдээнээс хуваалцахад тусалсан юм. Хэдэн долоо хоногийн дараа манай ангийн дөрвөн оюутан Сүмд нэгдэхэд надад бахархах сэтгэл төрж билээ.

Энэ үйл явдал надад гэрчлэл ямар чухал болохыг заасан. Эхлээд би яагаад Их Эзэн надад номнуудаасаа авчир гэсэн сүнслэг мэдрэмж төрүүлээгүй юм бол гэж гайхаж байсан. Тэдгээр нь асуултад төгс хариулахад туслах байсан. Гэхдээ дараа нь Сүмийн талаар бүх зүйлийг чээжлэх юм уу заавал холбогдох материалд тулгуурлах хэрэггүй, харин бид сайн мэдээг судалж, үүний дагуу амьдарч, хуваалцах мөн Ариун Сүнсэнд найдах хэрэгтэй юм байна гэдгийг ухаарсан билээ. Надад ном байгаагүй ч гэрчлэл байсан. ■

Зохиогч нь Филиттинийн Кагаяанд амьдардаг.



ТЭД ТҮҮНИЙГ ХАРСАН

Эдгээр хүн үнэхээр амилсан Аврагчийг харсан ч та өөрийн гэсэн арга замаар Христийн гэрч болж чадна.

Та амилсан Аврагчийг бодитоор харахад ямар байна гэж бодож байна вэ? Есүсийн үед олон зуун хүн үүнийг төсөөлөх шаардлагагүй байсан бөгөөд тэд үүнийг өөрийн биеэр гэрчилсэн юм. Амилсан Их Эзэн хүмүүс дээр ирсэн тохиолдлыг судруудад, тухайлбал Шинэ Гэрээн дээр доод тал нь арван хоёр удаа, Мормоны Номон дээр бас хэд хэдэн удаа дурдсан байдаг. Энэ хүмүүс Есүс Христ үхлийг ялж, бидэнд дахин амьдрах боломжийг олгосон, түүхэн дэх хамгийн агуу гайхамшгуудын нэгийг гэрчилсэн билээ. Гайхамшигтай зүйл биш гэж үү?

Тэгвэл Христийн гэрч байх гэдэг нь яг юу гэсэн утгатай вэ? Судрууд дээрх эдгээр үйл явдлаас цөөн хэдийг авч үзээд, бид Христийг өөрийн нүдээр хараагүй ч хэрхэн Түүний гэрч бас байж болох тухай бодож үзэцгээе.

Магдалын Мариа

Магдалын Мариа хамгийн анхны гэрч байсан. Цовдлуулсны дараах ням гаргийн өглөө тэр хэдэн эмэгтэйтэй хамт Их Эзэний биеийг тослохоор булш руу иржээ. Мариа хоосон булшийг хараад уйлав. Тэр үед хэн нэгэн хүн түүний ард ирээд, “Эмэгтэй, чи юунд уйлна вэ?” гэж асуужээ. Уг хүн үхлээс боссон Есүс байсныг мэдээд тэр хэчнээн их гайхсан бол? (Иохан 20:1-18-ыг үзнэ үү.)



PENNANT © ISTOCK/GETTY-ИЙН ЗУРГУУД

Еммау хүрэх зам дээрх хоёр шавь

Клеопийг өөр нэгэн шавьтайгаа Еммау хүрэх зам дээр алхаж байхад нэгэн үл таних хүн тэдэнтэй зам нийлжээ. Тэд шинэ хамтрагчаа таниагүй бөгөөд оройн хоолны үеэр үл таних хүн талх хуваасан байна. Яг тэр мөчид тэдний нүд нээгдэж, замын турш Аврагчтай хамт аялж байснаа ойлгосон юм. Тэд “Зүрх маань бидний дотор шатаж байсан бус уу...?” гэж бие биенээсээ асуун, Түүнийг үнэхээр өөрсөдтэй нь хамт байсан гэдгийг баталсан мэдрэмжийнхээ талаар тунгаан боджээ. (Лук 24:13-34-ийг үзнэ үү.)



Арван төлөөлөгч

Христтэй хамт Еммау руу аялсан хоёр шавь Иерусалимд буцаж ирээд, бусад арван төлөөлөгчид тохиолдсон үйл явдлынхаа талаар ярьжээ. Тэднийг тийн ярилцаж байх үед Аврагч тэдэн дээр ирээд, “Миний гар, Миний хөлийг хараач.

Энэ чинь Би Өөрөө байна. Надад гараа хүргээд үз. Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм гэв.” (Лук 24:36-41, 44-49-ийг үзнэ үү.)




ТЭР АМИЛСАН, КРЭГ К.ОЛСЭН, ХУУЛБАРЛАЖ БОЛОХГҮЙ.
ЕММАУ ХҮРЭХ ЗАМД, ЖОН МАКНАУТОН
МИНИЙ ГАР, ХӨЛИЙГ ХАРААЧ, ХАРРИ АНДЭРСОН

Төлөөлөгч Томас

Төлөөлөгч Томас Аврагчийг бусад төлөөлөгчид үзэгдэхэд тэнд байгаагүй учраас Христ амилсан гэдэгт итгэхгүй байв. Нэг долоо хоногийн дараа Христ дахин төлөөлөгчид дээр иржээ. Тэр үед Томас тэнд байсан бөгөөд Христийг харсан учраас Түүний амилсанд итгэжээ. Аврагч “чи намайг харсан учраас итгэв үү? Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй еэ!” хэмээн зөвхөн харсныхаа дараа итгэх тухайд Томаст сэрэмжлүүлсэн байна. (Иохан 20:24-29-ийг үзнэ үү.)



ТОМАСЫН ЗУРАГ, БРАЙН КОЛЛ



Тибер нууран дээрх арван нэгэн төлөөлөгч

Амилалтын дараа төд удалгүй нэгэн өдөр хэсэг төлөөлөгч Тибер нуур руу загасчлахаар явсан ч бүтэлгүйтэв. Маргааш өглөө нь Аврагч ирж, тороо завиныхаа баруун талд хаяхыг зөвлөжээ. Тороо хаясны дараа торонд нь бараг татаж гаргаж чадахааргүй их загас орсон аж. Аврагч тэдэнтэй хамт хоол-лосныхоо дараа “Миний хоньдыг тэжээ” хэмээн бусдад тохинуулахын ач холбогдлын талаар заасан юм. Төлөөлөгчид үлдсэн бүхий л амьдралынхаа турш зөвхөн үүнийг буюу Христийн тухай хүмүүст номлох ажлыг хийж, зарим нь бүр уг үйл хэргийн төлөө амиа өгсөн билээ. (Иохан 21:1-22-ыг үзнэ үү.)



ТИБЕР НУУРАН ДЭЭРХ АМИЛСАН АВРАГЧ, ДЭВИД ЛИНДСЛИЙ



НЭГ ХОНЬГИЙН ХОВАРД ЛИОН


Америк тив дэх нифайчууд

Цовдлолтын үеэр Америк тив газар хөдлөлт, гал түймэр, бусад байгалийн гамшгаас болж сүйрч, Аврагчийн үхлийг бэлгэдсэн харанхуй гурван өдөр үргэлжилжээ. Хожим нь Христ тэнгэрээс бууж, Өгөөмөр нутгийн ариун сүмийн ойролцоо цугларсан 2500 хүн дээр ирсэн байна. Тэрээр Өөрийн мутар, хөл, хавирган дахь сорвийг тэмтэрч үзэхэд хүмүүсийг урьж, номлол айлдан, нифайчуудын хүүхдүүдийг нэг нэгээр нь адисалсан юм. Маргааш нь бүр олон хүн цуглаж, Аврагч тэдэн дээр ирж, заажээ. Эцэстээ шавь нар нь Христийн Сүмийг байгуулан, нифайчууд болон леменчүүдийн аль аль нь хүчирхэг гэрчийг хүлээн авсан учир Их Эзэнд хөрвөсөн байна. (3 Нифай 11-18; мөн 3 Нифай 8-10; 4 Нифай 1-ийг үзнэ үү.)

Өнгөрсөн болон өнөө үеийн гэрчүүд

Түүнээс гадна Магдалын Мариад Христийн биеийг тослоход нь туслахаар булшин дээр ирсэн эмэгтэйчүүд, 500 гаруй ах дүү нар, Иаков, Паул гэх мэт олон хүнд Тэр үзэгдсэн юм. (Матай 28:9; Үйлс 9:4-19; 1 Коринт 15:6-7; мөн 3 Нифай 19; 26:13-ыг үзнэ үү.)

Бидэнд эдгээр гэрчийн адил Аврагчийг харах боломж олдохгүй байж болох ч та тэдний адил Христийн гэрч байж чадна. Мариа булш руу явахдаа Аврагчийг эрэлхийлсэнтэй адил та Түүний талаар илүү их судалснаар Түүнийг хувь хүнийхээ хувьд эрэлхийлж болно. Эсвэл та зарлигуудыг сахиж, бошиглогчдын зөвлөгөөг дагаснаар Түүнд итгэх итгэлээ хөгжүүлж болно. Та бас Еммау руу явах замд таарсан хоёр шавийн адил өөрийн амьдралд буй Аврагчийн адислалуудыг таньж мэдэх болно. Энэхүү Христийн амилсны баярын өдрүүдэд Христийн гэрч байх гэдэг нь ямар утга учиртай талаар бодоорой. Эдгээр хүн амилсан Христийг амьдаар нь харсан гэрчүүд боловч энэ нь таны Түүнийг амьдралдаа гэрчлэх цорын ганц арга зам биш юм. ■



ТҮҮНИЙ ТАЛААР СУРАЛЦ

“Та нар Христийн талаарх Ариун Сүнсний гэрчлэлийг өөр өөр туршлага, нөхцөл байдалд сүнсэнд тань ахин дахин баталж өгөхийг мэдэрснээр болон өдөр бүрийн амьдралдаа Түүний үлгэр жишээний гэрлийг өндөрт өргөхийг хичээснээр мөн бусдад гэрчлэлээ хуваалцаж, Түүний талаар сурч мэдэн,

Түүнийг дагахад тусалснаар Есүс Христийн гэрч болдог.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон, “Becoming a Witness of Christ,” *Liahona*, 2008 оны 3-р сар, 63.

БИДНИЙ ОРОН ЗАЙ

БУРХАН БИДЭНД БАГАЖ ЗЭВСЭГ ӨГДӨГ

Авга ах маань урлагийн хүн бөгөөд жижиг модон усан онгоцтой шилэн лонх хийдэг. Үүнийг хийхэд маш их цаг хугацаа, анхаарал, хичээл зүтгэл шаарддаг.

Нэг өдөр би түүний бүх багаж хэрэгслийг хараад, хэрхэн багаж хэрэгсэл нэг бүрийг усан онгоцны тодорхой нэг хэсгийг буюу хэвийг хийхэд хэрэглэдэг болохыг анзаарсан. Би түүний ажиллаж байгааг харсан бөгөөд эдгээр усан онгоцыг хийхэд багаж хэрэгслээ хэрхэн ашиглаж байгаа нь гайхалтай санагдсан юм. Энэ нь надад Нифайн усан онгоц барьсан түүхийг сануулав (1 Нифай 17–18-ыг үзнэ үү). Тэр завиа хүмүүний аргаар биш, Их Эзэний аргаар барьсан. Бурхан бидэнд өөрсдийн гэсэн усан онгоцыг Өөрийнх нь арга замаар барих багаж хэрэгслүүдийг өгсөн. Судрууд, итгэл, Бурханы хайр зэрэг нь өөрийн усан онгоцыг тун хянамгай байж, ямар ч завсар зайгүй барихын тулд амьдралдаа хэрэглэх ёстой багаж хэрэгслүүд юм. Бид өдөр бүр Их Эзэний шавь байхад суралцаж байна. ■

Мариа Мэрсэдэс Ж., Венесуэлийн Монагас муж



ГАНЦААРДЛЫГ МЭДЭРСЭН НЬ

Дани улсад хүйтэн хавар болж байлаа. Би дөнгөж бүрэн цагийн номлолдоо үйлчилж эхлээд байсан бөгөөд гэрчлэл маань гуйвж байв. Би Сүмд хөрвөөд дөнгөж 19 сар өнгөрч байсан бөгөөд гадаад улс орон, ярьж чадахгүй шинэ хэл, зүг чигээ олж чадахааргүй сүлжилдсэн гудамжтай газар очно гэхээс айж байлаа. Нэгэнтээ талархлаар дүүрэн байсан залбирал маань “Бурхан минь, та яагаад намайг ганцаардуулж орхив?” хэмээх гашуун, буруушаасан зүйл болон хувирсан юм.

Нэгэн өглөө би Түүнд хандан залбиран гуйлаа. Харин энэ

удаа “Яагаад” гэж зүрх сэтгэлдээ уурлан бухимдахын оронд сайн мэдээ үнэн гэсэн гэрчийг өгч, эргэлзээг минь тайлж өгөхийн төлөө гуйв.

Би залбирсныхаа дараа судрын хуудсыг нээхэд “Тууштай, зоригтой бай. Чиний Бурхан Эзэн чамтай хамт явдаг учраас тэднээс бүү ай, тэдний өмнө бүү чичир. Тэр чамайг орхихгүй, чамайг хаяхгүй” (Дэд хууль 31:6) гэсэн судар гарч ирсэн юм.

Би Бурхан үргэлж надтай хамт байсан гэдгийг мөн залбирлынхаа хариултыг авсан гэдгээ ойлгон ухаарахад зүрх сэтгэл минь баяр баялаар дүүрч билээ. Намайг орхиж явлаа гэж буруутгагдсныхаа дараа

Тэр надаас чин сэтгэлийн залбирлыг маань л хүлээж байв.

Бүр гарах гарцгүй санагдаж байсан ч Бурхан намайг хэзээ ч орхихгүй. Бид залбирал болон судраар дамжуулан Түүний хайрыг мэдэрч чадна. ■

Клэйтон Э, АНУ-ын Техас муж

ОДОО ТАНЫ ЭЭЛЖ

Лиахона таныг сайн мэдээний дагуу ламьдарснаар олж авсан туршлага, төрж буй сэтгэгдлээ ирүүлнэ үү хэмээн урьж байна. Та түүхээ liahona.lds.org вэбсайтаар эсвэл liahona@ldschurch.org э-мэйл хаягаар бидэнд рүү илгээж болно. Өөрийн овог нэр, тойрог, гадас мөн эцэг эхийн зөвшөөрлийг хавсаргана уу.

УРАГШАА, ХРИСТИЙН ЦЭРГҮҮД ЭЭ

“Селестиел хаант улсад суудалтай болохыг хүссэн эрэгтэй,
эмэгтэй хүмүүс өдөр бүр тулалдах хэрэгтэйгээ олж мэддэг.”

Teachings of Presidents of the Church: Brigham Young (1997), 294.



“Бурхан залбирлыг маань сонсож байгаа гэдгийг би хэрхэн мэдэх вэ?”

Залбирал бол агуу адислал бөгөөд Тэнгэрлэг Эцэг биднийг үргэлж сонсоно гэж амласан ч Түүний хариултыг ойлгож мэдэхэд ихэвчлэн хичээл зүтгэл гаргах хэрэгтэй байдаг.¹

Бурхан таныг сонсдог эсвэл сонсдоггүй гээд бодоод үз дээ. Хэрэв Тэр сонсдоггүй бол мэдээж залбирах шаардлагагүй. Гэхдээ Тэр сонсдог бол (Тэр сонсдог!) бид Түүнтэй хэрхэн залбирлаар *жинхэнээсээ* харилцах, хариултыг олж таних, итгэлтэй урагшлах зэрэг арга барилыг олох хэрэгтэй.

Бид Түүнийг сонсохгүй байна гэж мэдэвэл хувийн өсөлт хөгжил дээрээ ажиллах шаардлагатай байж магадгүй. Та өөртөө дараах хэдэн асуултыг тавьж болох юм. Би цэвэр ариун уу? Би зохистой зүйлс эзддэг үү? Би Түүний хий гэсэн зүйлийг хийх хүсэлтэй юу?² Хэрэв эдгээрт бүгдэд нь “тийм” гэж хариулсан бол “чиний Бурхан Их Эзэн . . . залбирлуудад чинь хариу өгөх болно” (С ба Г 112:10) гэдэгт итгэж болно. Заримдаа хариултууд үл мэдэгдэх эсвэл санаанд оромгүй арга замаар ирдэг гэдгийг бүү март.

Хэрэв та зарим асуултад үгүй гэж хариулсан бол оройтоогүй шүү! Ариун Сүнстэй байхын тулд амьдралдаа шаардлагатай өөрчлөлтийг хий. Хүлээн авсан сүнслэг өдөөлтийнхөө дагуу үйлдэх хүсэлтэй бай.

Хүн бүр хариултаа өөр өөр арга замаар хүлээн авдаг гэдгийг санаарай. Ариун Сүнс *танд* хариултаа хэрхэн таньж мэдэхийг зааж өгөөрэй хэмээн залбир. Эхлээд тэдгээрийг таньж мэдэх нь хялбар бус байж болох ч аливаа ур чадварын адил үүнийг төгс эзэмшихийн тулд дадлага хийх хэрэгтэй. Тэнгэрлэг Эцэг *үргэлж* сонсож байдаг гэдэгт итгэ, найд.

ЭШЛЭЛҮҮД

1. Матай 7:7; Иаков 1:5–6; Алама 33:4–11; Сургаал ба Гэрээ 8:1–2-ыг үзнэ үү.
2. Ричард Г.Скотт, “Learning to Recognize Answers to Prayer,” *Ensign*, 1989 оны 11-р сар, 32.



Сүнсийг сонс.

Ариун Сүнсийг сонсохыг хичээ. Хүмүүс Ариун Сүнсийг олон арга замаар сонсдог учраас сүнслэг өдөөлт

танд мэдрэмж маягаар ирэх үед та намуун, зөөлөн дуу хоолой сонсохыг хүлээж байж болох юм. Ариун Сүнс таны мэдвэл зохих бүх зүйлийг хэлж өгнө гэдгийг би мэдэх учраас та зөвхөн сонсох л хэрэгтэй.

Элис Г., 13 настай, Канадын Алберта

Хариултыг Сүмээс олж болно

Би нэг удаа Сүмийн гишүүн бус хүнтэй болзоонд явах эсэх талаар нэлээн эргэлзсэн юм. Нэгэн ням гаргийн ариун ёслолын цуглаан дээр нэг эгч надад зориулсан мэт үгийг хэлж билээ. Тэр үед би Их Эзэн миний залбиралд хариулсан гэсэн баталгааг хүлээн авсан юм. Өмнө нь би юу хийхээ мэдэхгүй эргэлзэж байсан бол яг тэр мөчид Ариун Сүнс намайг тайвшруулан, зүрх сэтгэлийг маань баяр баясгалан, эр зоригоор дүүргэсэн. Бурхан бидэнд мэдрэмж, бодлоор мөн судраар, тэр ч бүү хэл Сүм дээр үг хэлсэн хүмүүсээр дамжуулан хариулдаг!

Карэн В., 19 настай, Бразилын Минас Жераис



Хэн гэдгээ сана

Залбирал зүрх сэтгэлд маань амар амгалан, тайвшрал, хайрыг бий болгодог учраас Бурхан биднийг

сонсдог гэдгийг би мэднэ. Тэрээр өдрөөс өдөрт олон аюулаас намайг чөлөөлөн, гэр бүлийг минь хамгаалдаг болохыг би харсан бөгөөд намайг хайрладаг гэдгийг мэдэрдэг.

Би сургуульдаа явахаасаа өмнө Залуу эмэгтэйчүүдийн уриаг үргэлж хэлдэг. Энэ нь намайг хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн охин гэдгээ санахад надад тусалдаг юм.

Никол М., 19 настай, Перугийн Лима



Хүүхдийн залбирал

Хүүхдийн хэсгийн “Хүүхдийн залбирал” (*Children's Songbook*, 12) дууны үгэнд: “Тэнгэрлэг Эцэг, Та тэнд

байдаг уу? Хүүхэд бүрийн залбирлыг Та сонсож, хариулдаг уу? Тэнгэр биднээс хол байдаг хэдий ч залбирах үедээ ойр гэдгийг мэддэг” хэмээх үгс байдаг учраас Тэнгэрлэг Эцэг миний залбирлыг сонсдог гэдгийг би мэднэ. Би энэ дууг санах үедээ Ариун Сүнсний болон намайг гэх Тэнгэрлэг Эцэгийн эцэс төгсгөлгүй хайрыг мэдэрдэг учраас Тэр намайг сонсож байгаа гэдгийг мэддэг. Би Тэр намайг хайрладаг гэдгийг санах үедээ тайвшрах шиг болж, залбирлыг маань сонсдог болохыг мэддэг.

Элэйн Б., 16 настай, АНУ-ын Хойг Каролина

Түүнд итгэ

Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг байнга сонсдог ч залбиралд маань хэрхэн мөн хэзээ хариулахаа хэлдэггүй учраас зарим үед бидэнд хариулахгүй байгаа мэт санагддаг. Бид өөрсдийн хүслийг Түүний хүсэлд нийцүүлэх хүсэлтэй гэдэгтээ мөн Тэр бидэнд юу хамгийн сайн болохыг мэддэг гэдэгт итгэх хэрэгтэй. Тэнгэрлэг Эцэг биднийг хайрладаг бөгөөд залбиралд маань хариулахдаа суралцаж, өсөж хөгжихөд маань туслахыг үргэлж хичээх болно.

Мозая М., 17 настай, АНУ-ын Юта

Асуу, тэгвэл та нар хүлээж авах болно

Хэрэв бид Бурханд итгэлтэй, чин хүсэлтэй хандвал Тэрээр үргэлж бидний залбирлыг сонсож, хариулна гэдгийг судраар дамжуулан заадаг. Бид зүрх сэтгэлдээ Тэр биднийг сонсдог гэсэн баттай нотолгоог мөн амар амгалан, тайван мэдрэмжийг мэдэрнэ. Түүнчлэн, хэрэв бид Эцэгийн хүслийг дагавал бүх зүйл сайн байх болно гэдгийг мэдрэх боломжтой. Хэрэв бид Тэр биднийг сонсдог гэдэгт эргэлзэж байвал судраас удирдамж эрэлхийлэн, уншсан зүйл маань үнэн эсэхийг асуух нь зүйтэй.

Констанза Л., 20 настай, Чилийн Био Био

Хайж ол

Би нэг удаа Бурхан залбирлыг маань сонсдог болов уу гэж бодож байхдаа зүрх сэтгэлдээ хариултыг нь мэдэрсэн. Би залбирлын талаар хуваалцсан нэг хүний гэрчлэлийг сонсож, Ариун Сүнсийг мэдэрч билээ. Би бас та нарт эцэг эх, бишоп, тойргийнхоо бусад гишүүнээс асуу хэмээн өөр нэг зөвлөгөө өгөх гэсэн юм. Түүнээс гадна та энэ сэдвээр тусламж хүсэн залбирч болно шүү дээ!

Иошуа С., 13 настай, АНУ-ын Орегон



БҮҮ БУУЖ ӨГ

“Дуулгавартай бай, өмнө нь Сүнс мэдэрч байсан цаг мөчөө эргэн

сана, тэгээд итгэлээр асуу. Танд хариулт ирэх болно. Та Аврагчийн хайр, амар амгаланг мэдрэх болно. Хариулт таны хүссэнээр хурдан эсвэл хүссэн загвараар тань ирэхгүй байж болох ч хариулт ирэх л болно. Бүү шантар, бүү бууж өг.”

Жэймс Б.Мартин, “Түүн рүү эргэ, хариулт ирэх болно,” 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 47.

Чин сэтгэлээсээ залбир

Залбирсныхаа дараа зүрх сэтгэлдээ төрөх мэдрэмж, бодол санааг сонсож болно. Тэдгээрийн нэг нь залбирлын тань хариу байж болох юм. Бид чин сэтгэлээсээ, үнэн хүсэлтэйгээр залбирах юм бол Тэнгэрлэг Эцэг маань Өөрт нь итгэх бидний итгэлийн дагуу хариулдаг. Тэр зөвхөн бидний сониуч занг даргах гэж хариулдаггүй. ■

Жан-Клог Н., 16 настай, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Төв Касаи

ДАРААГИЙН АСУУЛТ

“Би хэрхэн бусдын талаар муу эсвэл зохисгүй зүйл ярьж байгаа найз нөхдөөсөө ийнхүү ярихаа боль гэж хүсэх вэ?”

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай зургийн хамт lahona.lds.org хаягаар (“Өгүүлэл оруулах” дээр дарна), э-мэйл бичих бол lahona@ldschurch.org хаягаар 2017 оны 5-р сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Дараах мэдээллийг хавсаргана уу. Үүнд: (1) Овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн зөвшөөрөл эсвэл 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичсэн зөвшөөрөл (э-мэйл байж болно).

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлах магадлалтай.

Андрей ба муухай үг

Жюли К.Доналдсон

Бодит түүхээс сэдэвлэв

“Би наманчлан, илүү сайн хийж, залбирахыг хичээх болно.” (Children’s Songbook, 98).

“**Ч**и хараалын үг хэлдэггүй болохоороо өөрийгөө бусдаас илүү сайн гэж бодож байна уу?” хэмээн Николай завсарлагаанаар хэлэв.

“Энэ чинь худлаа шүү дээ” гэж Андрей хариуллаа.

“Тэгвэл чи нэг хараалын үг хэлээд үз дээ? Ердөө л ганцхан үг. Нэг үг хэллээ гээд чи үхэхгүй. Бүгд л хараал хэлдэг шүү дээ” гэв.

Андрей мөрөө хавчаад, “Би зүгээр л хэлэхийг хүсэхгүй байна” гэж хариуллаа.

Андрей хараал хэлэх нь буруу мөн Ариун Сүнсийг холдуулдаг гэдгийг мэдэж байв. Тэр мөн Ариун Сүнсийг өөртэйгөө хамт байлгахыг хүсжээ. Тиймээс тэр хараал хэлсэнгүй.

Андрейг шинэ сургуульд шилжиж ирэхэд, зургаадугаар ангийнхнаас өөртэй нь найзлахыг хүссэн цорын ганц хүн байсан нь Николай байв. Гэтэл Николайн өдөр бүр хараал хэлдэг

нь түүнийг залхааж байлаа. Мөн өдөр бүр Андрей үгүй гэж хэлэхээс ч залхаж эхлээд байв. Түүнээс гадна Николай түүнтэй найзлахаа болих вий, тэгэх юм бол ганцаардах байх гэхээс бас эмээж байлаа.

Хичээл тарсны дараа Николай “За,

ганцхан хараалын үг хэлчихээч. Тэгвэл би чамаас дахин хэл гэж шалгаахгүй” гэж хэллээ.

Эцэст нь Андрей залмаар байдлаас гарахын тулд *арай* гайгүй нэг муу үг хэлэв.

Николай ч толгой дохиод, “Сайн байна.

Чи одоо бидний нэг боллоо” гэлээ.





Үүний дараа Николайг бусад найз Андрейтэй ярьдаг болов. Тэд түүнтэй хамт үдийн хоолоо идэн, завсарлагаанаар хөл бөмбөг тоглодог байлаа. Гэхдээ Николайг найзуудтай хамт байхад яг л шигддэг элсэн дээгүүр явж байгаа мэт байдаг байв. Тэр тэдэнтэй хамт цагийг өнгөрүүлэх тусам илүү адилхан ярьж, үйлддэг болж ирэв. Тэд бүгд хараал хэлдэг байсан. Маш их гээч. Тэд инээлдэн, бие биенээ доромжилдог байв. Тэд бас багш нарынхаа тухай бүдүүлэг зүйл ярьж, уурлан, үргэлж муухай аашилдаг байлаа. Андрей аажим аажмаар уурлан бухимдах болж, олон шалтгаанаар хараал хэлэх болов.

Андрей нэг орой аав, ээжийгээ явсан хойгуур Катя эгчтэйгээ юу үзэх тухайд маргалдлаа. Андрейг бодож ч амжаагүй байтал хараалын үг амнаас нь гарав.

Катя гайхаж цочирдон, “Би ээжид хэлнэ дээ” гэлээ.

Андрей унтлагынхаа өрөө рүү гүйж орон, хаалгаа савж хаагаад, “Энэ хүмүүс чинь яачихаад байгаа юм бэ? Яагаад бүгдээрээ үргэлж миний уурыг хүргэж байдаг юм бэ?” гэж бодов. Аав, ээж хоёр нь гэртээ эргэж ирэхэд Андрей хаалгаа бага зэрэг онгойлгоод, Катягийн “Ээж ээ, Андрей над руу хараалын үг хэлсэн” гэхийг сонсов.

Ээж нь “Юу? Андрей хэзээ ч хараалын үг хэлж байгаагүй шүү дээ” гэж гайхан дуу алдахыг сонслоо.

Андрей хаалгаа хаагаад, орон дээрээ пид хийтэл унав. Тэр хараал хэлдэг болсноосоо хойш ямар их өөрчлөгдсөн талаараа бодлоо. Ариун Сүнс мэдрээгүй маш их удсан байв.

Андрей орныхоо хажууд өвдөг сөгдөөд, “Хайрт Тэнгэрлэг Эцэг минь, намайг муухай аашлан, уурладаг болсонд уучлаарай. Хараал хэлдэг болсныг маань уучлаач. Би илүү сайн байх болно” гэж залбирлаа.


Андрейг залбирахад дулаахан мэдрэмж зүрх сэтгэлийг нь дүүргэв. Тэр хараал хэлдэг болсноосоо хойш анх удаа үнэхээр аз жаргалтай байлаа. Бурхан түүнд хайртай гэдгийг мэдэж мөн Ариун Сүнийг мэдэрчээ. Тэр өршөөгдсөн гэдгээ мэдэрч мөн өөрчлөгдөж, илүү сайн болж чадна гэдгээ мэдэж байв.

Тэр залбирсныхаа дараа ээждээ үнэнээ хэлэн,

Катягаас уучлалт гуйв. Үүний дараа сэтгэл нь онгойжээ. Наманчилсан болохоор сайхан байв.

Маргааш нь Андрей сургууль дээрээ Николайг бүлгийнхэнтэй үдийн хоол идсэнгүй. Харин таньдаггүй өөр хүүхдүүдийн хажууд суужээ. Цаг хугацаа шаардагдах ч гэсэн Андрей сайн, аз жаргалтай, хараал хэлдэггүй хүүхдүүдтэй найз болно гэдгээ мэдэж байв. Яг л түүн шиг. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



ЗС

ДААЛГАВАР

“Би Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын нэрийг хүндэтгэлтэйгээр хэрэглэх болно. Би хараал болон бүдүүлэг үг хэлэхгүй. (Миний сайн мэдээний жишгүүд)

Цаасны нэг талд сайхан үг танд ямар сэтгэгдэл төрүүлдэг тухай бич эсвэл зур. Нөгөө талд нь муухай үг танд ямар сэтгэгдэл төрүүлдэг тухай бич эсвэл зур.

Левит 19:12-ыг унш. Яагаад Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн нэрийг хүндэтгэлтэй хэрэглэх нь чухал вэ?

Эцэг эх эсвэл удирдагчаасаа яагаад бид сайхан үг хэллэг ашиглах хэрэгтэйг мөн энэ нь хэрхэн тэднийг адисалсан талаар асуу.

Би өөртөө . . . даалгавар өгөв.





Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
Ахлагч
Дэвид А.Бэднар

Би гэр бүлийнхэндээ хүчтэй байхад нь хэрхэн тусалж чадах вэ?



Та нар гэр бүлийнхэндээ хайртай гэдгээ хэлээд, үүнийгээ үйлдлээрээ харуул.



Ариун Сүнсний гэрчилсний дагуу үнэн гэж мэддэг зүйлсийнхээ талаарх өөрийн гэрчлэлийг илэрхийл. Хамгийн их хайрладаг хүмүүстэйгээ гэрчлэлээ хуваалцаарай.



Гэр бүлтэйгээ хамт гэр бүлийн залбирал хийж, судар судлахад дуртайяа нэгд. Гэр бүлийн үдэшт идэвхтэй оролцож, үүнийг хөгжилтэй байдлаар хий.



Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг хайрлаж, үүнээс суралцаж мөн дагаж амьдрахад итгэл төгс бай.



Хүүхдийн
хэсгийн ерөнхий
ерөнхийлөгч

Жой Д.Жонс

Өдөр бүр АРИУН СҮМД ОРОХОД БЭЛД

Намайг есөн настай байхад Кохлэр эгч гэдэг нэгэн Нгайхалтай Хүүхдийн хэсгийн багш байсан. Би маш ичимхий хүүхэд байсан ч тэр үнэхээр зөөлөн хүн байсан тул түүнтэй хамт байх дуртай байлаа. Нэгэн өдөр тэр хүн бүрд хуудас цаас өгөөд, бүгдээрээ өсөж том болсныхоо дараа юу хийхийг хүсэж байгаагаа бич гэсэн юм. Би “Коллежид сурч, ариун сүмд гэрлэнэ” гэж бичив. Би цаасаа шүүгээнийхээ хаалган дээр наалаа. Шөнө болоход гудамжны гэрэл манай цонх руу тусахад би цаас руугаа хардаг байв. Энэ нь надад ариун сүм рүү явахыг хүсэж байгааг маань сануулдаг байсан юм.

Тэр үед дэлхий дээр дөнгөж 12 ариун сүм байсан бөгөөд би бүх ариун сүм рүү очихыг хүсдэг байлаа.

Аав, ээж маань аялаа төлөвлөж, гэр бүлээ ариун сүм рүү байнга авч явдаг байж билээ. Бид АНУ-ын Орегонд амьдарч байсан бөгөөд хамгийн ойр байх ариун сүм 965 км-т, Канадын Алберта мужийн Кардстон хотод байдаг байв. Машинд маань агааржуулагч байгаагүй бөгөөд би ах, эгч хоёрынхоо хамт арын суудал дээр сууж явсан юм. Бид машиныхаа цонхоор нойтон алчуураа гарган сэвээд, дараа нь хүзүүн дээрээ тавьж сэрүүцэж байлаа.

Тэгээд эцэст нь ариун сүмийг олж хараад, үнэхээр их сэтгэл хөдөлж билээ. Тэнд юу болдог талаар би сайн мэддэггүй байсан ч ээж, аав хоёр маань гарч ирэхдээ үргэлж аз жаргалтай байдаг байв. Би ариун сүм үнэхээр чухал газар гэдгийг, бас энэ нь Их Эзэний өргөө гэдгийг мэдэж байсан. (Зурган дээр би цагаан цамцтай байгаа болно.)



Би 12 нас хүрээд, хэд хэдэн ариун сүмд ариун сүмийн баптисм төлөөлөн хүртсэн. Дараа нь ирээдүйн нөхөртэйгөө танилцаад, ариун сүмд хайртай болохыг нь бас мэдсэн гээч! Бид Ютагийн Мантай ариун сүмд гэрлэсэн юм.

Та ариун сүмд ороход өдөр бүр бэлдэж болно. Боломж гарах бүрд ариун сүмд орж бай. Хананд нь хүрч үзээрэй. Ач хүү Жаррэт маань 11 настай байхдаа ням гараг бүр аавтайгаа хамт гэр бүлийн түүх дээрээ ажилладаг байсан. Тэр маш олон өвөг дээдсийнхээ нэрийг олсон. Тэр одоо 12 настай бөгөөд эдгээр өвөг дээдсийнхээ өмнөөс ариун сүмд баптисм хүртэж байгаа.

Та ариун сүмд байхдаа Есүсийн алхсан замаар алхаж болно. Энэ бол Түүний өргөө. Таныг ариун сүмд орж, Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдрэхийн тулд бэлдэхэд туслахыг өдөр бүр Түүнд хандан залбирч гуйна гэдэгт би найдаж байна. ■

Стар од мэт гялалзана

Жэйн Макбрайд

Бодит түүхээс сэдэвлэв

“Тантай хамт Хүүхдийн хэсэгт байх сайхан байдаг” (Children’s Songbook, 254).

Стар хувцсаа өмсөж байлаа. Сүм рүү даа шинэ өмсөж явах нь хачин санагдсан хэвээр байв. Түүний явдаг байсан өөр сүмд охид ням гарагт өмд эсвэл шорт өмсдөг байсан. Харин шинэ сүмд өөр байлаа. Тэр саяхан ээжтэйгээ хамт Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртээд байв.

Стар өөрийгөө толинд хараад, санаа алдлаа. Тэр анх удаа албан ёсны гишүүний хувьд сүмд явах гэж байгаадаа баярлахын зэрэгцээ сандарч байв. Урьд нь тэр сүмд ээжтэйгээ хамт байсаар тардаг байв. Харин одоо тэр Хүүхдийн хэсэгт орно.

Стар толинд өөрийгөө харснаа нүдээ анивчив. Тэр ангидаа дасаж чадахгүй бол яах вэ? Бусад хүүхэд түүнд дургүй байвал яах вэ?

“Стар аа? Чи бэлэн үү?” гэж ээж нь асуув.



Стар шатаар буугаад, “Би зүгээр харагдаж байна уу?” гэж асуулаа.

Ээж нь инээмсэглээд, “Чи хөөрхөн харагдаж байна” гэв.

Стар нүүрээ урвайлган, “Мэдээж та тэгж л хэлнэ шүү дээ. Та чинь миний ээж биз дээ” гэхэд ээж нь

“Чиний зөв. Ингэж хэлэх нь миний үүрэг шүү дээ. Яагаад гээч, үнэн болохоор л тэр” гэлээ.

Стар инээмсэглэв. Ээж нь түүнийг яаж баярлуулахаа сайн мэддэг байлаа. Гэхдээ л тэр дотроо сандарсаар байв. Нэг ч хүүхэд түүнтэй ярихгүй бол яах вэ? Түүнд сургуулийн найзууд байдаг ч тэд шинэ сүмийнх нь гишүүн биш байлаа. Өөртэй нь нэг ч гэсэн найз нь сүм рүү хамт явдаг ч болоосой гэж хүсэв.

Тэр ээждээ “Би нэг зүйл хийхээ мартсан байна” гэж хэллээ.

Тэр дээшээ гараад, орныхоо хажууд өвдөглөн суугаад, “Хайрт Тэнгэрлэг Эцэг минь, найзтай болоход туслаач. Номлогчдын заасан зүйлс үнэн гэдэгт би итгэж байгаа ч айж байна” гэлээ.

Стар өвдөглөн суусан хэвээрээ сонсов. Хэсэг хугацааны дараа түүнд сайхан, амар тайван мэдрэмж

төрж, дахиж сандрхаа болив.

Сүм дээр Стар ээжтэйгээ хамт гурван бяцхан охинтой нэгэн гэр бүлийн хажууд суулаа. Тэдний эцэг эх цуглаан эхлэхээс өмнө өөрсдийгөө танилцуулаад, ээжтэй нь ярьж эхлэв. Харин Стар охидод Есүсийн зургийг будахад тусаллаа.

Андрю бишоп гэдэн рүү чиглэн ирээд, “Каннинхам эгч ээ! Стар аа! Та нарыг өнөөдөр харах сайхан байна” гэв. Тэр тэдэнтэй халуун дотноор гар барин мэндчилээд, тэвэрлээ. Стар сүм дээр хүмүүс ямар эелдэг байдгийг мартсан байжээ. Тэр одоо найзтай болж ч магадгүй.

Ариун ёслолын дараа Стар Хүүхдийн хэсэгт орлоо. Тэр суудалдаа суунгаа бусад хүүхэд рүү сандрангуй харлаа. Тэд бие биетэйгээ ярьж, өөрийг нь анзаарахгүй байгаа бололтой. Стар сэтгэлээр унав. Эцэст нь тэр ганцаараа л байх нь дээ.

Яг тэр үед Стартай нас чацуу нэгэн охин өрөөнд орж ирэв. Стар “Тэр ч бас сандарч байна даа. Би түүнтэй ярьж болох юм” гэж бодлоо.

Тэр гүнзгий амьсгаа аваад, тэр охин руу очив. “Сайн уу. Намайг Стар гэдэг. Би шинээр ирсэн. Чи миний хажууд суумаар байна уу?” гээд амьсгал даран хүлээв. Тэр охин түүний найз болох болов уу?

Охин инээмсэглэхчээ аядсанаа, “Намайг Сара гэдэг. Би ч бас шинээр ирсэн. Манай гэр бүл саяхан Онтариогоос нүүж ирсэн” гэлээ.



“Би ээжтэйгээ хамт хоёр долоо хоногийн өмнө баптисм хүртсэн. Би юу хийхээ сайн мэдэхгүй байна” гэж Стар хэлэв.

Сара инээмсэглээд, “Хоёулаа хамтдаа учрыг нь олно доо” гэлээ.

Стар, Сара хоёр суудалдаа суув. Стар Сара руу үе үе харан, инээмсэглэхэд тэр хариу инээмсэглэв. Старын сэтгэл тайван, баяртай байлаа. Тэнгэрлэг Эцэг залбирлыг нь сонсож, найзтай

болоход нь тусалсан гэдгийг тэр мэдэж байлаа.

Ангид багш Стар, Сара хоёроос өөрсдийгөө танилцуулахыг хүсэв.

Стар босоод, “Намайг Стар Каннинхам гэдэг. Би ээжтэйгээ хамт хоёр долоо хоногийн өмнө баптисм хүртсэн” гэж хэлэв. Тэр түр азнаад, шинэ найз руугаа харан инээмсэглээд, “Энэ миний найз Сара” гэлээ. ■

Зохиогч нь АНУ-ын Колорадоод амьдардаг.

ЭНЭ ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЖ БОДНО УУ

Та сүм дээр шинээр ирсэн хэн нэгнийг хэрхэн утган авах вэ?

Гэрэл нь бай

Элизабэт Пинбороу

Хайрлах

Хов ярихгүй байх

Уучлах

Дэмжиж туслах

Урамшуулан дэмжих

Урих

Сонсох

Найзлах

“Дэлхийд туяарч болохын тулд гэрлээ өргөгтүн. Болгоогтун би бол та нарын өргөх тэрхүү гэрэл билээ” (3 Нифай 18:24).

Бид жинхэнэ найз нөхөд байснаар бусдад гэрэл нь байж чадна. Доорх санаануудыг уншаад, өөрийнхөө санааг нэм. Хайраа үзүүлэхийг хүссэн хүнийхээ нэрийг бичих бүрдээ нарыг буд.

1. **Бусдыг хайрла.** Та тэдний амьдралд том өөрчлөлт гаргаж чадна! Христ тэднийг хайрладаг учраас тэдэнд тэрхүү хайрыг харуулахыг хичээ.

Хэн: _____

2. **Уучил.** Хэрэв хэн нэгэн таныг гомдоовол тэдний байр сууринаас харахыг хичээ. Хэрэв та тэднийг уучилбал зүрх сэтгэлийг нь зөөлрүүлж чадна.

Хэн: _____

3. **Урамшуулан дэмж.** Найз нөхдийнхөө давуу талыг сайшаа. Хэдийгээр тэдэнд засаж сайжруулах зүйл байгаа ч гэлээ, сайн талыг нь олж хар. Та хамгийн сайнаараа байх нь тэдэнд бас тус болдог!

Хэн: _____

4. **Ариун Сүнсийг сонс.** Таны үгс муу нөхцөл байдлыг ч сайн болгон өөрчлөх боломжтой. Ариун Сүнс танд ямар үг хэлэхийг мөн хэрхэн сайхан сэтгэлээ харуулахыг олж мэдэхэд тань тусалж чадна.

Хэн: _____

5. **Хэзээ ч хов жив ярьж болохгүй.** Муу үг хүнийг гомдоодог. Хүмүүс сайн гэдэгт эргэлзэхгүй байж, сөрөг муу бодлоос татгалз.

Хэн: _____

6. **Найз нөхдөө дэмж.** Найзынхаа спортын арга хэмжээнд эсвэл сургуулийнх нь тоглолтод очих нь тэдэнд таны хайрыг мэдрэхэд тусална.

Хэн: _____

7. **Сайн мэдээнээс суралцахад бусдыг урь.** Хэдийгээр тэд таны хэлснийг хүлээн авахгүй ч та түүнд анхаарал халамж тавьдаг гэдгээ харуулсан.

Хэн: _____

8. **Янз бүрийн хүмүүстэй найзал.** Бусдад хуваалцах олон сайн сайхан зүйл байдаг. Христ юу ч болсон бай бүх хүнд тусалж, тэднийг хайрласан.

Хэн: _____

Сайн мэдээг түгээх нь

Сүмийн түүхийн талаар хуваалцахдаа эдгээр түүхийг ашигла!



Самуел Смит



Хайрум Смит



Парлей П.Пратт

Сүм зохион байгуулагдсаны дараа Тэнгэрлэг Эцэг хүн бүр сайн мэдээг сонсоосой хэмээн хүссэн. Иосеф Смитийн дүү Самуел анхны номлогч байсан. Иосефын ах Хайрум мөн адил бусдад сайн мэдээний тухай заадаг байв. Нэг өдөр Парлей Пратт хэмээх нэг хүн өдөржингөө Мормоны Ном уншсан тухайгаа Хайрумд ярьжээ. Хайрум түүнд Сүмийн талаар илүү ихийг заасан бөгөөд улмаар тэр баптисм хүртсэн юм. Харин дараа нь Парлей номлолд үйлчилжээ. Тэр Сүмийн агуу удирдагч болсон.

Сүмийн түүхэн дэх онцгой хүмүүсийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг iahona.lds.org-оос авна уу.



Есүсийн тухай бодох нь

Линдси Таннэр

Бодит түүхээс сэдэвлэв

Миагийн сэтгэл их догдолсон байлаа. Тэр анх удаа Сүмд ирсэн нь энэ байж! Номлогчид энэ Сүмийн талаар гэр бүлийнхэнд нь ярьж өгчээ. Тэд ч Сүмд ирэхээр шийдсэн аж.

Миа эргэн тойрноо харлаа. Тэр ширээн дээр цагаан бүтээлэгтэй зүйл байхыг олж харав. Тэр бүтээлгэн доор ямар нэгэн юм байлаа.

“Бүтээлгэн доор юу байгаа юм болоо?” гэж Миа нэг номлогчоос асуув.

Хансон эгч инээмсэглээд, “Энэ бол ариун ёслол” гэлээ.

Ариун ёслол. Маш том үг байлаа. Номлогчид ээж, аавд нь энэ тухай

ярьж байсныг Миа сонссон боловч чухам юу гэдгийг нь сайн мэдэхгүй байв.

Бүгд дуу дуулав. Хоёр эрэгтэй хүн цагаан бүтээлгийг сөхлөө. Доор нь байх тавиур дээр талх байв! Миа тэднийг талх жижиглэн хувааж байхыг харлаа.

Дуу дуулсны дараа нэг эрэгтэй нь залбирал хэлэв. Бусад нь талхыг хүн болгонд түтээлээ.

“Талх Есүсийн биеийг санахад маань тусалдаг” хэмээн Гарсиа эгч шивнэв.

Миа талхнаас аваад, Есүсийг өөрийнхөө өмнө зогсож байгаагаар төсөөлөн бодлоо.



Түүний дараа дахиад залбирал хэлэв. Эрэгтэйчүүд жижигхэн аягатай усыг тавиур дээр тавин авч явж, хүмүүст тарааж байлаа.

“Ус бидэнд Есүсийн цусыг санахад тусалдаг. Тэр бидэнд хайртай учраас бидний төлөө амиа өгсөн” хэмээн Гарсиа эгч мөн шивнэв.

Миа аягатай уснаас уулаа. Тэр Есүсийг өөрт нь хэчнээн их хайртай тухай бодов. Есүс түүнийг чанга тэвэрч байгаа мэт санагдлаа.

Дараа нь Хансон эгч түүнд Есүсийн жижигхэн зургийг өгөөд, “Бид Есүсийг дурсан санаж, дагана гэдгээ мартаггүйн тулд талх, уснаас хүртдэг” гэв. Тэр инээмсэглээд, “Ариун ёслолын талаар юу гэж бодож байна?” гэж асуулаа.

Миа Есүсийн зураг руу хараад, өөрт нь төрсөн дулаахан мэдрэмжийг санахад. Тэр инээмсэглээд, “Сайхан байсан! Би Есүст хайртай” гэж хариулав. ■

Зохиогч нь АНУ-ын Калифорнид амьдардаг.

Есүс Христ ариун ёслолыг бидэнд өгсөн

Ким Вэбб Рэйд



Есүс энэ дэлхийд байх цаг хугацаа нь бараг дуусаж байгааг мэдэж байлаа. Тэрээр төлөөлөгчдөө Сүүлчийн зоогт цуглуулжээ. Есүс ариун ёслолыг тэдэнд өгөөд, Өөрийг нь үргэлж дурсан санахыг хүсэв.



Тэр залбирахаар цэцэрлэг рүү очжээ. Тэрээр хүн бүрийн бүх гэм нүгэл болоод амьдрал дахь гунигтай зүйлийн төлөө зовж шаналсан. Үүний дараа Тэрээр загалмай дээр амиа өргөсөн бөгөөд Түүнийг булшин дотор оршуулсан билээ.

Есүсийг нас барсны дараах
ням гаргийн өглөө эмэгтэйчүүд
булш руу ирэв. Булшны
хаалган дахь чулуу хөдөлж,
булш хоосон байлаа. Есүс
хаачсан бэ?



Тэр амилсан байлаа! Мари Магделен Есүсийг харсан
аж. Өөрийг нь тэнгэрт одсоны дараа сайн мэдээ заахад
төлөөлөгчдөө бэлдэхийн тулд Тэрээр тэдэн дээр зочилжээ.



Би ариун ёслол хүртэж байхдаа Есүсийг дурсан санадаг.
Тэр бидний төлөө амьдарч, амиа өргөж мөн амилсан
гэдгийг би дурсан санадаг. Иймээс би дахин амьдарч
чадна! ■



Христийн амилсны баярын сараана цэцэгс



Христийн амилсны баярын цагаан сараана цэцэгс Есүсийн амилсан гайхамшигтай сайхан өдрийг бидэнд сануулдаг. Энэ зурган дээр таван цагаан сараана цэцгийг нуусан байгаа. Цэцгийг олох бүрдээ Есүсийн талаар мэдэж авсан ямар нэгэн зүйлээ хэлээрэй.





Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын

**Ахлагч
Брус Р.Макконки
(1915–1985)**

БУРХАНЫ ХҮЧ

Итгэл бол хүч, хүч бол санваар.

Бурхан бол бүх итгэл, хүч чадал, санваарын цогц нэгдэл учраас л Бурхан юм. Түүний амьдралыг мөнх амьдрал гэнэ.

Бид хэрхэн Түүний итгэлийг олж аван, хүч чадлыг эзэмшиж, санваарыг ашиглаж байгаа нь Түүнтэй хэр адилхан болох хэр хэмжээг илэрхийлж байгаа юм. Бид бүрэн дүүрэн, бодитоор Түүнтэй адил болсон үедээ мөнх амьдралыг хүлээн авна.

Итгэл, санваар хоёр гар нийлэн ажилладаг. Итгэл бол хүч, хүч бол санваар. Бид итгэлтэй болсныхоо дараа санваарыг хүлээн авдаг. Тийн бид санваараар дамжуулан итгэлээ хөгжүүлсээр, бүх хүчийг хүлээн авсан цагт л Их Эзэнтэйгээ адил болдог.

Мөнх бус байдалд өнгөрүүлэх бидний цаг хугацааг туршилт, сорилтын цаг хэмээн тогтоосон юм. Бид энд байхдаа итгэлээ төгөлдөржүүлж, санваарын хүчинд өсөж хөгжих онцгой эрхтэй байдаг. . . .

Енохын өдрүүдэд хүмүүнийг ариун санваараар урьд хожид хэзээ ч байгаагүй ихээр төгөлдөржүүлсэн. Тухайн үед Енохын жаяг (С ба Г 76:57-г үзнэ үү) гэгддэг байсан санваар нь түүнийг болон түүний хүмүүсийг хувиргасан хүч байсан



юм. Тэд мөн итгэлтэй байж, санваарын хүчийг хөгжүүлсэн учраас хувиргагдсан.

Их Эзэн санваарыг хүлээн авсан хүн бүр итгэлээр дамжуулан дэлхий ертөнц дээрх бүх зүйлийг захирч, үндэстнүүдийн армийн өмнө үл сөхрөн, Их Эзэний өмнө алдар суу, өргөмжлөлд зогсох хүчтэй байх болно гэсэн мөнхийн гэрээг Енохтой хийсэн билээ.

Мелкизедек нь мөн адил итгэлтэй эр байсан бөгөөд “мөн түүний хүмүүс зөв шударгыг үйлддэг байж, мөн тэнгэрийг олж аван, . . . Енохын хотыг эрэлхийлдэг байв” (Иосеф Смитийн орчуулга, Эхлэл 14:34). . . .

Тийм бол санваарын сургаал гэж юу вэ? Түүнчлэн бид Их Эзэний үйлчлэгчийн хувьд хэрхэн амьдрах ёстой вэ?

Энэ нь Бурхан бидний Эцэг бүх хүч чадал, ноёрхлыг эзэмшдэг, бүх

зүйлийг мэддэг, бүх шинж чанар нь хэмжээлшгүй, гэр бүлийн нэгжид амьдардаг алдаршуулсан, төгс төгөлдөржсөн, өргөмжлүүлсэн бодгаль гэсэн сургаал болой.

Бидний Мөнхийн Эцэгийн итгэл нь төгс, санваар нь хязгааргүй учраас энэ алдар суу, төгс төгөлдөр байдал, хүч чадлын эрхэм дээд байр сууринд байгаа билээ.

Санваар гэдэг нь Бурханы хүчний нэр бөгөөд хэрэв бид Түүнтэй адил болохыг хүсвэл Түүний санваарыг эсвэл хүчийг хүлээн авч, Түүнтэй адил хөгжүүлэх хэрэгтэй.

Бид Түүний итгэл, төгс төгөлдөр байдал, хүч чадлыг буюу өөрөөр хэлбэл санваарын бүрэн байдлыг хүлээн авсан учраас итгэлээр дамжуулан материаллаг болон сүнслэг зүйлийн аль алиныг захиран, удирдах, гайхамшиг үйлдэх мөн амьдралыг төгс төгөлдөржүүлж, Бурханы оршихуйд зогсон, Түүнтэй адил болох боломжтой болдог.

Энэ нь санваарын сургаал юм бол үүнээс агуу зүйл урьд хожид ч байхгүй нь лавтай. Энэ нь итгэл, зөв шударга байдлаар дамжуулан олж авдаг хүч юм. . . .

Үнэхээр санваарын хүч байдаг бөгөөд энэ нь бидний ашиглахыг хүсдэг мөн чин сэтгэлээсээ залбирах юм бол бид өөрсдийн болон үр удмынхаа дээр байлгах боломжтой тэр хүч юм. ■

Санваарын нэгдсэн хуралдаан дээр хэлсэн “The Doctrine of the Priesthood,” үгээс эш татав, Ensign, 1982 оны 5-р сар, 32–34; үг үсгийг стандартын дагуу болгов.



**НАДАД ӨӨР ХОНЬД БИЙ,
ЭЛСПЭФ ЯНГ**

Амилсан Их Эзэн Америкт болон өөр бусад газарт байх “өөр хоньд” (3 Нифай 15:21) дээрээ зочилсон. Нифайчууд “түүний мутар дахь мөн түүний хөлөн дэх хадаасны ормуудыг тэмтэрч үзэв; мөн тэд үүнийг үйлдэж, бүгд очих хүртлээ нэг нэгээрээ явж, мөн нүдээрээ үзэж мөн гараараа тэмтэрч, мөн бошиглогчдоор ирэх болно хэмээн бичигдсэн тэр нь мөн болохыг гарцаагүйгээр мэдэж мөн гэрчлэв” (3 Нифай 11:15).

Мөн энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Патриархын адислалаа ОЙЛГОХ НЬ

Патриархын адислал бидний амьдралд болох бүх зүйлийг хэлдэггүй ч Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулан бэлдсэн агуу аз жаргалд хүргэх хувийн газрын зураг болдог.



44-р хуудас

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



58-р хуудас

ТЭД ТҮҮНИЙГ ХАРСАН

Тэрээр амилсан Христийн гэрч байсан. Бид өнөөдөр хэрхэн гэрч болон зогсож болох вэ?

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Есүс Христ ариун ёслолыг бидэнд ӨГСӨН

Бид долоо хоног бүр ариун ёслолоос хүртдэг. Гэхдээ хүүхдүүд тань яагаад гэдгийг мэдэх үү?



76-р хуудас



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ